3-рбүлэг	Баруунтуруун, Бөхмөрөн, Давст, Зүүнхангай, Зүүнговь, Малчин, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Өндөрхангай, Сагил, Тариалан, Түргэн, Тэс, Улаангом, Ховд, Хяргас, Цагаанхайрхан	21112.9	<p>Хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 20 см, ялзмаг агууламж хөнгөн шавранцар хөрсөнд 2,2 %, 100 грхөрсөндхөдөлгөөнт фосфор (P_{205}) 3.8 мг , солилцохкали (K_2O) 18 мг байна. Хөрсний орчин карбонатгүй үедээ рН=7,0 -7,75 байх ба карбонатын илэрц гол төлөв В-үе давхаргадаа ажиглагдаж 10%-ийн давсны хүчлийн уусмалд буцална.</p> <p>Хөрсний шингээгдсэн сууриудын нийлбэр 100 г хөрсөнд 14.9-24.9 мг-экв байх ба түүний дотор калцийн агууламж 9.7-18.6 мг-экв-ийг эзэлнэ. Зүсэлт хийхэд хүрэн өнгөтэй, манай орны хуурай нөхцөлд голдуу тоосорхог бөөмөрхөг бүтэцтэй, доод үе давхаргадаа бага зэрэг чулуурхаг, ургамлын үндсээр дунд зэрэг, шилжилт тод, ихэвчлэн элсэнцэр, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна. Дээрхээс үзэхэд уг хөрс нь үржил шимийн хувьд хөдөө аж ахуйн таримал тариалахад тохиромтой боловч ашиглалтын явцад дээрх хөрс уг шинж чанараа тодорхой хэмжээгээр алдсан нь дамжиггүй. Хөрсний дээрх шинж чанараас харахад хөрсний үржил шимээр ядуу, салхины элэгдэл эвдрэлд өртөмтгий байх тул хөрс хамгаалах технологийг чанд мөрдөж тариалан эрхлэх нь чухал юм.</p> <p>Аллювийн нугын хөрсний ялзмагт үе давхарга төдийлэн зузаан биш 13-42 см, голдуу цайвардуу хүрэн өнгөтэй, бүх үе давхарга нь хоорондоо эрс ялгаатай үелсэн маягтай. Дээд үе давхаргадаа ихэвчлэн хөнгөн шавранцараас элсэнцэр, доошлох тутам наанги шавар багасч чулууны хэмжээ томорно. Ялзмаг агууламж 1.6–4.0 %, хөрсний орчин саармагаас шүлтлэг 6.8-7.43 байна. 100 г хөрсөнд шингээгдсэн сууриудын нийлбэр 31.3 мг/экв байх ба түүний ихэнхи хэсгийг кальци эзэлнэ. Хөдөлгөөнт фосфор, калийн агууламжаар дунд зэрэг, фосфор 3.5 мг, кали 14 мг байна. Дээрхээс үзэхэд тус аймагт тархсан хөрс хөрсний ялзмагт үеийн зузаан, ялзмаг агууламж, шим тэжээлийн бодисын хангамжаар тийм ч муугүй бөгөөд оновчтой агротехникийн бодлого явуулахад арвин ургац авах бүрэн боломжтой.</p>
4-рбүлэг	Давст, Малчин, Өлгий, Өмнөговь, Сагил, Тариалан, Улаангом	2090.1	<p>Морфологи бичиглэлүүдээс үзэхэд гол төлөв ялзмагт үе нь цайвардуу хүрэн өнгөтэй, гүн нь 15 см-ийн орчим ,үрлэн бүтэцтэй, ургамлын үндсээр тийм ч баялаг биш, хөрсний 15 см-ээс давсны хүчлийн уусмалд буцалж байгаа нь хөрс үүсгэгч эх чулуулаг нь карбонатлаг болохыг харуулж байна. Хөрсний шингээгдсэн сууриудын нийлбэр 100 г хөрсөнд 28.0мг-экв байх ба түүний дотор калцийн агууламж 50-аас дээш хувийг эзэлж байгаа нь хөрсний бүтцэнд сайн нөлөө үзүүлнэ. Ялзмагт үе давхаргадаа ялзмагийн агууламж 1.1 -2.8 % хүрэх ба харин азотын хангамжаар төдийлэн сайнгүй, хөрсний хөдөлгөөнт фосфор, калиар дунд зэрэг хангагдсан, 100г хөрсөнд 1.8 - 2.2мг фосфор, 12-20.5 мг кали агуулна. Механик бүрэлдэхүүний хувьд ихэвчлэн элсэнцэр болон хөнгөн шавранцар байна.</p>

Хүснэгт №2.52. Агро үйлдвэрлэлийн зөвлөмж

Агро үйлдвэрлэлийн бүлэг	Зөвлөмж
2-р бүлэг	<p>Энэ бүлгийн хөрсний үржил шимийн түвшин харьцангуй сайн, органик бодисын агууламж ихтэй байх онцлогтой. Харин механик бүрэлдэхүүний хувьд физик шаврын агуулагдах хувь их байх тул ургамал ургалтын хугацаан дахь хөрс боловсруулалтыг технологийн дагуу сайн хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн хөрсний үе давхаргын зузаан газрын гадаргуу болон бусад хүчин зүйлээс хамааралтай ихээхэн хэлбэлзэлтэй байх тул тухайн талбай бүрд хөрсний судалгааг гүйцэтгэж, үе давхаргын зузааныг нь тогтоож хагалах гүн, тарих таримлын төрлийг сонгох нь чухал. Увс аймгийн хэмжээнд нийт 27674.3 га талбай байгаа бөгөөд тухайлбал Баруунтуруун суманд 27348 мян. га талбай 2-р бүлгийн хөрсний нөөцтэй байгааг бүрэн ашиглаж буудайн үйлдвэрлэл эрхлэхэд нэг га-аас улсын дунджаар 12цн ургац авна гэж тооцвол 328176цн ургац бүрдүүлэх боломжтой байна. Тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэхэд бордох, хог ургамал, өвчин хортонтой тэмцэх, хөрс хамгаалах арга хэмжээг иж бүрэн шинжлэх ухааны үндэстэй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ бүлгийн хөрсийг усалгаатай тариаланд ашиглахад тухайн талбайд хөрсний ус-физикийн судалгааг нарийвчлан хийж, усалгааны норм, горимыг чандлан барих нь зүйтэй. Хөрсний үе давхаргын зузаан их, хүнд механик бүрэлдэхүүнтэй тохиолдолд ус барих чадвар сайн байх тул усалгааг ахиу нормоор цөөн услах нь зүйтэй юм. Усалгаатай нөхцөлд 1га-аас авах ургацын хэмжээ эрс нэмэгддэг нь таримал ургамал хөрснөөс тэжээлийн бодисыг авч ашиглаж байгаатай холбоотой бөгөөд тэр хирээр хөрсний үржил шим алдагдана. Өнөөгийн байдлаар дэлхийд тариалах талбайн 17 хувийг усалгаатай тарьж байгаа боловч нийт ургацын 50 гаруй хувийг усалгаатай талбайгаасаа авч байгаа нь усалгаа эдийн засгийн болоод талбай ашиглалтын ямар их ач холбогдолтой болохыг харуулж буй хэрэг юм. Гэвч асуудалд болгоомжтой хандан шинжлэх ухааны үндэстэйгээр хэрэгжүүлэхгүй бол хөрс эвдрэлд нэрвэгдэх, үржил шимээ алдан доройтож, ургац өгөх чадваргүй болдог нь дэлхийн олон улс оронд нотлогдсон илээ. Ийм байдлаар хэдэн сая га газар ашиглагдахгүй болсны дотор Оросын холбооны улс, Хятад, Дундад Азийн орнууд, Энэтхэг зэрэг олон улс үндэстэн ихээхэн хэмжээний талбайнхаа хөрсний үржил шимийг алджээ. Иймд энэ бүлгийн хөрсийг усалгаатай тариаланд ашиглахдаа хөрсний үржил шимийг хамгаалах асуудалд онцгой анхарах, налуужилтыг усалгаа хийх аргыг сонгохдоо тооцох нь зүйтэй. Усалгаатай нөхцөлд буудайн ургац 20цн/га-аас дээш байж эдийн засгийн хувьд үр ашигтай байдаг гэсэн тооцоо, судалгаа байна. Энэ бүлгийн хөрс тархсан сумдуудад дулааны бүслүүрээр сэрүүн бүсэд багтах бөгөөд идэвхитэй дулааны нийлбэр 2000-2600, цочрол хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110-140 хоног, харин чийг хангамжийн хувьд чийгшлийн бүсээр чийгхүрэлцээгүй бүсэд багтах ба нэн хуурай, хуурайвтар, гандуу, гандуувтар дэд бүсүүдэд багтана. Иймд бүс нутагт зохицсон сортыг тариалах, усалгаатай тариаланг шинжлэх ухааны үндэстэй эрхлэх нь чухал юм.</p>
3-р бүлэг	<p>Энэ бүлгийн хөрс нь үржил шимийн түвшин дундаас доогуур, зарим газарт хайрга, чулууны эзлэх хувь ихтэй, ихэвчлэн хөнгөн механик бүрэлдэхүүнтэй байх онцлогтой. Иймд хөрс хамгаалах арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал талбай бүрийн хөрсний агро химийн шинжилгээг нарийвчлан хийж бордоог шинжлэх ухааны үндэстэй хэрэглэх, салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах хэрэгтэй. Үе давхаргын зузаан ихээхэн хэлбэлзэлтэй байх тул талбай бүрийн хөрсний судалгааг хийж хагалах гүн, тариалах таримлыг сонгох нь зүйтэй. Увс аймгийн ихэнх сумдад энэ бүлгийн хөрс тархсан байгаагаас үзэхэд үржил шимээр ядмаг, эзмэг хөрсөн бүрхэвчтэй гэж ерөнхийд нь ойлгож болох бөгөөд ийм нөхцөлд газар тариалангийн үйлдвэрлэлд хөрс сайжруулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх, технологийг чандлан мөрдөх нь газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх боломж бүрдэнэ. Энэ бүлгийн хөрс нийт 21112.9га газарт тархсан бөгөөд хамгийн их тархалттай Баруунтуруун суманд 9912,7га хөрсний нөөц байгаа бөгөөд үр тарианы үйлдвэрлэлд бүрэн ашиглана гэвэл нэг га-аас улсын дунджаар 12цн ургац бүрдүүлнэ гэж тооцвол 118952.4цн, харин хамгийн бага тархалттай Давст суманд 2.5га талбайн нөөц байгааг бүрэн ашиглаж төмсний үйлдвэрлэл эрхлэхэд улсын дунджаар 140 цн ургац бүрдүүлнэ гэж тооцво лнийт 350 цн төмс хураах боломжтой. Энэ бүлгийн хөрсийг усалгаатай</p>

	<p>тариаланд ашилахад ихээхэн эмзэг байх бөгөөд тухайн талбайд хөрсний ус–физик шинж чанарыг нарийвчлан судалж услах норм, горимыг тогтоох, хөрс усны элэгдэлд өртөх, шим тэжээлийн бодисоор ядуурч үржил шимээ алдах, давсжих зэрэг процесс явагдах боломжтой тул урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа хөрсний тэжээлийн бодисын хангамж төдийлөн сайн биш тул бордоог зохих нормоор хэрэглэх нь зүйтэй. Усалгаатай нөхцөлд усалгаагүйгээс бордоог ахиу нормоор хэрэглэдэг бөгөөд хөрсний агро химийн шинжилгээнд тулгуурлан бордооны тун, нормыг тогтооно. Энэ бүлгийн хөрс тархсан сумдуудад дулааны бүслүүрээр сэрүүн бүсэд багтах бөгөөд идэвхитэй дулааны нийлбэр 2000-2600, цочрол хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110-140 хоног, харин чийг хангамжийн хувьд чийгшлийн бүсээр чийг хүрэлцээгүй бүсэд багтах ба нэн хуурай, хуурайвтар, гандуу, гандуувтар дэд бүсүүдэд багтана. Иймд бүс нутагт зохицсон сортыг тариалах, усалгаатай тариаланг шинжлэх ухааны үндэстэй эрхлэх нь чухал юм.</p>
4-рбүлэг	<p>Энэ бүлгийн хөрс нь үе давхаргын хувьд нимгэн, үржил шимийн түвшин дундаас доогуур, хайрга, чулууны агууламж ихтэй тул газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэхэд технологийг чанд мөрдөх, хөрс хамгаалах арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн түүнчлэн карбонат агуулалтын гүн нилээд дээр, зарим газарт өнгөнөөсөө карбонаттай байх тохиолдол их байх тул хөрсний уусмал дахь давсны агууламж ихсэж ургац хязгаарлах сөрөг талтай. Иймд хөрсийг давсжихаас урьдчилан сэргийлэх, давстай хөрсийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хөрсний агро химийн шинжилгээг талбай бүрээр хийлгэх шаардлагатай. Хөрсний үе давхаргын хувьд нимгэн газруудад төмс, хүнсний ногоо тариалах боломжгүй бөгөөд үр тариа болон тэжээлийн ургамал тариалахад тохиромжтой юм. Энэ бүлгийн хөрс нь Увс аймагт 2090.1га-д тархсан бөгөөд энэ хөрсний нөөцийг бүрэн ашиглаж тэжээлийн ургамал тариалахад улсын дунджаар 280цн ургац бүрдүүлнэ гэж тооцоход 585228цн тэжээлийн ногоон массын ургац хураан авах боломжтой. Энэ бүлгийн хөрсийг усалгаатай тариаланд ашиглахад давсжих, усны элэгдэлд өртөх, шим тэжээлийн бодисоор дутагдах зэрэг сөрөг үр дагавар гарах магадлал өндөртэй. Иймд тухайн талбай бүр хөрсний ус–физикийн шинж чанарын судалгааг нарийвчлан хийж усалгааны тун нормыг тогтоох, хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа бордоог шинжлэх ухааны үндэстэй хэрэглэх, хүчиллэг бордоо хэрэглэх нь зүйтэй. Энэ бүлгийн хөрс тархсан сумдуудад дулааны бүслүүрээр сэрүүн бүсэд багтах бөгөөд идэвхитэй дулааны нийлбэр 2000-2600, цочрол хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110-140 хоног, харин чийг хангамжийн хувьд чийгшлийн бүсээр чийг хүрэлцээгүй бүсэд багтах ба нэн хуурай, хуурайвтар, гандуу, гандуувтар дэд бүсүүдэд багтана. Иймд бүс нутагт зохицсон сортыг тариалах, усалгаатай тариаланг шинжлэх ухааны үндэстэй эрхлэх нь чухал юм.</p>

Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой үр ашигтай эрхлэхэд үйлдвэрлэлийн технологийн нарийн мөрдөх, хөрс сайжруулах болон хамгаалах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх нь арвин ургац авах гол үндэс болно. Оросын холбооны улсад хийсэн судалгаагаар шим тэжээлийн бодисоор баялаг хар шороон хөрсийг ч бордоход ургац нэмэгдсэн дүн гарсан байдаг. Манай орны хувьд хөрсөн бүрхэвч ихээхэн эмзэг, үржил шимээр ядмаг тул хөрс сайжруулах, хамгаалах арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй, тогтмол, зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Иймд хөрс хамгаалах зарим нэг аргууд болон бодоо хэрэглэх тун норм, өвчин хортонтой тэмцэх аргачлалыг товч дурьдсан болно.

Хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах арга хэмжээ

1. Ойн зурвас байгуулах. Салхины дээд талд салхины хүчийг бууруулах, талбайн чийгийн ууршилтийг багасгах, өвөл цас тогтоох зорилгоор ойт хээрт 3 эгнээ, хээрт 4 ба түүнээс дээш эгнээгээр ойн зурвасыг байгуулна. Энэ нь шигүү зурвас бөгөөд сийрэг

зурвас гэж бас байна. Сийрэг зурвасыг нэвтэрсэн салхи, зурвас дээгүүр давж ирсэн салхитай мөргөлдөж хүч нь саардаг.

2. Хөрсийг хавж боловсруулах. Хуурай уур амьсгалтай манай орны нөхцөлд хөрсийг аль болох хөндөхгүйгээр, ургамлан бүрхэвчийг устгахгүйгээр /уриншийн боловсруулалтын эцэст 1м² талбайд 40ш гуурс үлдээх/ хөрс боловсруулалтыг аль болох цөөн оновчтой хийх . Үүнд хавж боловсруулах СЗС-2.1, СЗП-3.6, КПШ-5 зэрэг эрозийн техникийг өргөн ашиглах.

3. Зурваслан тариалах. Салхины хөндлөн чигт хөрс хөнгөн, элэгдэж эвдэрсэн бол 30-50м, элэгдэж эвдрээгүй хүндэвтэр хөрстэй бол 50-75м-ийн өргөнтэйгээр зурваслан тариалах. Ялангуяа томоор талбайг эсгэсэн тохиолдолд зайлшгүй зурваслан тариалах шаардлагатай.

4. Шим ба эрдэс бордоогоор бордох. Үржил шимээр ядуурч доройтсоноос хөрс хийсч элсжих процесс түргэдэг учир хөрсний бүтэц, үржил шимийг сайжруулахын тулд үр тарианд N60P40K40 /үйлчлэх бодис/ , төмс, хүнсний ногоонд N90P60K60 гэсэн дундаж тунгаар эрдэс бордоог хэрэглэхийн дээр орон нутгийн бордоо бууцыг үр тарианд 1га-д 20 тн, төмс, хүнсний ногоонд 20-40 тн хийж өгөх хэрэгтэй. Гэхдээ бууц нь ялзарсан бууц байх шаардлагатай.

5. Сүрэл хэрчиж цацах.Талбайд хураалт хийсэний дараа Сүрэл хэрчигч ФУН-5 төхөөрөмжийг ашиглан комбайнаар 1га-д 6-8цн сүрэл цацаж өгөх нь хөрсөнд бордоо болохоос гадна салхинаас хамгаалах, чийг барих онцгой ач холбогдолтой байдаг.

6. Ногоон бордоот уринш.Үржил шимээр ядуурч, элжсэн талбайд ногоон массыг бий болгоод буцааж түүнийг хөрсөнд булах нь үржил шимийг дээшлүүлж хөрсжүүлэх нэг арга болдог. Таримлыг сонгохдоо хөрсөнд шим тэжээлийн бодисыг хамгийн ихээр хуримтлуулж чадах таримлыг ногоон бордуурт сонгох шаардлагатай. Манай орны нөхцөлд хошоон өвс /донник/, царгасыг /люцерна/ өргөн ашигладаг.

7.Олон наст тариалах.Хүчтэй эвдрэлд орсон талбайг эргэлтээс түр болон бүр чөлөөлж олон наст үет, буурцагт ургамлыг тариалах нь хөрс сайжруулах нэг чухал арга байдаг.Манай орны нөхцөлд царгас, хошоон өвс, хошоонгор, ерхөг, хиаг, өлөнгө, согоовор зэрэг үет болон буурцагт ургамлыг 1га-д 6-10ц байхаар тооцож тариалдаг.Эвдэрч доройтсон талбай уг талбайнхаа онцлогоос хамааран 8-15 жилийн хугацаанд нөхөн сэргэдэг.

Хөрсийг усны элэгдэл эвдрэлээс хамгаалах

Газрын гадаргын хэвгий байдал, гол мөрний сав газар хэтэрхий ойр талбайг хагалснаас талбай усны шугаман /гуу жалга/ болон нэлэнхүй эвдрэлд орж гуу жалга үүсэх, намагжих явдал хааяа тохиолддог. Үүнд:

1. Шугаман эвдрэл үүссэн тохиолдолд: газрын гадаргын налууд хөндлөн 12-15м – ийн зайтайгаар хөрсийг 50 см гүн зүсэж боловсруулах.
2. Газрын гадаргын хэвгийг тогтсон усыг талбайгаас шуудуу татаж зайлуулах.
3. Нэлэнхүй эвдрэлд орж намагжсан тохиолдолд мөн илүүдэл усыг газрын гадаргын налууг харгалзан нам талруу нь суваг шуудуу татаж урсгах.

Тариалангийн талбайд тархсан хог ургамал, хортон, шавьж, мэрэгчидтэй тэмцэх

Тус аймгийн үр тариа, төмс, хүнсний ногооны талбайд зонхилон тохиолдох өвчин, хортон шавьж, мэрэгчид болон хог ургамлыг устгах зарим нэг бодисын зааварчилгааг толилуулж байна.

Үр тарианы талбайд хог ургамлаас татар сагаг, тарианы хар будаа, чөдөр тарна, үхэр тарна, мөлхөө хиаг, хонгио хошуу будаа, лууль, бөөнөг хамхуул, үнэгэн сүүл, г.м элбэг тааралдана. Мөн хортон мэрэгчидээс шар чичүүл, өвчинөөс шугаман зэв, тоост харуу бага зэрэг үзэгдэнэ.

Төмс, хүнсний ногооны талбайд байцааны хивэн, нугын бор эрвээхэй, жант цох, хөнөөлт бясаа, царцаа, хачиг г.м хортон шавьж түгээмэл тохиолдоно.

Хүснэгт №2.53. Ургамал хамгаалах бодис хэрэглэх заавар

Бодисын нэр	1га-д хэрэглэх тун л/га, кг/га	Хэрэглэх таримал	Хэрэглэх өвчин, шавьж, хог ургамал, мэрэгчид	Хэрэглэх арга, хугацаа, онцлог	Хэдэн удаа хэрэглэх
Децис	0.25	Буудай, арвай	хөнөөлт бясаа, бөөс, цагаалж, тарианы цохууд, үрийн бүгэг,	ургалтын үед 1га-д 100 л ажлын уусмал бэлдэж шүрших.	1-2
	0.25-0.5	Хүнсний ногоо	нугын бор эрвээхэй	Авгалдайн хөжлийн эхний үед 1га-д 100л а/уусмал	1-3
	0.3	Байцаа	хивэн, бөөс, цагаан эрвээхэй	Ургалтын хугацаанд 1га/100л	1-3
	0.1-0.15	Төмс	жант цох ба бусад	Цох гарсан үед 1га-д 100л а/шингэн	1-3
Фуроре супер	0.8-1.2	үр тариа, манжин, лууван, байцаа, сонгино	Хонгио амуу, гагадай, хар будаа	Ургалтын үед хог ургамлын 2 навчтай болох үеэс 1га-д 50-100л а/уусмал	1
Пума супер	0.8-1.2	буудай	Хонгио амуу, хоног будаа, хар будаа	Мөн ижил	1
Зенкор	0.7	Улаан лооль	1наст үет ба өргөн навчит хог ургамал	Таримлын 2-4 навчтай байх үед 1га-д 100л	1
2.4-ийн нэгдлүүд цууны хүчлийн давс, эфирууд	1.5-2.0 0.8-1.5	үр тариа	өргөн навчит хог ургамал/лууль г.м/	1га-д 25-100л а/уусмал шүрших, 2.4Д давсыг 1.5-2.0, эширийг 0.8-1.5л/га тунгаар	1
Суми -8	1.5-8.0	буудай	Хатуу ба тоосон харуу, үндэсний ялзрал	1т үрэнд 10л шингэн хэрэглэнэ, үрийг тарихаас 7-30 хоногийн өмнө ариутгана	1
Бромодилон	14мл/га	буудай	Шар чичүүл болон бусад мэрэгчид	Будаан өгөш бэлдэж 1га-д 1.5-3.0кг цацах	2
Сумицидин20	0.3	Төмс, байцаа, лууван, манжин жимс	Жант цох, бүгэг, байцааны хивэн, ялаа ба бусад	1га-д 50-100л шингэн хэрэглэх	1-3
Кинмикс 5	0.25-0.5	манжин	Мрэгч бүгэг, бөөс,	1га-д 50-100л шингэн	1-2

			шөвгөлж бусад	хэрэглэх	
Раундап	2-3 4-6 2-3	Төмс Уринш байцаа	1наст үе болон өргөн навчит х/ур	Төмс соёолохоос 2- 5хоногийн өмнө 1га-д 200л шингэн, уриншинд 1га-д 25- 100л шингэн	1
Сандофон	2.0	Төмс, лооль	Фиофтор, макроспориоз, переноспориоз өвчинд	Ургалтын үед 1га-д 200л шингэн бэлдэх	2-4
Маврик	0.6-0.12	Алим жимс, жимсгэнэ	Алимны үрэлж эрвээхэйн авгалдай, хачиг	Ургалтын үед 1модонд 2000мл шингэн бэлдэх	1-2

Жич: Сүүлийн үед хлорофос, керлин мэт бодисуудыг хэрэглэхээ больсон болохыг анхааруулж байна.

Хөрсний шим тэжээлийн бодисын хангалтын зэрэглэлээс хамааруулан эрдэс ба шим бордоо хэрэглэх

Хөрсний хөдөлгөөнт элементүүд болох ниратазот, хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлсон судалгааны тоо материал, үзүүлэлтийг авч ашиглав. Эдгээр үзүүлэлтийг шим тэжээлийн бодисын хангалтын зэрэглэлээр /Усалгаатай газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, лабораторийн маш бага, бага, дунд, хангалтай, сайн хангалттай гэсэн 5 баллын зэрэглэл, мг/кг шороонд, 0-20см гүн/ авч үзээд тухайн хөрс аль элементээр ямар зэрэглэлд багтаж байгааг тогтоосны үндсэн дээр тухайн хөдөө аж ахуйн тарималд тохирсон тунгаар бордох юм .

Хүснэгт №2.54. Хөрсний шим тэжээлийн бодисын хангалтын зэрэг мг/кг шороонд /0-20см гүнд/

Шим тэжээлийн бодисын төрөл	Хангалтын зэрэг				
	Маш бага	Бага	дунд	Хангалттай	Сайн хангалттай
Нитратын азот	< 3.5	3.6-8.0	8.1-11.0	11.1-14.0	> 14
Хөдөлгөөнт фосфор	< 50	51-80	81-130	131-250	> 251
Хөдөлгөөнт кали	< 90	91-120	121-160	161-220	> 221

Жишээ нь: 15/250 га талбайн Нитратын азот кг шороонд 5.6, фосфор 98 мг, кали 162мг байна гэж үзвэл уг талбайн хөрс ургамалд ашиглагдах нитратын азотоор бага, хөдөлгөөнт фосфороор дунд зэрэг хангалттай, калиар хангалттай байна гэсэн үг. Тэгвэл усалгаагүй нөхцөлд үр тариаг бордох тунг дараахи байдлаар N60P30K0–бордох шаардлагагүй гэж тогтооно.

Төмс, хүнсний ногооны талбайд 1га-д 20-40тн бууцаар бордсон тохиолдолд дараахи эрдэс бордооны тунг хэрэглэнэ /хүснэгт 2.50/.

Усалгаагүй үр тарианы талбайг уриншлах үед дээрхи тунгаар, усалгаатай үр тариа болон төмс, хүнсний ногооны талбайг жил бүр тариалахдаа бордоно.


Хэрэв үр тарианы дараа төмс, хүнсний ногоо, тэжээл тариалах бол сүүлийн тарималд шаардлагатай тунгаар тооцож бордоно.

Хүснэгт№2.55. Хөрсний шим тэжээлийн бодисын хангалтын зэргээс хамаарч хөдөө аж ахуйн таримлыг бордох тун, 1га-д кг /үйлчлэх бодис/.

Таримлын нэр	Хангалтын зэрэг		
	бага	дунд	сайн
1. Азотын бордоо			
үр тариа, усалгаагүй	60	40	40
усалгаатай	120	80	60
Төмс	80	60	40
Эртийн байцаа	200	160	120
Оройн байцаа	120	100	70
Хүнсний ногоо	80	60	40
Ногоон тэжээл, дарш	120	100	50
2. Фосфорын бордоо			
үр тариа, усалгаагүй	40	30	15-20
усалгаатай	80	50	15-20
Төмс	80	60	40
Эртийн байцаа	200	100	60
Оройн байцаа	120	100	45
Хүнсний ногоо	80	70	60
Ногоон тэжээл, дарш	150	120	60
3. Калийн бордоо			
үр тариа, усалгаагүй	40	30	Бордохгүй
усалгаатай	80	60	Бордохгүй
Төмс	120	100	80
Эртийн байцаа	160	100	60
Оройн байцаа	100	80	60
Хүнсний ногоо	90	60	60
Ногоон тэжээл, дарш	150	100	70

Дээр дурьдсан хөрс хамгаалах, хог ургамал хортон шавьж устгах, эрдэс бордоо хэрэглэх заавар зөвлөмжийг өөрийн талбайн онцлог, Хөдөө аж ахуйн тарималд зохицуулан хэрэглэвэл зохино.

Орон нутгаас шинээр газар тариалан хөгжүүлэх санал бүхий газрын үнэлгээ, цаашид хэргэжүүлэх шаардлагатай арга хэмжээ



Зураг №2.7. Шинээр газар тариалан хөгжүүлэх санал бүхий газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Газар тариалан хөгжүүлэх санал бүхий газруудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хүснэгт №2.56.-т үзүүлэв.

Хүснэгт №2.56. Газар тариалан хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ

№	Сумын нэр	Санал	Шаардлагатай хөрөнгө оруулалт
1	Улаангом	Одоо байгаа тариалангийн талбайгаа бүрэн ашиглах	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
2	Түргэн	Хойд хөвийн тариг усалгаатай газар тариалангийн бүс болгох	Услалтын системийг засварлах
3	Ховд	Ховд голын хөндийн тариалангийн талбайг ашиглах	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
		Баяртай сайгт тэжээлийн ургамал тариалах	Усны насос, Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх

		Харгайн голд тэжээлийн ургамал тариалах/голын уснаас услах боломжтой/	Усны насос, Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
4	Өндөрхангай	Хуучин нэгдэл байх үед тэжээлийн ургамал тариалж байсан газрыг дахин сэргээж тариалангийн газар болгох боломжтой. /атаршсан талбай/	Усалгаатай болгох
5	Сагил	Боршоо нүцгэн эдгээр газруудад жимс жимсгэнэ тариалах боломжтой бүс	Усалтын систем байгуулах
		Зуун модны газарт газар тариалан, усалгаатай хадлангийн бүс болгох	Усалтын систем байгуулах
6	Тэс	Нарийнаа голын дундуур төмс ногоо тариалах боломжтой. Мөн жимстын үзүүрээс зүүн талд тариалах боломжтой байна.	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
7	Цагаанхайрхан	Одоо байгаа тариалангийн талбайгаа бүрэн ашиглах	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
8	Давст	Одоо байгаа тариалангийн талбайгаа бүрэн ашиглах. 860 га талбайн усалтын системийг сэргээн ашиглах нь зүйтэй.	Усалтын системийг засварлах
9	Наранбулаг	Тээлийн боомд фремрийн аж ахуй болон газар тариалан хослуулан хөгжүүлэх	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
		Шивээн голд усалгаатай ГТ хөгжүүлэх/хүнсний ногоо, тэжээлийн ургамал/	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
10	Завхан	Сэтэртийн хойд газарт хүнсний ногоо болон жимс жимсгэнэ, мод зэргийг тарьж эхэлсэн үр дүн сайн байгаа цаашдаа тариалангийн бүс болгохоор төлөвлөж байна.	Завхан голд урсацын тохируулга хийх толгойн байгууламж байгуулах, усалтын систем байгуулах
11	Өлгий	Сондуултын голын усалгааны систем, Хар ус нуур газар тариалан хөгжүүлэх, хадлан тэжээлийн аж ахуй хослуулан хөгжих боломжтой	Сондуултын усны далан, усалтын системийг сэргээх хөв цөөрөм байгуулах
		Боомын голд усалгаатай газар тариалан хөгжүүлэх	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
12	Өмнөговь	Талын толгой орчимд газар тариалангийн бүс, жимс жимсгэнэ тариалдаг.	Орлогын голын усалтын системийг сэргээх
13	Бөхмөрөн	Бөхмөрөн голоо дагаад газар тариалан болон тэжээлийн ургамал тариалах хөгжүүлэх бүрэн боломжтой.	Тариалан эрхлэлтийг дэмжих, зээл тусламж үзүүлэх
14	Тариалан	Одоо бүртгэлтэй газар тариалангийн газраасаа өөр газар эрхлэх боломжгүй. Усалтын системээс болж атаршсан 1000 га газар байна. Бүрэн ашиглахын тулд усалтын системийг сэргээн засварлах	Усалтын системийг засварлах
15	Хяргас	Хөтөнгийн орчимд хуучин атаршсан газарт тэжээлийн ургамал тариалах боломжтой.	Усалтын системийг засварлах
16	Малчин	Улаан булагт газар тариалан буюу төмс хүнсний ногоо тариалдаг. 650 га талбайн усалтын системийг сэргээн ашиглах нь зүйтэй байна.	Усалтын системийг засварлах
17	Баруунтуруун	1500 га-д хуучин атаршсан газруудыг эргэн ашиглах	Усалтын системийг засварлах
18	Зүүнхангай	Хуучин атаршсан газар ашиглах	Усалтын систем байгуулах
19	Зүүнговь	Газар тариалангийн чиглэлээр санал байхгүй	


2.8. Отрын бүс нутгийн ашиглалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөө

2.8.1. Отрын бүс нутгийн ашиглалт

Газрын тухай хууль болон Улсын их хурлаас баталсан "Монгол мал" үндэсний хөтөлбөрт нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг улс, аймаг, сумын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авч, цаг хүндэрсэн үед ашиглах талаар заасан байдаг.

Аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар нийт 28.9 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, тус отрын бэлчээр нутгийг "Ачит нуур" гэж нэрлэн Монгол улсын Засгийн газрын 2012-12-08 ны өдрийн 158-р тогтоолоор Улсын тусгай хэрэгцээнд авсан байна.

Ингэснээр Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг дэвсгэр дэх 8.0 мянган га, Увс аймгийн Ховд суман дахь 20.9 мянган га газар аймаг дундын отрын бэлчээр нутаг болсон байна.



Зураг №2.8. Отрын бүс нутгийн зураг

Одоогын байдлаар Увс аймаг Ховд сумын нутаг Ачит нуур орчмын 21059.1 га-д Улсын чанартай аймаг дундын оторын бүс нутаг байгуулагдаад байна. Отрын бүс нутгийн Захиргаа болон бусад бариллага байгууламж одоогоор баригдаж эхлээгүй байлаа.

Хүснэгт №2.57. Отрын бүс нутгийн тохиромжтой байдлын үнэлгээ

№	Сумын нэр	Газрын нэр	Зураг дээрхи дугаар	Ургамлын индекс	Бэлчээрийн тохиромжтой байдал				Талбай /га/
					Зун-намар	Өвөл-хавар	Хадлан	Малын төрөл	
Аймаг дундын отрын бүс нутаг									
1	Ховд	Ачит нуур	4	У-VI-1-8	2	1		Бог, тэмээ, Адуу	8281.3
				У-VI-1-9	3	1			5047.9
				Н-I-2-2	2	2	1		1180.1
				Н-III-3-1	3	2	1		257.9
				ЦХ-I-1-2	1	2			6291.8
								21059.1	
Сум дундын отрын бүс нутаг									
2	Өмнөговь	Намирийн түнгэ	2	У-IV-2-15	1	3		Бүх төрлийн малд тохиромжтой	261.8
				Х-II-2-8	1	2	3		115.1
				Н-III-3-1	3	2	1		66.8
				Н-III-3-2	3	1	2		15.7
				Н-III-3-5	2	2	2		11094.2
				ЦХ-I-1-5	1	2			94.0
								11647.4	
3	Завхан	Үнэгэд	3	У-V-1-2	1	2		Бог мал, Тэмээ	2936.7
				Х-II-2-2	1	2			27.8
				ЦХ-I-1-8	1	2			804.0
								3768.4	
4	Бөхмөрөн	Ачит нуур	5	У-VI-1-8	2	1		Бүх төрлийн малд тохиромжтой	1451.7
				Н-I-2-2	2	2	1		14785.1
				Н-III-1-3	2	1	3		235.5
				ЦХ-I-1-8	1	2			261.1
								16733.4	
Сумын отрын нөөц нутаг									
5	Баруунтуруун	Эрдэнэтолгой	1	У-V-1-4	2	1	4	Бүх төрлийн малд тохиромжтой	1548.8
				Х-II-2-5	1	1			5820.7
				Х-III-1-2	3	1			142.5
				Х-III-2-1	2	1	3		4945.0
								12457.0	
6	Давст	Зүүн тэрмис	6	Х-I-2-13	1	2		Бүх төрлийн малд тохиромжтой	666.9
				Х-II-2-2	1	2			9987.4
								10654.3	
7	Улаангом	Дунд тэрмис	7	Х-I-2-13	1	2		Бүх төрлийн малд тохиромжтой	157.4
				Х-II-2-2	1	2			7147.2
								7304.6	
8	Өлгий	Хожгор, Аргалант, Ширэн хан	8	У-VI-2-2	2	1		Бүх төрлийн малд тохиромжтой, үхэрт дунд зэрэг	3859.5
				У-IV-2-5	1	3			12.0
				Х-II-4-1	1	1			1332.0
				ЦХ-I-1-2	1	2			569.9
				ЦХ-I-1-8	1	2			4766.8
				ЦХ-I-1-15	2	1			1290.7
				ЦХ-I-2-3	1	2			403.1
				ЦХ-I-2-4	1	2			27732.8
Ц-I-1-8	2	3		4813.3					
								44780.1	

2.8.2. Отрын бүс нутгийн менежмент

Увс аймгийн отрын бүс нутгийн байршлыг 2.6-р зурагт, отрын бүс нутгийн тохиромжтой байдлын үнэлгээг 2.52, 2.53-р хүснэгтүүдээр харууллаа. Аймгийн иргэд, малчид, сум багийн удирдлагуудын санал, уламжлалт отрын нутгийг харгалзан тус аймгийн хэмжээнд Өмнөговь сумын Намирын түнгэд 11647.4 га, Завхан сумын Үнэгэдэд 3768.4 га, Бөхмөрөн сумын Ачит нуурын савд 16733 га бүгд 42.1 мян га-д 7957 хонь толгой мал өвөлжүүлэх сум дундын, Баруунтуруун, Давст, Улаангом, Өлгий зэрэг сумын нутагт нийт 75.2 мян га нутагт 15.4 мян хонь толгой мал багатах даацтай сумын буюу баг дундын отрын бүс нутаг зохион байгуулахаар төлөвлөлөө.

Отрын бүс нутагт аймаг, сумын төсвийн хөрөнгөөр малын хашаа саравч барих, худаг ус гаргах, өвс тэжээл бэлтгэх, сум дундын нутагт бусад сумдаас нүүж ирэх малчдын замыг тосгуулан дамжин өнгөрөх цэг байгуулж тохижуулах, ойролцоох нутгийн иргэдэд тулгуурлан хүн малын эмч, худалдаа, үйлчилгээний газар ажиллуулах арга хэмжээ авах нь зүйтэй.

Отрын бүс нутгийн бэлчээрийн ургац тачир, сийрэг байдлыг харгалзан отрын бүс нутагт даацаас хэтэрсэн мал оруулах, ган, зуд тохиогоогүй үед мал оруулахаас аль болохоор татгалзаж байхыг санал болголоо.

Хүснэгт №2.58. Отрын бүс нутгуудын тэжээлийн нөөц, даац

№	Сумын нэр	Газрын нэр	Зураг дээрхи дугаар	Талбай /га/	Ургамлын индекс	Жилийн дундаж ургац/цн.га/	Тэжээлийн нөөц/тн/	Даац /хонь толгой/
Аймаг дундын отрын бүс нутаг								
1	Ховд	Ачит нуур	4	8281.3	У-VI-1-8	0.8	662.51	1274
				5047.9	У-VI-1-9	0.9	454.31	874
				1180.1	Н-I-2-2	2.4	283.23	545
				257.9	Н-III-3-1	3.6	92.85	179
				6291.8	ЦХ-I-1-2	1.2	755.02	1452
				21059.1			2247.9	4323
Сум дундын отрын бүс нутаг								
2	Өмнөговь	Намирийн түнгэ	2	261.8	У-IV-2-15	1.8	47.13	91
				115.1	Х-II-2-8	1.5	17.26	33
				66.8	Н-III-3-1	3.7	24.70	48
				15.7	Н-III-3-2	1.8	2.82	5
				11094.2	Н-III-3-5	1.3	1442.24	2774
				94.0	ЦХ-I-1-5	1.5	14.09	27
				11647.4			1548.2	2977
3	Завхан	Үнэгэд	3	2936.7	У-V-1-2	2.9	851.64	1638
				27.8	Х-II-2-2	1.8	5.00	10
				804.0	ЦХ-I-1-8	1.2	96.48	186
				3768.4			953.1	1833
4	Бөхмөрөн	Ачит нуур	5	1451.7	У-VI-1-8	1.2	174.21	335
				14785.1	Н-I-2-2	2.6	3844.12	7393
				235.5	Н-III-1-3	3.4	80.08	154
				261.1	ЦХ-I-1-8	1.5	39.17	75

				16733.4			4137.6	7957
Сумын отрын нөөц нутаг								
5	Баруунтуруун	Эрдэнэтолгой	1	1548.8	У-V-1-4	2	309.76	596
				5820.7	Х-II-2-5	1.4	814.90	1567
				142.5	Х-III-1-2	1	14.25	27
				4945.0	Х-III -2-1	1.1	543.95	1046
				12457.0			1682.9	3236
6	Давст	Зүүн тэрмис	6	666.9	Х-I-2-13	1.8	120.04	231
				9987.4	Х-II-2-2	1.6	1597.98	3073
				10654.3			1718.0	3304
7	Улаангом	Дунд тэрмис	7	157.4	Х-I-2-13	1.8	28.34	54
				7147.2	Х-II-2-2	1.6	1143.55	2199
				7304.6			1171.9	2254
8	Өлгий	Хожгор, Аргалант, Ширэн хан	8	3859.5	У-VI-2-2	0.8	308.76	594
				12.0	У-IV-2-5	2.2	2.64	5
				1332.0	Х-II-4-1	1.8	239.75	461
				569.9	ЦХ-I-1-2	1.8	102.59	197
				4766.8	ЦХ- I-1-8	1.9	905.69	1742
				1290.7	ЦХ-I-1-15	1.8	232.32	447
				403.1	ЦХ-I-2-3	1.8	72.56	140
				27732.8	ЦХ-I-2-4	1.9	5269.23	10133
				4813.3	Ц-I-1-8	1.8	866.39	1666
				44780.1			7999.9	15385

Хүснэгт №2.59. Отрын бүс нутгуудын бэлчээрийн даац, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Сумын нэр	Газрын нэр	Талбай /га/	Бэлчээрийн даац /хонь.толгой/	Арга хэмжээ
1	Ховд	Ачит нуур	21059.1	4323	
2	Өмнөговь	Намирийн түнгэ	11647.4	2977	
3	Завхан	Үнэгэд	3768.4	1833	Усан хангамжыг сайжруулах
4	Бөхмөрөн	Ачит нуур	16733.4	7957	
5	Баруунтуруун	Эрдэнэтолгой	12457.0	3236	
6	Давст	Зүүн тэрмис	10654.3	3304	Усан хангамжыг сайжруулах
7	Улаангом	Дунд тэрмис	7304.6	2254	Усан хангамжыг сайжруулах
8	Өлгий	Хожгор, Аргалант, Ширэн хан	44780.1	15385	Усан хангамжыг сайжруулах
9	Дүн		128404.3	41268.4	

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮН АМЫН СУУРЬШЛИЙН БҮС НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

3.1. Хот тосгон бусад суурин газрын одоогийн байдал

3.1.1. Хот суурин газрын ашиглалтын байдал

Увс аймаг газрын нэгдмэл сангийн ангиллын 2013 оны байдлаар хот, тосгон бусад суурин газар 16608 га гэж бүртгэгдсэнээс барилга байгууламжийн дэвсгэр газар 3577.41га, нийтийн эдэлбэр газар 8219.3 га, үйлдвэрийн газар 40.06га, уурхайн дэвсгэр газар 3345.9га, гэр хорооллын газар 1425.2га гэж бүртгэгдсэн байна.

Хүснэгт №3.1. Сумдын хот, тосгон бусад суурины газрын хэмжээ /га/

Д/д	Сумдын нэр	Бүгд/га/	Барилга, байгууламж	Нийтийн эдэлбэр	Үйлдвэрийн газар	Уурхай	Гэр хороолол
1	Баруунтуруун	648.76	20.16	574.19	7.24		47.17
2	Бөхмөрөн	280.96	7.29	92.08	0.06	158.7	22.83
3	Давст	444.97	14.72	170.31		231	28.94
4	Завхан	68.97	4.36	52.61	2		10
5	Зүүнговь	257.99	6.39	220.55			31.05
6	Зүүнхангай	630.02	8.02	299.80	0.25	295.73	26.22
7	Малчин	627.24	157.58	430.85	1		37.81
8	Наранбулаг	383.95	11.12	233.29		112	27.54
9	Өлгий	111.61	8.67	82.24			20.7
10	Өмнөговь	585.05	12.17	469.84		50	53.04
11	Өндөрхангай	388.49	10.17	323.74	0.22		54.35
12	Сагил	204.11	5.96	171.26	0.87		26.02
13	Тариалан	2244.91	23.52	127.78	4.34	2045	44.27
14	Түргэн	799.87	64.62	354.65		355.9	24.7
15	Тэс	433.80	18.47	325.76		58.4	31.17
16	Ховд	198.50	9.98	164.84	0.55		23.13
17	Хяргас	1788.30	13.44	1746.21	1	2	25.65
18	Цагаанхайрхан	773.55	26.07	707.92	3.13	8.26	28.17
19	Улаангом	5707.92	3154.7	1671.37	19.4		862.45
Дүн		16608.03	3577.41	8219.35	40.06	3345.99	1425.21

Одоо байгаа хот суурин газрын хэмжээгээр багатай сумд Завхан, Өлгий, Сагил, Ховд зэрэг сумдууд байна. Эдгээр сумдууд нь аймгийн төвөөс алслагдмал, төв рүү нүүх хүн амын шилжилт хөдөлгөөний байдал, хөрс, ургамалжилтын хувьд газар тариалан, үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжгүй, үйлдвэрлэл, зам харгуй, эдийн засгийн хувьд сайн хөгжөөгүй улмаас иргэдийн тогтмол суурьшмал байдал муу байдагтай холбоотой гэж үзэж байна. Харин төв суурин газартай ойр оршдог болон үйлдвэрлэл, зам харгуй сайтай, газар тариалан түлхүү хөгжсөн сумд болох Баруунтуруун, Тариалан, Хяргас, Цагаанхайрхан зэрэг сумдууд хот суурины газар нутгийн хэмжээгээр арай илүү байна. Энэ нь сумын эдийн засгийн нөхцөл бололцоо, иргэдийн тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах, зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Хүснэгт№3.2. Увс аймгийн сумдуудын суурин газрын 2003 болон 2014 оны өөрчлөлт га-аар

Д/д	Аймаг, сумдын нэр	Барилга байгууламжын дэвсгэр газар			Гэр хорооллын газар			Нийтийн ашиглалтын газар			Үйлдвэр			Уурхай			Бусад газар			Суурьшлын бүсийн нийт газар		
		2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%	2003	2014	%
1	Баруунтуруун	15.62	20.16	+29	40.29	47.17	+17.1	575.51	574.19	-0.2		7.24			0					631.42	648.76	2.7
2	Бөхмөрөн	10.21	7.29	-28	23.49	22.83	-2.8	93.51	92.08	-1.5		0.06		590	187.7	-68.2				717.21	309.96	56.8
3	Давст	15.3	14.72	-3.7	11.93	28.94	+142.6	182.75	170.31	-6.8				209	231	+10.5				418.98	444.97	6.2
4	Завхан	8.43	4.36	-48.2	8.38	10	+19.3	53.16	52.61	-1.0		2			0					69.97	68.97	1.4
5	Зүүнговь	6.39	6.39	0	14.54	31.05	+113.5	239.56	220.55	-7.9					0					260.49	257.99	1.0
6	Зүүнхангай	4.18	8.02	+91.8	15.27	26.22	+71.7	315.35	299.81	-4.9		0.25		5.7	295.73	+5088.2				340.5	630.03	85.0
7	Малчин	160.54	157.58	-1.8	15.2	37.81	+148.8	299.52	430.85	+43.8		1			0					475.26	627.24	32.0
8	Наранбулаг	13.42	11.12	-17.1	13.81	27.54	+99.4	245.57	233.29	-5.0					112					272.8	383.95	40.7
9	Өлгий	21.02	8.67	-58.7	8.94	20.7	+131.5	82.66	82.24	-0.5					0					112.62	111.61	0.9
10	Өмнөговь	10.77	12.17	+12.9	18.6	53.04	+185.2	506.5	469.84	-7.2				50	50	0				585.87	585.05	0.1
11	Өндөрхангай	11.07	10.17	-8.1	25.35	54.35	+114.4	353.04	323.75	-8.3		0.22			0					389.46	388.49	0.2
12	Сагил	40.54	5.96	-85.2	11.55	26.02	+125.3	151.51	171.26	+13.0		0.87			0					203.6	204.11	0.3
13	Тариалан	12.41	23.52	+89.5	30.11	44.27	+47	148.78	127.78	-14.1	4.34	4.34	0	489	2045	+318.2				684.64	2244.91	227.9
14	Түргэн	20.59	64.62	+213.8	14.69	24.7	+68.1	359.7	354.65	-1.4				40	355.9	+789.8				434.98	799.87	83.9
15	Тэс	23.65	18.47	-21.9	30.47	31.17	+2.3	322.85	325.77	+0.9				58.4	58.4	0.0				435.37	433.81	0.4
16	Ховд	42.71	9.98	-76.6	15.86	23.13	+45.8	50.33	164.84	+227.5		0.55			0					108.9	198.5	82.3
17	Хяргас	51.81	13.44	-74.1	15.44	25.65	+66.1	254.99	1746.22	+584.8		1			2					322.24	1788.31	455.0
18	Цагаанхайрхан	7.18	26.07	+263.1	15.5	28.17	+81.7	383.78	707.93	+84.5		3.13			8.26					406.46	773.56	90.3
19	Улаангом	3187.58	3154.7	-1	231.1	862.45	+273.2	2362.42	1671.37	-29.3	19.4	19.4	0	3.6	0					5804.1	5707.92	1.7
Аймгийн дүн		3663.42	3577.41	-2.3	560.52	1425.21	+154.3	6981.49	8219.36	-15.1	23.74	40.06	+68.7	1445.7	3345.99	+131.4				12674.87	16608.01	+31.0

Эх үүсвэр* Увс аймгийн ГТ-1 2003,2014он

3.1.2. Увс аймгийн бүлэг суурингийн тогтолцоо*Хүснэгт №3.3. Бүлэг суурингийн тогтолцоо*

Д/д	Бүлэг суурингийн төвийн нэр	Хамрагдах сум суурины нэр
1	Улаангом хот	Тариалан, Түргэн
2	Өмнөговь сум	Өлгий, Завхан, Ховд, Наранбулаг
3	Баруунтуруун сум	Цагаанхайрхан, Зүүнхангай, Өндөрхангай, Малчин, Зүүнговь, Хяргас
4	Тэс сум	Бие даасан төв
5	Сагил сум	Давст, Бөхмөрөн

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хот суурины нутаг дэвсгэрийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор хүн амын тоог 2020, 2025, 2030 онуудаар тооцоолсныг үндэслэн сумдыг хүн амын тоогоор нь 3 ангиллаа. Үүнд:

- 2000-3000 хүнтэй сумдууд:** Бөхмөрөн, Давст, Завхан, Зүүнговь, Зүүнхангай, Малчин, Өлгий, Сагил, Түргэн, Ховд, Хяргас, Цагаанхайрхан
- 3001-5000 хүнтэй сумдууд:** Баруунтуруун, , Өндөрхангай, Тариалан,
- 5001-6000 хүнтэй сумдууд:** Наранбулаг, Өмнөговь, Тэс

Ангиллыг харгалзан сумдын төв байх соёл ахуйн үйлчилгээний барилгын хүчин чадлыг тогтоосон.

Бүлэг суурингийн төв Өмнөговь, Баруунтуруун, Тэс, Сагилд ерөнхий боловсролын бүрэн дунд төрөлжсөн сургууль, сум дундын эмнэлэг байна. Улаангом хотод аймгийн нэгдсэн эмнэлэг байна.

Сум бүрт хүн амын соёл ахуйн үйлчилгээний байгууллагууд болох хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, сумын эмнэлэг, худалдаа үйлчилгээний бүх төрлийн барилга байгууламж байхаар тооцлоо.

Хот төлөвлөлтийн нормоор тооцсон соёл ахуйн үйлчилгээний барилга байгууламжаас гадна хүн амын тоогоор нь бүлэглэсэн Сумдын хөгжлийн загвар, Сумдад нийтлэг хөгжүүлэх үйлдвэрлэл бизнесийн загварт тодорхойлсон бусад барилга байгууллага сумдын төвд байна.


Хүснэгт №3.4. Сум суурины төвд хот байгуулалтын нормын дагуу байх шаардлагатай соёл ахуйн үйлчилгээний байгууллага

№	Сум суурины нэр	Хүүхдийн цэцэрлэг	сургууль	Бүрэлдүнд боловсролын сургууль	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Их дээд сургууль	МСҮТ	Эмийн сан	Биеийн тамир спортын байгууламж	Соёлын төв	Зочид буудал	Дэлгүүр, худалдаа	Нийтийн хоолны газар	Ахуйн үйлчилгээний төв	Холбооны салбар	Банк
1	Улаангом	+	+	+	+	+		+	+	+	+	+	+	+	+	+	+
2	Баруунтуруун	+	+	+	+	+		+	+	+	+	+	+	+	+	+	+
3	Бөхмөрөн	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
4	Давст	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
5	Завхан	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
6	Зүүнговь	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
7	Зүүнхангай	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
8	Малчин	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
9	Наранбулаг	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
10	Өлгий	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
11	Өмнөговь	+	+	+	+	+		+	+	+	+	+	+	+	+	+	+
12	Өндөрхангай	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
13	Сагил	+	+	+	+	+		+	+	+	+	+	+	+	+	+	+
14	Тариалан	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
15	Түргэн	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
16	Тэс	+	+	+	+	+		+	+	+	+	+	+	+	+	+	+
17	Ховд	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
18	Хяргас	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+
19	Цагаанхайрхан	+	+	+	+				+	+	+	+	+	+	+	+	+

3.2. Хот байгуулалтын нөхцлийн ерөнхий үнэлгээ, хэрэгцээ шаардлага

3.2.1. Хүн амын шилжилт хөдөлгөөн, өсөлт бууралт

2013 оны статистик тоо баримтаас харахад Увс аймагт нэг километр нутаг дэвсгэрт 2000 онд 1.3 хүн ногдож байсан бол 2010 онд 1.0 болж буурчээ. Сумын хүн амын нягтралын өөрчлөлтөд ердийн цэвэр өсөлтийн бууралтаас гадна дотоод шилжих хөдөлгөөн нөлөөлж байна. Хүн амын, орон сууцны 2010 оны тооллогоор Увс аймгийн хүн ам сүүлийн 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 14.0 мянган хүнээр буурсан нь тоологдсон хүн амын 19.2 хувьтай тэнцэж байна. 1000 хүнд ногдох төрөлт 1990 онд 40.0, 2000 онд 28.1 байгаагаас 2012 онд 28.0 болж, улсын дунджаас 2 пунктээр илүү байна. 1000 хүнд ногдох нас баралт 1990 онд 8.8, 2000 онд 6.4 байгаагаас 2012 онд 4.5 болж улсын дунджаас 1.8 пунктээр буурсан байна.



Зураг №3.1. Хүн амын өсөлт, бууралт



Зураг №3.2. Хүн амын нягтшил

Хүснэгт №3.5. Сумын хүн амын өсөлтийн тооцоо /2014-2030 он /

Сумдын нэр	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Баруунтуруун	2385	2890	2899	2913	2934	2960	2993	3032	3077	3130	3190	3258	3333	3418	3511	3614	3728	3852
Бөхмөрөн	2180	2182	2186	2193	2201	2212	2226	2241	2258	2279	2302	2327	2355	2386	2420	2456	2496	2538
Давст	1748	1750	1753	1758	1765	1774	1785	1797	1811	1827	1845	1866	1889	1913	1940	1969	2001	2035
Завхан	1722	1724	1728	1733	1740	1749	1760	1772	1786	1802	1820	1840	1862	1887	1913	1942	1973	2006
Зүүнговь	2413	2415	2420	2427	2437	2449	2464	2481	2500	2523	2548	2576	2607	2642	2679	2719	2702	2810
Зүүнхангай	2231	2233	2237	2244	2253	2265	2278	2294	2312	2333	2356	2382	2411	2443	2477	2515	2555	2598
Малчин	2404	2406	2411	2415	2428	2440	2455	2472	2492	2514	2539	2567	2598	2632	2669	2710	2753	2800
Наранбулаг	4356	4360	4369	4382	4400	4422	4448	4479	4514	4555	4601	4651	4708	4769	4837	4910	4989	5074
Өлгий	2121	2123	2127	2134	2142	2152	2166	2181	2198	2218	2240	2265	2292	2322	2354	2390	2479	2523
Өмнөговь	4348	4352	4361	4374	4392	4413	4440	4471	4506	4547	4593	4643	4699	4761	4828	4900	4980	5065
Өндөрхангай	3155	3158	3164	3173	3187	3202	3221	3244	3270	3299	3332	3369	3409	3454	3503	3556	3613	3675
Сагил	2267	2270	2274	2281	2290	2302	2316	2332	2351	2372	2396	2422	2451	2483	2518	2556	2597	2641
Тариалан	3679	3682	3694	3704	3720	3738	3760	3787	3817	3852	3890	3933	3980	4032	4089	4150	4217	4289
Түргэн	2015	2017	2021	2027	2035	2045	2057	2072	2088	2107	2128	2152	2177	2206	2237	2270	2307	2346
Тэс	5280	5285	5295	5312	5332	5360	5392	5429	5472	5521	5577	5638	5706	5781	5863	5951	6047	6150
Ховд	2222	2224	2228	2235	2244	2255	2269	2285	2303	2324	2347	2373	2402	2433	2467	2504	2544	2588
Хяргас	2426	2428	2433	2440	2450	2462	2477	2495	2514	2537	2563	2591	2622	2656	2694	2735	2778	2826
Цагаанхайрхан	1972	1974	1978	1984	1992	2002	2014	2028	2044	2063	2083	2106	2131	2159	2190	2223	2259	2297
Улаангом	26594	26620	26673	26753	26860	26994	27156	27346	27565	27813	28091	28400	28744	29120	29531	29976	30458	30979
Дүн	75518	75744	75896	76194	76428	76810	77271	77812	78434	79140	79931	80810	81788	82860	84028	85297	86670	88152

Хүснэгт №3.6. Сумын төвийн хүн амын өсөлтийн тооцоо /2014-2030 он /

д/д	Сумдын нэр	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
1	Баруунтуруун	1781	1783	1786	1792	1799	1808	1819	1831	1846	1863	1881	1902	1925	1950	1978	2007	2040	2075
2	Бөхмөрөн	1092	1093	1106	1110	1114	1120	1126	1134	1143	1153	1165	1178	1192	1207	1224	1242	1262	1284
3	Давст	561	562	563	564	567	569	573	577	582	587	593	600	607	615	624	633	644	654
4	Завхан	661	662	663	665	668	671	675	680	685	692	698	705	714	723	734	745	757	770
5	Зүүнговь	713	714	715	717	720	723	728	733	739	745	753	760	770	780	791	803	816	830
6	Зүүнхангай	510	511	512	513	515	518	522	526	530	535	540	545	552	559	567	576	585	595
7	Малчин	629	630	631	633	635	638	642	647	652	658	664	671	679	688	698	708	720	732
8	Наранбулаг	1172	1173	1175	1179	1184	1190	1197	1205	1215	1225	1238	1251	1266	1283	1301	1321	1342	1365
9	Өлгий	407	407	408	409	411	413	416	419	422	426	430	435	440	446	452	459	466	474
10	Өмнөговь	702	703	704	706	709	712	717	722	728	734	742	750	760	769	780	792	804	818
11	Өндөрхангай	1044	1045	1047	1050	1054	1060	1069	1077	1085	1095	1106	1118	1132	1146	1163	1180	1199	1220
12	Сагил	747	748	749	751	754	758	762	764	770	776	784	793	802	813	824	837	850	865
13	Тариалан	1350	1351	1354	1358	1363	1370	1378	1388	1399	1412	1426	1441	1459	1478	1499	1522	1546	1572
14	Түргэн	829	830	831	834	837	842	846	852	859	866	875	885	895	907	920	934	949	965
15	Тэс	709	710	711	713	716	719	724	729	735	741	749	757	766	776	787	799	812	826
16	Ховд	774	775	776	779	782	785	790	796	802	810	817	826	836	847	859	872	886	901
17	Хяргас	785	786	787	790	793	797	802	807	813	821	829	838	848	860	872	885	899	915
18	Цагаанхайрхан	928	929	931	933	937	942	947	954	962	970	980	991	1003	1016	1030	1046	1063	1081
19	Улаангом	22855	22917	22964	23032	23124	23240	23380	23544	23732	23945	24185	24451	24747	25071	25425	25809	26224	26672

Хүснэгт №3.7. Сумын төвийн өрхийн өсөлтийн тооцоо /2020-2030 он/

Д/д	Сумдын нэр	2020он		2025он		2030он	
		хүн ам	өрх	хүн ам	өрх	хүн ам	өрх
1	Баруунтуруун	1831	469	1925	506	2075	546
2	Бөхмөрөн	1134	298	1192	322	1284	347
3	Давст	577	175	607	190	654	204
4	Завхан	680	200	714	216	770	233
5	Зүүнговь	733	209	770	226	830	247
6	Зүүнхангай	526	132	552	142	595	153
7	Малчин	647	202	679	219	732	236
8	Наранбулаг	1205	280	1266	301	1365	325
9	Өлгий	419	127	440	138	474	148
10	Өмнөговь	722	190	760	205	818	221
11	Өндөрхангай	1077	291	1132	314	1220	339
12	Сагил	764	212	802	229	865	247
13	Тариалан	1388	347	1459	374	1572	403
14	Түргэн	852	213	895	229	965	247
15	Тэс	729	182	766	196	826	212
16	Ховд	796	249	836	270	901	291
17	Хяргас	807	224	848	242	915	261
18	Цагаанхайрхан	954	298	1003	324	1081	349
19	Улаангом	23544	6727	24747	7070	26672	7620

3.2.2. Хот суурины газрын хэрэгцээ, хамгамжийн үнэлгээ

Газар зохион байгуулалтын 2014-2030 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд хот байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага, төлөвлөлтийн норм ба дүрмийн дагуу тухайн хот сум суурины төвийн барилга байгууламж, нутаг дэвсгэрийн бүсүүдэд шаардагдах газрын хэмжээг тооцоолж гаргалаа.

Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний тооцооны үндэс болох хүн амын хэтийн тоог 2014-2020, 2021-2025, 2026-2030 оноор тооцоолж хүн амын тоотой уялдуулан орон сууц, цэцэрлэг сургууль эмнэлэг, худалдаа үйлчилгээний барилга байгууламжуудын хүчин чадал, шаардагдах эдэлбэр газрын хэмжээг тодорхойлов. **/Хот байгуулалтын нормоор/**

Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгуулалмжын бүс

Захиргаа олон нийтийн төвд нутгийн захиргаа олон нийтийн 7-8 байгууллага төвлөрч 8,4-9,6 га газрыг эзлэнэ. Худалдаа үйлчилгээний төвд дэлгүүр, ахуйн үйлчилгээний байгууллагууд байрлаж 1,0-1,14 га газартай байна.

Гэр орон сууцны бүс

Орон сууцны бүсэд шаардагдах газрын хэмжээг гаргахдаа нэг өрхөд 0,07-0,08 га эдэлбэр газар ногдохоор, өмчлөлд шаардагдах газрын хэмжээг хуулийн дагуу нэг иргэнд 0,5 га-аар тус тус тооцсон. Цэцэрлэгийн 1 хүүхдэд 40м², ерөнхий боловсролын сургууль дотуур байрт 2,0-2,8 га, эмнэлэгийн 1 оронд 300м², биеийн тамир спортын цогцолбор нь 1000 хүнд 0,7-0,9 га байна.

Үйлдвэр аж ахуйн бүс

Үйлдвэр аж ахуйн бүсийн тооцоонд тухайн сумын газрын нэгдмэл сангийн тайлан, хөгжлийн хэтийн төлөвийн харгалзан үзсэн болно. Энэ бүсэд байх хүнс, бараа, барилгын материал, түүхий эдийн захуудыг хот төлөвлөлтийн нормд заагдсан 1000 хүнд 60-300м² эдэлбэр газар ногдохоор, дахин ашиглах түүхий эд /хоёрдогч түүхий эд/-ийн цэгийн газрын хэмжээг 5-6 мянган хүнд 0,1 га эдэлбэр газар бүхий 1 объект байхаар тооцсон.

Нийтийн эзэмшлийн бусад газар

Хот орчмын бүсэд хамаарах хог хаягдлын газрын хэмжээ нь нормоор 1000 хүнд 0,02-0,05 га байна. Оршуулгын газрын хэмжээ нь нормоор 1000 хүнд 0,3-0,5 га байх ёстой боловч одоо байгаа хэмжээнээс нь ихгүй байхаар тооцсон. Авто засварын газар 100 машинд 5,0 га, шатахуун түгээх станц 2 резервуартай үед 0,1 га, 4 резервуартай бол 0,2 га, 6 резервуартай бол 0,3 га байна.

Галын депо нь 5-6 мянган хүнд 0,3-0,6 га эдэлбэр газар бүхий 1 объект байх бөгөөд 2-оос цөөнгүй машинтай байна.

Автовокзал нь 100 машинд 2,3 га, 200 машинд 3,5 га эдэлбэр газартай байна. Нисэх буудлын эдэлбэр газрыг газрын нэгдмэл сангийн тайланд тусгагдсанаар авч тооцсон. Сумын төвд байх халаалтын зуух, ус хангамжийн эх үүсвэр, бохир ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын хэмжээг хүчин чадалтай нь уялдсан нормоор бодож төлөвлөв. Хот төлөвлөлтийн норм нь хот байгуулалтын үр ашиг, оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцлийг хангах оновчтой хэмжээ тул түүнийг баримтлан хот байгуулалтын үйл ажиллагаа явуулах нь зохистой.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд сумдын хүн амын тоо, сумдын төвийн барилга байгууламж болон бүсүүдийн шаардагдах газрын хэмжээ, иргэнд өмчлүүлэх газрын хэрэгцээг сум тус бүрээр тооцоолов. Үүнд:

1. Сумын төвийн хүн амын тооцоо
2. Сумын хүн амын тооцоо
3. Сумын төвийн өрхийн тооцоо
4. Сумын төвийн суурьшлийн бүсийн тооцоо
5. Соёл ахуй үйлчилгээний байгууллагуудын эдэлбэр газрын тооцоо
6. Сумын төвийн дэд бүсийн тооцоо
7. Сумын төвийн эдэлбэр газрын тооцоо
8. Сумын хүн амын өмчлөлд шаардагдах газрын хэрэгцээний тооцоо

Эдгээр тооцоог дараахь хүснэгтүүдэд тодорхой үзүүлэв.

Хүснэгт№3.8. Сумын төвийн суурьшилийн бүсэд шаардлагатай газрын тооцоо/2020-2030 он/ хот байгуулалтын нормоор

Д/Д	Сумдын нэр	2020							2025							2030						
		Орон сууц	Соёл үйлчилгээ	Захиргаа олон нийт	Зам гудамж	Ногоон байгууламж	Нөөц	Дүн	Орон сууц	Соёл үйлчилгээ	Захиргаа олон нийт	Зам гудамж	Ногоон байгууламж	Нөөц	Дүн	Орон сууц	Соёл үйлчилгээ	Захиргаа олон нийт	Зам гудамж	Ногоон байгууламж	Нөөц	Дүн
1	Баруунтуруун	52.3	8.41	9.6	3.7	1.83	7.58	83.42	55	8.41	9.8	3.85	1.93	7.9	86.9	59.2	8.41	9.9	4.15	2.1	8.38	92.14
2	Бөхмөрөн	32.4	6.12	9.6	2.3	1.13	5.15	56.7	34	6.12	9.8	2.38	1.2	5.35	58.9	36.7	6.12	9.9	2.57	1.3	5.7	62.3
3	Давст	19.2	4.38	8.4	1.15	0.58	3.4	37.11	20.2	4.38	8.6	1.21	0.61	3.5	38.5	21.8	4.38	8.7	1.31	0.7	3.7	40.59
4	Завхан	20.6	4.64	8.4	1.36	0.7	3.57	39.3	21.6	4.64	8.6	1.43	0.71	3.7	40.7	23.3	4.64	8.7	1.54	0.8	3.9	42.88
5	Зүүнговь	22.2	4.96	8.4	1.47	0.7	3.8	41.53	23.3	4.96	8.6	1.54	0.8	3.9	43.1	25.2	4.96	8.7	1.7	0.8	4.14	45.5
6	Зүүнхангай	15	4.35	8.4	1.05	0.53	2.93	32.26	15.8	4.35	8.6	1.1	0.6	3.05	33.5	17	4.35	8.7	1.2	0.6	3.18	35.03
7	Малчин	19.6	4.74	8.4	1.29	0.64	3.47	38.14	20.6	4.74	8.6	1.35	0.7	3.6	39.6	22.2	4.74	8.7	1.5	0.7	3.8	41.64
8	Наранбулаг	34.4	7.59	9.6	2.41	1.2	5.52	60.72	36.2	7.59	9.8	2.53	1.3	5.74	63.2	39	7.59	9.9	2.73	1.4	6.1	66.72
9	Өлгий	12.7	4.1	0.84	0.25	0.42	1.83	20.14	13.3	4.1	8.6	0.9	0.5	2.74	30.1	14.4	4.1	8.7	0.95	0.5	2.86	31.51
10	Өмнөговь	21.9	6.1	8.4	1.44	0.72	3.86	42.42	23	6.1	8.6	1.52	0.8	4	44	24.8	6.1	8.7	1.64	0.8	4.2	46.24
11	Өндөрхангай	32.6	6.19	9.6	2.15	1.1	5.16	56.8	34.3	6.19	9.8	2.3	1.13	5.37	59.1	37	6.19	9.9	2.45	1.2	5.7	62.44
12	Сагил	23.2	5.1	8.4	1.53	0.8	3.9	42.93	24.3	5.1	8.6	1.6	0.8	4	44.4	26.2	5.1	8.7	1.73	0.9	4.3	46.93
13	Тариалан	39.7	7.88	9.6	2.78	1.4	6.14	67.5	41.7	7.88	9.8	2.92	1.5	6.4	70.1	44.9	7.88	9.9	3.14	1.6	6.74	74.16
14	Түргэн	24.3	5.28	8.4	1.7	0.9	4.1	44.68	25.6	5.28	8.6	1.79	0.9	4.22	46.4	27.6	5.28	8.7	1.93	0.97	4.45	48.93
15	Тэс	20.8	6.41	8.4	1.46	0.7	3.78	41.55	21.9	6.41	8.6	1.53	0.8	3.9	43.1	23.6	6.41	8.7	1.65	0.83	4.1	45.3
16	Ховд	24.1	5.1	8.4	1.59	0.8	4	44	25.3	5.1	8.6	1.67	0.8	4.2	45.6	27.3	5.1	8.7	1.8	0.9	4.4	48.2
17	Хяргас	24.4	0.18	8.4	1.51	0.8	4.04	44.43	25.7	5.18	8.6	1.7	0.85	4.2	46.2	27.7	5.18	8.7	1.83	0.92	4.43	48.8
18	Цагаанхайрхан	28.9	5.35	9.6	1.91	0.1	4.6	50.46	30.4	5.35	9.8	2.01	1	4.9	53.5	32.7	5.35	9.9	2.16	1.1	5.12	56.33

Хүснэгт №3.9. Сумын төвийн дэд бүсэд шаардлагатай газрын тооцоо/төлөвлөлтийн хугацааны эцэст 2030 он/ хот байгуулалтын нормоор

Д/д	Сумдын нэр	Инженерийн байгууламжийн бүс			Аж ахуй үйлдвэрийн бүс										Хот орчмын бүс /товоос 5-15 км/						Дэд бүсийн дун
		Хулаг усан сан	Бохир ус пэвэрлэх байгууламж	Халаалтын зуух	Авто вокзал	Галын депо	Хоёрдогч түүхий эд авах цэг	Үйлдвэрийн бүс	Хүнсний зах	Ахуй үйлчилгээ барааны зах	Барилгын материалын зах	Түлшний зах	Түүхий эдийн зах	ШТС	Амралт сувиллын газар	Нисэх буудал	Хот хаях газар	Оршуулгын газар	Зам	Хамгаалалтын зурвас	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
1	Баруунтуруун	1.5	0.7	0.8	2.5	0.3	0.1	1	0.06	0.02	0.06	0.02	0.02	0.3		0.3	0.04	0.3	18.5	15	42.52
2	Бөхмөрөн	1.2	0.6	0.7	2.3	0.3	0.1	1	0.05	0.02	0.05	0.01	0.02	0.2			0.03	0.3	19.5	15	42.1
3	Давст	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
4	Завхан	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
5	Зүүнговь	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
6	Зүүнхангай	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
7	Малчин	1	0.5	0.7	2.3	0.3	0.1	1	0.05	0.02	0.05	0.01	0.02	0.2			0.03	0.3	19.5	15	40.86
8	Наранбулаг	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.05	0.02	0.05	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.86
9	Өлгий	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
10	Өмнөговь	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
11	Өндөрхангай	1	0.5	0.7	2.3	0.3	0.1	1	0.05	0.02	0.05	0.02	0.02	0.2			0.03	0.3	19.5	15	4.86
12	Сагил	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
13	Тариалан	1	0.6	0.7	2.2	0.3	0.1	1	0.06	0.02	0.06	0.06	0.02	0.2	5		0.04	0.3	19.5	15	46.69
14	Түргэн	1	0.5	0.7	2.2	0.3	0.1	1	0.04	0.01	0.04	0.01	0.01	0.1			0.02	0.3	19.5	15	40.83
Увс аймгийн хувьд цахилгаан шугамын хамгаалалтын зурвас газрын хэмжээг гаргахдаа доорхи хүснэгтэнд буй зохих нормын дагуу гаргав. Үүний тулд шугамын төрлөөс нь хамаарч шугамаас хоёр тийш 10-30м хамгаалалтын зурвасыг авч талбайг гаргав.

Хүснэгт №4.8. Цахилгаан шугамын хамгаалалтын зурвас газрын норм

№	Шугам сүлжээ тоног төхөөрөмж	Хүн оршин суулаагүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суулаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой мод, цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш			Шугамын захын утаснаас 2 тийш
1	Цахилгааны дамжуулах шугам: а/ 1кв хүртэл	-	1-1.5 м	-	-	-	-	-
	б/ 1-20 хүртэл кв	10 м	2 м	10 м	-	-	-	2 м
	в/ 35 кв	15 м	4 м	15 м	-	-	-	3 м
	г/ 110 кв	20 м	5 м	20 м	-	-	-	3 м
	д/ 220 кв	25 м	6 м	25 м	-	-	-	4 м
	е/ 330-500 кв	30 м	10 м	30 м	-	-	-	5 м
2	Кабель шугам	-	-	-	-	1 м	100 м	-
3	Дулааны шугам а/ 500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м	-	-
	б/ 500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м	-	-

Хүснэгт №4.9. Увс аймгийн эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын хэмжээ

№	Сумд	Шугамын төрөл /35кВт/	Урт /км/	Талбай /га/
1	Баруунтуруун	35 кВ	47.5	142.5
2	Бөхмөрөн	10 кВ	7.5	15
3	Давст	10 кВ	28.7	57.4
4	Ховд	10 кВ	52.1	104.2
5	Хяргас	35 кВ	47.1	141.3
6	Малчин	110 кВ	101.3	405.2
		Малчин-Хар тэрмис 10кВ	51	102

7	Наранбулаг	10 кВ	63.9	127.8
8	Өлгий	35 кВ	22	66
9	Өмнөговь	110 кВ	117	468
		10 кВ	3	6
10	Өндөрхангай	15 кВ	61	122
11	Сагил	35 кВ	102	306
12	Тариалан	35 кВ	37	111
13	Тэс	Хуучин ОХУ-аас 10 кВ	30	60
		Одоо Малчин-с 35 кВ	115	345
14	Цагаанхайрхан	15 кВ	34.4	68.8
15	Түргэн	10 кВ	22.6	45.2
16	Улаангом	110 кВ	101	404
		35 кВ	22	66
17	Завхан	15 кВ	60	120
18	Зүүнговь	15 кВ	27.5	55
19	Зүүнхангай	15 кВ	106.7	213.4

Увс аймгийн хувьд нийт эрчим хүчний шугам сүлжээний урт 1281.3 км, нийт талбай 3734.8 га байна.

Дулаан хангамж

Увс аймаг дулаан хангамжийн хувьд зөвхөн аймгийн төв дулаан үйлдвэрлэдэг дулааны станцтай харин хөдөө орон нутаг, сумууд олон тооны халаалтын зуух, бие даасан жижиг зуухыг хэрэглэгчдийн хэрэгцээний халуун ус, халаалтаар хангах зориулалтаар ашиглаж байна.

Аймгийн төв Улаангом хотын дулааны станц нь дулаан үйлдвэрлэдэг KE25/14, KBTC20/150 маркийн зуух бүхий төвлөрсөн дулаан хангамжийн системтэй, хүчин чадал 28.6 Гкал/ц юм.

Хүснэгт №4.10. Аймгийн төвийн дулаан хангамжийн систем (ДХС) – Статистикийн дүн (2012 он)

№	Аймгийн төв	Зуухны төрөл	Зуухны тоо		Хүчин чадал		Зуухны газар, ДДТ		Шугамын урт	Шугамын дээд голч	ДХС-ийн эзэмшил	Нүүрс авдаг уурхай	Уурхайгаас аймагт км	Нүүрсний хэрэглээ
			ш	мвт	ш	км	мм	Мян. т/жил						
1	Улаангом	KE-25-14	3	39	2	3.5	250	ДС,ТШ-Х, СШ-ОН	Хар тарвагаг ай	90	28.1			

Эх сурвалж* Тусгай зөвшөөрөл эзэмшигчид (ТЗЭ), Эрчим хүчний газрын (ЭХГ) өгөгдөл ба Зөвлөхийн өгөгдөл

2013 оны байдлаар Улаангом хотын нийт хүн амын 12% буюу 900 хүн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон орон сууцанд амьдарч байна.

1980-аад оны дунд үед буюу 1986 оноос Дулааны станц ашиглалтанд орж Улаангом хотын үйлдвэр албан газрыг уураар хангаж эхэлсэн ба удалгүй дулааны төв шугам, сүлжээ баригдаж орон сууц, нийгэм ахуйн хэрэглэгчдийг дулаанаар хангадаг болжээ.

Улаангом хотын дулааны хэрэглээг нийгэм ахуйн ба орон сууцны барилгын халаалт болон хэрэгцээний халуун усны дулааны хэрэглээг үндэслэн гаргав.

Хүснэгт №4.11. Улаангом хотын дулааны хэрэглээний хэтийн төлөв

Он	Төвийн хүн ам	Дулаан авдаг	Халаах талбай	Өсөлт	Жилийн дулааны хэрэглээ	Дээд ачаалал
	Мян.	хүн	км ²	%	Мян. Гкал	Гкал/ц
2004	22,518	797	85.1	39.4%	20,315	7.3
2005	23,858	809	93.5	9.9%	22,280	7.9
2006	23,023	821	103.0	10.1%	24,474	8.5
2007	21,949	833	113.5	10.2%	26,924	9.3
2008	22,982	846	125.3	10.4%	29,662	10.1
2009	23,561	859	138.5	10.5%	32,722	11.0
2010	23,250	877	153.3	10.7%	36,166	12.0
2011	22,704	890	156.3	1.9%	36,857	12.2
2012	23,000	903	159.3	1.9%	37,562	12.4
2013	22,189	917	162.4	1.9%	38,281	12.7
2014	24,300	931	165.5	1.9%	39,013	12.9
2015	25,700	944	168.8	1.9%	39,760	13.2
2020	30,500	917	331.7	96.6%	112,930	34.1

Эх сурвалж* Тусгай зөвшөөрөл эзэмшигчид (ТЗЭ), Эрчим хүчний газрын (ЭХГ) өгөгдөл ба Зөвлөхийн өгөгдөл

Нэг хүнд ноогдох дулааны хэрэглээний таацыг тооцож Гкал-аар гаргав. Энд эцсийн хэрэглэгч хүртэлх дулаан алдагдлыг оруулаагүй болно.

Хүснэгт №4.12. Улаангом хотын дулаан (Жилд)

Он	Дулаан хэрэглэгч	Сууц	Албан газар	Сууцны халаалт	Албан газрын дулаан	Сууцны халуун ус	Нийт	Нэг хүнд ноогдох
	Мян.	Мян. м ²	Мян. м ³	ПДж	ПДж	ПДж	Мян. Гкал	Гкал
2012	2,710	18,967	392,950	0.013	0.137	0.008	37,562	13.9

Улаангом хотын хувьд дунд чадлын төвлөрсөн халаалтын зуухнаас дулааны сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдийг дулаанаар хангаж байна. Суурилагдсан хүчин чадал, үйлдвэрлэсэн хүчин чадлын тайлан, нөөц хүчин чадал болон хүчин чадлын тооцоолсон алдагдлыг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №4.13. Улаангом хотын дулаан хангамжийн хүчин чадал (2012 он)

Суурилагдсан хүчин чадал	Үйлдвэрлэсэн хүчин чадал	Нөөц хүчин чадал	Дулааны алдагдал	
Гкал/ц	Гкал/ц	Гкал/ц	Гкал/ц	Үйлдвэрлэсний %
28.6	20.0	10.3	7.6	38%

Одоогоор дулаан дамжуулах 5 төвтэй, сүлжээний төв шугамын нийт урт 4.5 хос км. Төв шугамын диаметр толгойн хэсэгтээ 250 мм, ДДС-ын оролтонд 150 мм. 2006 онд хийсэн туршилтаар төв шугамын техникийн байдал сайн гэж гарсан.

4.2. Зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлт

Авто зам

Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийхдээ Монгол улсын авто замын салбарын “Автозамын сүлжээг дунд хугацаанд хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө” /1994 он/, Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” /1999 он/, “Мянганы зам төсөл” /2001/, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, түүнтэй харилцан уялдах автозам ба тээврийн хэтийн хөгжлийн төлөв” /2001”/, Азийн

авто сүлжээнд нэгдэх бодлого” /2005 он/, “Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /2007/, “Монгол улсын авто замыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө” /2007 он/, Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” /2012 он/ Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр /2008-2021/ тус аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад холбогдох баримт бичгүүдийг ашиглалаа.

Увс аймгийн авто замын хэтийн хэрэгцээг төлөвлөхдөө босоо тэнхлэгийн Боршоо-Улаангомьн үргэлжлэл Улаангом-Ховдын хатуу хучилттай замыг барьж дуусгах, дараа нь Улаангомьн Цагаан нуурын худалдааны чөлөөт бүстэй хатуу хучилттай замтай холбох ажлыг гүйцэтгэх, улмаар босоо тэнхлэгийн зам дайран өнгөрдөг Увс аймгийн Өлгий сумаас Өмнөговь, Ховд сум дайран Баян-Өлгий аймгийн Өлгий хүртэл хатуу хучилттай авто замыг барихаар төлөвлөв. Ингэснээр зөвхөн хот хоорондын зам хатуу хучилттай болоод зогсохгүй тухайн чиглэл давхцаж байгаа сумууд хатуу хучилттай замаар аймгийнхаа төвтэй холбогдоно. Мөн Увс болон Баян-Өлгий аймгийн нүүрсний хэрэгцээг хангадаг Нүүрс Хотгор, Хар тарвагатайн нүүрсний уурхайнуудын замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөв.

Хүснэгт №4.14. Улс хот хоорондын болон нүүрсний уурхайнуудын шинээр байгуулах хатуу хучилттай замууд

№	Одоогийн байгаа зам	Хэрэгцээ	Төлөвлөлт		
			2015-2020	2021-2025	2026-2030
1	Улаангом-Ховд чиглэлийн А1701*	Орос,Хятадтай холбосон Хандгайт-Улаангом-Ховд-Ярантын баруун босоо тэнхлэгийн зам			
2	Улаангом Цагааннуур чиглэлийн А16	Увс аймгийнхан Цагааннуурын чөлөөт бүстэй холбогдоно. Нүүрс Хотгорын нүүрсний уурхайг хоёр аймагтай холбох боломж бүрдэнэ.			
3	Улаангом Цагааннуур чиглэлийн А16 замтай Хотгорын уурхайг холбох	Хотгорын нүүрсний уурхайг хоёр аймагтай хатуу хучилттай замаар холбосноор байгаль орчин, экологид эерэг нөлөө үзүүлнэ.			
4	/Өлгий сумаас/ замаас Баян –Өлгийн төв Өлгий чиглэлийн А07	Баруун босоо тэнхлэгийн замуудыг хооронд нь холбоно. Хотгорын нүүрсний уурхайг хоёр аймагтай холбоно.			
5	А07 замаас Хар тарвагатайн нүүрсний уурхай	Хар тарвагатайн нүүрсний уурхайг хатуу хучилттай болгосноор байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.			
6	Улаангом хотын дотор хатуу хучилттай зам барих				

**Монгол улсын УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Мянганы замын болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийн зам.*

Хүснэгт №4.15. 2015-2030 оны хооронд засахаар төлөвлөж байгаа орон нутгийн зам ба гүүрүүд

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ /км/	Тоо хэмжээ /км/	Хэрэгжүүлэх шалтгаан	Хөрөнгийн хэмжээ, /сая төг/, эх үүсвэр	2015-2020	2021-2025	2026-2030
1	Баруунтуруун сумын төвийн төмөр бетон гүүр	108 у/м	Төмөр бетон	Сумын төвд байсан модон гүүр эвдэрсэн	350.0 улсын төсөв			
2	Зүүнговь сумын Тохойн эхний Нарийний голын төмөр бетонон гүүр	28у/м	Төмөр бетон	Иргэдэд нийгмийн үйлчилгээ хүргэх	156.0 сая Улсын төсөв			

3	Ховд сумын Ховд голын төмөр бетонон гүүр	105 у/м	Төмөр бетон	Хадлангийн гол нутаг	800.0 улсын төсөв			
4	Цагаанхайрхан-Хяргас замын засвар	36.6	Замын бартааг засах	Сум хоорондын байнгын ашигладаг зам	72.0 орон нутгийн төсөв			
5	Зүүнговь сумын Гурмасны голын төмөр бетон гүүр	47 у/м	Төмөр бетон	Модон гүүр шаардлага хангахгүй байгаа	260.0 Улсын төсөв			
6	Ховд сумын Шивэрийн голын гүүр	80 у/м	Төмөр бетон	Нийтийн шаардлагаар	450.0 Улсын төсөв			
7	Өмнөговь сумын Намирын голын гүүр	80 у/м	Төмөр бетон	Модон гүүр шаардлага хангахгүй байгаа	450.0 Улсын төсөв			
8	Цагаанхайрхан сумын Хангилцгийн голын гүүр	36 у/м	Төмөр бетон	Нийтийн шаардлагаар	200.0 Улсын төсөв			
9	Улаангом хотын доторхи хатуу хучилттай авто зам	11.4км	Асфальт бетон	Хот хөгжүүлэх	Улсын төсөв			
10	Улаангomoос Увс нуурын хөвөө чиглэлийн хатуу хучилттай авто зам	25.8км	Асфальт бетон	Аялал жуулчлал хөгжүүлэх	Улсын төсөв			
11	Улаангomoос Хархираагийн амралт чиглэлийн хатуу хучилттай авто зам	28км	Асфальт бетон	Аялал жуулчлал хөгжүүлэх	Улсын төсөв			
12	Тариалан, Сагил, Давст, Түргэн сумуудыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох	67км	Асфальт бетон	Сум хөгжүүлэх	Улсын төсөв			
13	Гашууны голын гүүрийн их засвар	72 у/м	Төмөр бетон	Хуучин гүүр суултанд орсон ба хийц эдлэлүүд эвдэрсэн	Улсын төсөв			
14	Түргэн сумын Цалгарын голын гүүрийн их засвар	132 у/м	Төмөр бетон	Хуучин гүүр суултанд орсон ба хийц эдлэлүүд эвдэрсэн	Улсын төсөв			
15	Түргэн голын гүүрийн их засвар	186 у/м	Төмөр бетон	Хуучин гүүр суултанд орсон ба хийц эдлэлүүд эвдэрсэн	Улсын төсөв			

Эхний үе шат буюу 2015-2020 онд дагуу босоо тэнхлэгийн олон улсын А1701 буюу Улаангом-Ховд чиглэлийн 190 км замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөлөө. Ингэснээр Боршоо-Ярантын боомтууд хатуу хучилттай замаар холбогдон Оросын Холбооны улс, Хятад улсыг холбоно. Энэ нь олон улсын ачаа тээврийн чухал зам болно.


Мөн Хар тарвагатайн нүүрсийг Баян-өлгий, Увс, Ховд аймаг руу тээвэрлэхэд хялбар болж байна. Дээрх зам Тариалан сумын төвөөс 10 км зайтай өнгөрөх тус сумаас Улаангом руу зорчиход хялбар болж өгнө.

Улаангом хотын дотор 11.4 км 15 м өргөнтэй 5 тэрбум төгрөгийн өртөгтэй хатуу хучилттай зам барина. Эхний ээлжинд 9.4 км замыг барина.

Хоёрдугаар үе шат буюу 2021-2024 онд А16 чиглэлийн зам буюу олон улсын чанар А0306 ба А1702 чиглэлийн замуудыг холбосон замыг барихаар төлөвлөв. Энэ замыг барьснаар Улаангом Цагааннуурын чөлөөт бүстэй хатуу хучилттай замаар холбогдож Увс аймгийнхан чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахад хялбар болж байгаа юм. Нөгөөтэйгүүр

Хотгорын нүүрсийг Улаангом болон тус аймгийн сумууд руу тээвэрлэхэд хялбар болж эдийн засгийн хэмнэлт гарахаас гадна байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Баян-Өлгий аймгийхан ч нүүрсээ хатуу хучилттай замаар тээвэрлэдэг болно. Тус зам Хотгорын уурхайгаас 32 км зайтай байх тул түүнийг мөн хатуу хучилттай болгоно. Энэ замаас Бөхмөрөн сумын төв 7 км зайтай. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд Увс аймгийн нутагт 152 км, Баян-Өлгий аймгийн нутагт 35 км орчим зам барих шаардлагатай болно. Энэ замыг барихад Улаан даваа, Зэнхлэгийн даваануудыг засах бөгөөд байгалийн хүнд нөхцөлтэй.

Гуравдугаар үе шат буюу 2025-2030 онд А1701 чиглэлийн замаас салаалан /Увс аймгийн Өлгий сумаас буюу А1701 чиглэлийн замаас салаалан Өмнөговь, Ховд сум дайруулан Өлгий хүртэл/ А07 чиглэлийн замыг барихаар төлөвлөв. Тус замыг барихад Увс аймгийн нутагт 124 км, Баян-Өлгий аймгийн нутагт 71 орчим км зам барих шаардлагатай болж байна. Энэ зам баригдснаар Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн төвүүд хатуу хучилттай замаар холбогдсон цагираг үүсэх бөгөөд тээврийн сүлжээнд хүндрэл үүсэхгүй болно. Үүний хамт замд нь байгаа Өмнөговь, Ховд сумууд хатуу хучилттай замаар аймгийнхаа төв болон Өлгий, Ховдтой шууд холбогдоно.



Зураг №4.3. Авто замын газрын төлөвлөлтийн зураг

Хүснэгт №4.16. 2015-2030 онд шинээр баригдах хатуу хучилттай авто замууд шаардагдах хөрөнгө оруулалт

№	Авто замын чиглэл	Замын нэр	Хучилтын төрөл	Нийт зай, км	Хөрөнгө оруулалт тэрбум.төг
1	A1701	Улаангом-Ховд	Хатуу хучилттай	190.0	108.3
2		Улаангом сумын төв	Хатуу хучилттай	11.4	5.0
				201.4	113.3
3	A16	Улаангом-Цагааннуур	Хатуу хучилттай	152.0	95.0
4		A16 засмал замаас-Хотгорын уурхай	Хатуу хучилттай	32	21.0
				184.0	116.0
5	A07	A07 /Өлгий сумаас/ замаас Баян –Өлгийн төв Өлгий	Хатуу хучилттай	124.0	75.0
6		A1701 зам-Хар тарвагатай	Хатуу хучилттай	22.0	17.0
				146.0	92.0
Бүгд				531.4	321.3

Хүснэгт №4.17. Замын зурвас газрын тооцоо

№	Автозамын чиглэл	Замын нэр	Замын урт /км/	Замын зурвас газрын талбай /га/
1	A1701	Улаангом-Ховд	190.0	380.0
2		Улаангом сумын төв	11.4	11.4
3	A16	Улаангом-Цагааннуур	152.0	304.0
4		A16 засмал замаас- Хотгорын уурхай	32.0	64.0
5	A07	A07 /Өлгий сумаас/ замаас Баян – Өлгийн төв Өлгий	124.0	248.0
6		A07-Хар тарвагатай	22	44
			541.4	1051.4

Дээрх төлөвлөж байгаа замуудыг 2015-2030 онд барьж байгуулахад 2015-2020 онд 113.3, 2021-2025 онд 116.0, 2026-2030 онд 92.0 тэрбум төгрөг буюу нийт 321.3 орчим тэрбум төгрөгний хөрөнгө шаардагдана. Эдгээр замуудад 1043.4 га газар ашиглагдах болно. Харин орон нутгийн чанартай зам, гүүрүүдийг барьж байгуулах засварлахад 1104.0 сая төгрөг шаардагдана.

Хүснэгт №4.18. Орон нутгийн чанартай авто замын сүлжээний хэтийн төлөв

/ хатуу хучилттай замаас сумдын төвийн холбогдох зай /

№	Авто замын чиглэл	Хучилтын төрөл	Аймгийн төвөөс	Хатуу хучилттай авто замаас сумын төв хүртлэх зай /км/
1	Баруунтуруун	Ердийн хөрсөн	193.0	83.0
2	Бөхмөрөн	Ердийн хөрсөн	174.0	7.0
3	Давст	Ердийн хөрсөн	136.0	27.0
4	Завхан	Ердийн хөрсөн	161.0	80.0
5	Зүүнговь	Ердийн хөрсөн	139.0	128.0
6	Зүүнхангай	Ердийн хөрсөн	357.0	46.0
7	Малчин	Ердийн хөрсөн	93.0	93.0
8	Наранбулаг	Хатуу хучилттай	90.0	0.0
9	Өлгий	Хатуу хучилттай	113.0	0.0
10	Өмнөговь	Хатуу хучилттай	109.0	0.0
11	Өндөрхангай	Ердийн хөрсөн	286.0	18.0
12	Сагиль	Ердийн хөрсөн	61.0	7.0
13	Тариалан	Ердийн хөрсөн	30.0	10.0
14	Түргэн	Ердийн хөрсөн	36.0	4.0
15	Тэс	Ердийн хөрсөн	155.0	155.0
16	Ховд	Хатуу хучилттай	177.0	0.0
17	Хяргас	Ердийн хөрсөн	163.0	106.0
18	Цагаанхайрхан	Ердийн хөрсөн	226.0	48.0
19	Улаангом			
		Нийт	2705.0	812.0
		Хатуу хучилттай	489.0	
		Ердийн	2226.0	

Эдгээр замууд ашиглалтанд орсноор Увс аймаг хил залгаа ОХУ болон Баян-Өлгий, Ховд, Завхан аймгуудтай хатуу хучилттай замаар холбогдсон байна.

2030 он гэхэд Улаангом нь баруун босоо тэнхлэгийн хатуу хучилттай зам болон Өлгий, Ховд болон тус улсын бусад аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар бүрэн холбогдсон байна. Нөгөөтэйгүүр тус аймгийн Хар тарвагатай, Нүүрст хотгорын уурхайнууд хатуу хучилттай замтай болно. Ингэснээр ачаа тээвэр, зорчигчдын урсгал түргэн шуурхай болж цаг хугацаа хэмнэхээс гадна ердийн хөрсөн замтай байх үед замын

тоос шороонд дарагдан, хөрс их хэмжээгээр эвдэрч, ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, байгаль-экологи их хэмжээгээр сүйтгэгдэж байсан байдал арилж байгаль экологид эерэг нөлөө үзүүлэх болно. Авто замд оруулсан хөрөнгө оруулалт экосистемийг сүйтгэсэн хохирлыг бууруулах зардалтай харьцуулахад 30 дахин бага юм. Мөн сумдын хувьд зарим сум хатуу хучилттай замтай болох ба хатуу хучилттай замаас салаалан сумын төв хүрдэг болж ердийн хөрсөн замаар явах хэмжээ эрс багасах буюу 2226 км байснаа 812 км болно.

Агаарын тээврийн барилга байгууламж

Улаангомьн Цагаан Дэглий нисэх буудал нь хатуу хучилттай нисэх буух зурвастай, цаашид тус буудлыг өргөтгөх талаар ямар нэг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно. Хуучин тус аймгийн бүх сумуудад бага оврын нисэх онгоц хүлээн авах буудалтай байсан ба одоо ашиглагдаж байгаа буудал байхгүй байна.

Төмөр замын газар

Увс аймгийн төмөр замын сүлжээг “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан төмөр замын сүлжээг барьж дуусгах” гэсэн зорилтын дагуу төлөвлөв.

“Төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын 2010 оны 32 тогтоол батлагдан гарсан бөгөөд түүнд хэтийн хугацаанд барих төмөр замын чиглэл гарсан билээ. Увс аймгийн нутгаар тавигдах төмөр зам нь Дөрвөлжин-Цагаанхайрхан, Мөрөн-Цагаанхайрхан, Цагаанхайрхан-Улаангом, Улаангом-Цагааннуур, Цагаанхайрхан-Арцсуурь гэсэн чиглэл байх юм. Энэ чиглэлийн дагуу тус аймгийн нутгаар тавигдах төмөр замд ашиглагдах газрын тооцоог хийлээ. Дээрх чиглэлийн төмөр замын баригдах хугацааг одоогоор төвлөх боломж байхгүй байна.

Хүснэгт №4.19. Төмөр зам ашиглагдах газрын тооцоо

Сумдын нэр	Нийт урт	Үүнээс өртөөний урт /км/	Замын зурвас газар /га/	Өртөөний Тоо /ш/	Өртөөний газар /га/
Дөрвөлжин-Цагаанхайрхан	116	6	1320	3	180
Цагаанхайрхан-Улаангом	224	10	2568	5	300
Улаангом-Цагааннуур	184	10	2088	5	300
Цагаанхайрхан-Мөрөн	101	6	1145	3	180
Цагаанхайрхан-Арцсуурь	80	6	888	3	180
Дүн	705	38	8009	19	1140

Тайлбар : Өртөөний газрыг 2 км урт, 300 м өргөнөөр, төмөр замын зурвас газрын өргөнийг 120 м төлөвлөв.

Дээрх төмөр зам баригдснаар төмөр замын зурвас газарт 8009 га, өртөөний зориулалтаар 1140 га, нийт 9149 га газар шинээр ашиглагдахаар байна.

4.3. Шугам сүлжээний газрын төлөвлөлт

Холбоо мэдээллийн сүлжээний төлөвлөлт

Тус аймгийн нийт 17 сум аймгийнхаа төвтэй шилэн кабелиар холбогдсон бөгөөд шилэн кабелийн урт 1145 км урт байна. Аймгийн хэмжээнд ганц Тэс сум шилэн кабелид холбогдоогүй, Vsat станцаар холбогдсон байгааг 2015-2020 онд шилэн кабелиар аймгийн төвтэй холбоно. 157 км урт шилэн кабелийн шугам байгуулснаар Увс аймгийн бүх сум шилэн кабелийн сүлжээнд холбогдоно. Мөн зарим боломжтой уурхай, амралт сувилалын газрууд шилэн кабелийн сүлжээнд холбогдож интернет болон бусад холбооны үйлчилгээг

авах боломжоор бүрэн хангагдана. Ингэснээр 2030 онд тус аймгийн холбоо мэдээллийн сүлжээнд интернет, тоон технологи бүрэн нэвтэрсэн байна. Өргөн уудам газар нутагт байнга нүүдэллэн амьдарч байгаа хөдөөгийн малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээгээр хангахад хиймэл дагуул ашиглан шийдвэрлэсэн байна.

Цахилгаан эрчим хүчний сүлжээний төлөвлөлт

Эрчим хүчний яамнаас 2014 оныг бүтээн байгуулалтын жилээр онцолсонтой холбогдуулж Улаангом аймгийн төвд 35 мВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станцыг барьж байгуулсан. Эхний ээлжинд 9 дүгээр сарын 11-нээс эхлэн туршилт тохируулгын ажлыг эхлэн хэрэглэгчдэд халаалт, хэрэглээний халуун усны хангалт хийж байна.

Баруун 3 аймаг нь цахилгаан эрчим хүчний хэрэглээнийхээ 76 орчим хувийг Оросын холбооны улсаас авдаг бөгөөд Дөргөн, Тайширын усан цахилгаан станц үлдсэн хувийг хангадаг байна. Оросын холбооны улсад манай аймаг жилд дунджаар 7 орчим тэрбум төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт өгдөг байна. Иймд Улаангом аймгийн төвд шинээр баригдсан энэхүү дулааны станцын үүрэг их юм.

Мөн Завхан сумаас Хэцүү хад, Тэс сумаас Шар суурийн боомт, Цагаанхайрханы Хунт, Хулж багуудад цахилгаан дамжуулах агаарын шугам татах зэрэг ажлууд хийгдэх бөгөөд цаашид амралтын бааз, томоохон багуудад цахилгаан эрчим хүч татах ажлууд хийгдэхээр төлөвлөөд байна. Завхан сумын төвийн 15 кВ-ын дэд станц, 0.4 кВ-ын агаарын шугам шинэчлэх ажлыг 135.0 сая төгрөгөөр хийлгэхээр төлөвлөөд байна.

Улаангом хотод 60 Мвт-ын цахилгаан станц 9.5 га газарт 2015-2020 онд баригдахаар төлөвлөөд байна.

Усны эрчим хүч ашиглалт

Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн хангамжаас алслагдсан нутгийг цахилгаанаар хангах, усны нөөцөө зүй зохистой иж бүрэн ашиглах шаардлагыг дээшлүүлэх үүднээс усан цахилгаан станцыг байгуулан ашигладаг. /1975 онд зохиогдсон БНМАУ-ын Усны нөөцийг нэгдмэлээр ашиглах ба хамгаалах ерөнхий схем/

Ойрын ирээдүйд барих шаардлагатай гэж үзсэн усан цахилгаан станцуудын байршил шаардагдах газрын хэмжээг хүснэгт-4.25.-д харуулав.


Хүснэгт №4.20. Шинээр баригдах Цахилгаан станцууд

№	Аймаг	Сум	Голын нэр	Төрөл	Газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа
1	Увс	Тариалан	Хархираагийн гол	УЦС	996.0	2020 он хүртэл
2	Увс	Баруунтуруун	Баруун турууны гол	УЦС	2007.0	2020 он хүртэл
	Дүн				57169.0	

Эдгээр усан цахилгаан станцуудыг барьж байгуулах хугацааг Увс аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийн үе шатуудтай нь уялдуулан авч үзэхэд үе шатуудаар хуваах боломж багатай юм.

Хүснэгт №4.21. Шинээр баригдах Усан цахилгаан станцад шаардагдах нийт газар

№	Аймаг	Шаардагдах газар* /га/
1	Увс	3003.0



Зураг №4.4. Эрчим хүчний шугам сүлжээ, эрчим хүч үйлдвэрлэлийн байгууламжын төлөвлөлтийн зураг

Увс аймгын сумдаас ирсэн саналууд

1. Цагаанхайрхан сум: Сумын төв дундуур урсах Мөндөөхэй голын зүүн хэсгийн суурьшлийн бүсэд цахилгаан, тог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн улсын чанартай авто зам дагуу хэд хэдэн газар суурьшлийн бүс байгуулах боломжтой байна. Учир нь хүмүүсээс санал их ирж байгаа тул зайлшгүй шаардлагатай байна. Шинэ суурьшлийн бүс бий болохтой уялдуулаад цахилгаан дамжуулах агаарын шугам тавих хэрэгтэй байна. Энэ газруудад /автозамын дагуу орших/

- Үзүүрийн булаг орчимд /гуанзтай газар/
- Хулж баг, Хунт багын архан зам дагуу суурьшлийн бүс байгуулах боломж байна. /Хулж баг, Хунт баг хоёр нь зэргэлдээ шахуу ойр оршдог байна/

2. Завхан сум: Завхан сумын “Хэцүү хад”-ын үзэсгэлэнт газарт аялал жуулчлал түлхүү хөгжүүлэх боломжтой бөгөөд үүнтэй холбогдуулан эрчим хүч цахилгаан тавихаар төлөвлөж байгаа. Завхан сумын тэг гортиг зүүн хойшоо тэлэхтэй уялдуулж тог, цахилгаанаа тэр чиглэлд нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн Завхан сумын төвд 15 кВ-ын дэд станц, 0.4 кВ-ын агаарын шугам шинэчлэх ажил төлөвлөгдөөд байна.
3. Бөхмөрөн сум: Олон нуур орчмын хилийн газрыг огт ашиглахгүй байна. Энд байгалийн үзэсгэлэнт газар, олон өнгийн нууртай, Вансэмбэрүү цэцэг ургадаг. Иймээс энэ газрыг ашиглахын тулд аялал жуулчлалын бүс байгуулж, улмаар зам тавиж, тог цахилгаан тавих шаардлагатай байна.
4. Өмнөговь сум: 8 га газар салхины эрчим хүчний газар авсан. Станц бариулахаар төлөвлөж байна.
5. Баруунтуруун сум: Баруунтурууны нөөц онгоцны буудлыг 2016 онд ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байна. Иймд онгоцны буудал руу 10 кВт-ын шугам татах шаардлагатай байна.
6. Ховд сум: Сумын төвөөс зүүн урагш төв зам дагуу тэлж үйлдвэр, суурьшлийн бүс байгуулах боломжтой. 10 кВт-ын цахилгааны шугам татах шаардлагатай байна. Мөн одоогийн суурьшлын бүс дэх иргэдийн өмчилж авсан газраар өндөр хүчдэл бүхий цахилгааны шугам дайрсан газрыг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олгох шаардлага тулгараад байна.
7. Наранбулаг сум: Сумын төвийн тэг гортиг дотроо зүүн болон зүүн хойд зүгт иргэдэд шинээр газар өмчлүүлэхээр төлөвлөж байгаа. Үүний тулд тог, гэрэл цахилгаан татаж нэмэгдүүлэх шаардлагатай байна.
8. Тэс сум: Таван улиасаас Шар үзүүр хүртэл цахилгаан дамжуулах шугам шинээр татах,
9. Зүүнговь сум: Баруунтуруун сумруу явах хар шороон зам дагуу 3 га газрыг шинээр өмчлүүлэхээр төлөвлөж байна. Шинээр үүсэх суурьшлийн бүсийг дагаад тог цахилгаан нэмэгдүүлэх шаардлагатай байна.
10. Тариалан сум: Сумын төвийн тэг гортиг урагшаа замруугаа тэлэх хандлагатай байна. Үүнийг дагаад тог цахилгааныг нэмэгдүүлэх шаардлага байна.
11. Өндөрхангай сум: Сумын төвийн тэг гортиг дотор зүүн болон зүүн хойд хэсгээр суурьшлийн бүс, орон сууцны бүс төлөвлөгдсөн байна. Шинээр үүсэх суурьшлийн бүсээ дагаад цахилгаан нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Дулааны шугам сүлжээ, үйлдвэрлэлийн байгууламж

Дулааны станц нь дунд чадлын төвлөрсөн халаалтын зуухнаас дулааны сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдийг дулаанаар хангаж байна. Хүснэгт 4.27.-оос үзэхэд Улаангом хотын одоо байгаа дунд чадлын зуухтай Дулааны станц 2020 оны төвшний дулааны хэрэглээг хангах боломжтой байна.

Хүснэгт №4.22. Аймгын төвийн дулаан хангамжийн систем, Өсөлтийн шинжилгээний нэгдсэн дүн

№	Аймгийн төв	Одоо байгаа дулаан хангамжийн систем 2012 онд	Дулааны ачаалал (алдагдал ороогүй) 2012		Дулааны сүлжээ	Дулааны нягтрал	Дулаан хангамжийн оновчтой систем 2012	Дулааны ачаалал (алдагдал ороогүй) 2020		Дулааны сүлжээ	Дулааны нягтрал	Дулаан хангамжийн оновчтой систем 2020
			15.0	14.5				34.1	39.7			
1	Улаангом	ДЧХЗ/ДШ	15.0	14.5	5.4	2.7	ДЧХЗ/ДШ	34.1	39.7	11.2	3.5	ДЧХЗ/ДШ

Эх сурвалж: ТЗЭ, ЭХТ-ын өгөгдөл ба Зөвлөхийн тооцоо Тэмдэглэгээ: БЧХЗ/ДШ-Бага чадлын зуух дулааны сүлжээтэй, ДЧХЗ/

Улаангом хотод баригдсан 35 мВт-ын хүчин чадалтай дулааны станц, шугам сүлжээ, дулаан дамжуулах төвүүд энэ оны 09 дүгээр сарын 11-нээс эхлэн ашиглалтанд ороод байна. Шинэ дулааны станц нь нийтдээ 7 дулаан дамжуулах төвтэй /ДДТ/ бөгөөд одоогийн байдлаар ДДТ2, ДДТ6-ийн хэрэглэгчид холбогдож, халаалт, хэрэглээний халуун усаар хангаж байна.

Увс аймгийн Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд тусгагдсан “Сумдын төвийн төвлөрсөн дулаан хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд Увс аймгийн Завхан, Зүүнговь, Малчин, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Өндөрхангай, Сагил, Тариалан, Түргэн, Ховд, Хяргас, Цагаанхайрхан сумын төвийн хэрэглэгчдийг халаалтын нэг зуухны газраас төвлөрсөн байдлаар дулаанаар хангах зуухны газар, дулааны шугам сүлжээг шинээр барихаар төлөвлөөд байгаа. Одоогийн байдлаар сонгон шалгаруулалтын үе шатандаа явж байна.


Увс аймгын сумдаас ирсэн саналууд:

1. Малчин сум: Сумын төв дотроо шинэ уурын зуух барихаар төлөвлөсөн.
2. Сагил сум: Сумын төвийн дулааны хэргцээг хангах уурын зуух барихаар төлөвлөж байгаа.

ТАВДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**5.1. Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал****5.1.1. Увс аймгийн ойн сангийн газрын өнөөгийн байдал, өөрчлөлт**Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал

Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ. Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 м газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сангийн газарт хамаарна. Увс аймгийн ойн сангийн талбайг газрын төрлөөр ангилагдсан байдлыг зураг№5.1.-д харуулав.

Зураг№5.1. Увс аймгийн ойн сангийн талбай газрын төрлөөр ангилагдсан байдал



Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилна. Ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагдана. Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой байгаа (0.3 ба түүнээс дээш өтгөрөлтэй) болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд одоогийн байдлаар ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд (ойжиж байгаа газар, тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай г.м) тус тус хамрагдана.

Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, жижиг нуур цөөрөм, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд орно. Ойн сангийн нийт талбай 236629 мян.га, үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 200929 мян.га, байгалийн ой 197347 мян.га аймгийн нийт нутаг дэвсгэрийн 3.4 хувийг ойн талбай эзэлнэ.

Ойн сангийн нийт талбайн 98.16 хувийг ойн талбай, 1.84 хувийг ойн бус талбай эзэлж байна. Ойн талбайн 86.51 хувь нь ойгоор бүрхэгдсэн 13.49 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай эзэлж байна.

Ойгоор бүрхэгдсэн талбайн 98.22 хувийг байгалийн, ой 0.02 хувийг таримал ой, 1.76 хувийг торлог, ойгоор бүрхэгдээгүй талбайн 85.11 хувийг тармаг мод, 6.52 хувийг шатсан ойн талбай, 6.28 хувийг мод бэлтгэсэн талбай 2 хувийг ойжих талбай 0.09 хувийг хортон шавьж өвчинд нэрвэгдсэн талбай тус тус эзэлж байна.

Увс аймгийн ой гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд бүрэлдэхүүний хувьд шилмүүст ой зонхилон ургасан байна. Бут сөөг ихэнхдээ гол горхины дагуу тархан ургана. Байгалийн ойн талбайг модны төрлөөр талбай, нөөцийг хүснэгт 5.1-д харуулав.

Хүснэгт №5.1. Байгалийн ойн талбай


Д/д	Төрөл зүйл	Ойн талбай	Эзлэх хувь	Ойн нөөц /шоометр/
1	Шинэс	141357 га	71.1	18904610
2	Хуш	1527	0.77	249720
3	Гацуур	330	0.16	249720
4	Хус	1315	0.66	249720
5	Улиас	11140	5.6	707330
6	Бургас	41678	21.1	1021820
	Дүн	197347	100.0	20961670

5.1.2. Ойн сангийн өөрчлөлт

Аймгийн ойн сангийн өөрчлөлтийг хүснэгт 5.2- д үзүүлэв.

Хүснэгт №5.2. Увс аймгийн ойн сангийн газрын өөрчлөлт

Үзүүлэлт	Газрын нарийвчилсан судалгаа		
	1990, 2000 оны	2012 оны	Өөрчлөлт
1. Ойгоор бүрхэгдсэн талбай	139588	200929	61341
Байгалийн ой	136192	197347	61155
Сөөг, торлог	3396	3552	156
Таримал ой	-	30	30
Газар нутгийн ойрхог чанар %		3,44	
2. Ойгоор бүрхэгдээгүй талбай	20591	31346	10755
Тармаг ой	10363	26678	16315
Түймэрт нэрвэгдсэн ой /мян,га /	152	2042	1890
Мод бэлтгэсэн талбай	7137	1971	-5166
Байгалийн аясаар ойжих талбай	2939	629	-2310
Зориудаар ойжуулсан талбай / га/	-		
Хөнөөлт шавжинд нэрвэгдсэн талбай	-	26	26
Салхи цасанд унасан ой	-		
3. Ойн талбай/1+2/	160179	232275	72096
4. Ойн бус талбай	25384	4354	-21030
Ойн сангийн нийт талбай, га/3+4/	185563	236629	51066



Зураг№5.2. Ойн сангийн ангиллын зураг

5.2. Ойн сан бүхий газрын ашиглалт хамгаалалтын менежмент

Ойн сан бүхий газрын төлөвлөлтийг ойрын болон дунд хугацааны /2015-2020он/, Алс хэтийн /2020-2030он/ гэсэн 2 хугацаагаар төлөвлөсөн бөгөөд 2015-2020он хүртэлх хугацаанд ойн сангийн газрын ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх арга хэмжээг ойн зохион байгуулалт, ойн тооллогын материалд тулгуурлан сум тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан бөгөөд 2020-2030 оны төлөвлөлтийг одоогийн ойн санд оруулж буй хөрөнгө оруулалт, ойн ангийн хүчин чадал зэргээс харгалзан ерөнхийлөн төлөвлөсөн болно.

5.2.1. Ойрын болон дунд хугацааны төлөвлөлт /2015-2020он/

Ойг хамгаалах арга хэмжээ

Аймгийн захиргаа, Байгаль орчны алба бусад холбогдох байгууллагуудаас ойг хамгаалах талаар багагүй арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч сүүлийн 5 жилд 15

суманд 23 удаа ой хэрийн түймэр гарч, байгаль экологид 2.4 тэрбум төгрөгний хохирол учруулжээ. Мөн түүнчлэн аймгийн хэмжээнд явуулсан ой зохион байгуулалтын материалаас үзэхэд түймэрт нэрвэгдсэн 2042 га ойн талбай байна. Мөн түүнчлэн сүүлийн судалгаагаар тус аймагт зайлшгүй ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлагатай 30437 га талбай байгаа нь тогтоогджээ. Иймээс цаашид ойг түймэр, ойн хөнөөлт шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын ажлын зэрэгцээ түймрийн шороон зурвас байгуулах, ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг 2015-2020 онд төлөвлөсөн болно. Энэ арга хэмжээг хүснэгт 5.3, 5.4-д харуулав.

Хүснэгт №5.3. Увс аймгийн 2015-2020 онд байгуулах түймрийн зурвас

Д/д	Сумын нэр	5 жилд байгуулсан түймрийн зурвас, га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Баруунтуруун	6	5			5			10
2	Бөхмөрөн								
3	Давст								
4	Зүүнхангай		5						5
5	Малчин							5	5
6	Наранбулаг							5	5
7	Өндөрхангай						5		5
8	Сагил	44		5					5
9	Тариалан								
10	Түргэн					5			5
11	Тэс								
12	Ховд								
13	Хяргас								
14	Цагаанхайрхан			5			5		10
15	Улаангом								
	Аймгийн дүн	50	10	10		10	10	10	50

Ойн тооллого ой зохион байгуулалтын зураг, тайлангаас үзэхэд Увс аймгийн хэмжээнд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлагатай байгаа 30437га талбай байгаа бөгөөд 2020 он хүрэтл хугацаанд 50500 га талбайд хортонтой тэмцэх ажлыг зохион байгуулсан байхаар төлөвлөв. Үйлдсэн хэсгийг 2020 оноос хойш гүйцэтгэх бөгөөд 2020 онд дахин судалгаа хийж ойн хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн талбай нэмэгдсэн эсэхийг судалсны үндсэн дээр нарийвчилсан төлөвлөгөө гаргах нь зүйтэй юм.


Хүснэгт №5.4. Увс аймгийн ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлагатай талбай

Д/д	Сумын нэр	Зайлшгүй тэмцэл явуулах талбай		Зүйлийн нэр
		Талбайн хэмжээ	Хэсэглэлийн дугаар	
1	Өндөрхангай	9601	1, 2, 4, 15-18, 22, 24	Шилмүүс хөндийлөгч
2	Зүүнхангай	5946	4, 8, 11, 7, 12, 9, 10, 16	
3	Баруунтуруун	11136	4-10, 13-18	
4	Хяргас	811	6	Шилмүүс хөндийлөгч, Эгэл бийрэн сүүлт
5	Малчин	2943	4-6	Якобсоны төөлүүрч эрвээхэй
	Дүн	30437		

Хүснэгт №5.5. Увс аймгийн 2015-2020 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх төлөвлөгөө

Д/д	Сумдын нэр	Хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцсэн талбай	Тэмцэл явуулах шаардлага тай талбай /га/	Он						
				2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Баруунтуруун		11136	2000	3500		2000	1000		9500
2	Бөхмөрөн									

3	Давст											
4	Зүүнхангай		5946		1500		2000		2000	5500		
5	Малчин		2943	2000	1000	3000				6000		
6	Наранбулаг											
7	Өндөрхангай		9601	2000	3500	3500	2000	2000	1000	13000		
8	Сагил											
9	Тариалан											
10	Түргэн											
11	Тэс											
12	Ховд											
13	Хяргас		811	2000	1000	1000	2000	2500	2500	11000		
14	Цагаанхайрхан				1500			2500	2500	6500		
15	Улаангом											
	Аймгийн дүн		47829		30437	8000	11000	7500	8000	7000	9000	50500




Зураг №5.3. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх газруудын байршил

Ойн ашиглалт, арчилгаа цэвэрлэгээ хийх арга хэмжээ

Өнгөрсөн 5 жилд тус аймгийн хэмжээгээр нийт 187.8 мянган шоометр мод арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсний дотор хэрэглээний зориулалтаар 26.3 мянган шоометр, түлээний зориулалтаар 161.4 мянган шоометр мод байгаа юм. 2015-2020 онд бэлтгэсэн модны ашиглалтыг сайжруулах, түлшинд өөр төрлийн бүтээгдэхүүн орлуулах зорилт тавьж, мод бэлтгэх модны хэмжээг өнгөрсөн оны түвшинд төлөвлөсөн болно. Тухайлбал ирэх 6 жилд 5956 га талбайгаас 121500 шоометр модыг бэлтгэж ашиглана. 2015-2021 онд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэж ашиглах нийт модны хэмжээг хүснэгт№5.6.-д үзүүлэв.

Хүснэгт№5.6. 2015-2020 онд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэж ашиглах модны дээд хэмжээ/сумдаар/

д/д	Сумдын нэр	Ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай		2013 онд бэлтгэсэн модны хэмжээ	2015		2016		2017		2018		2019		2020		Дүн	
		Талбай га	Гарах нооц шоом		Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом	Талбай га	Нооц шоом
1	Баруунтуруун	325	7140	2307	75	1200	75	1200	76	1200	76	1200	76	1200	76	1200	454	7200
2	Бөхмөрөн	-	-	430	14	1100	14	1100	15	1100	15	1100	15	1100	15	1100	88	6600
3	Давст	-	-	1927	61	1500	61	1500	61	1500	61	1500	63	1500	63	1500	370	9000
4	Зуунхангай	8777	192760	3500	109	1800	109	1800	109	1800	109	1800	110	1800	110	1800	656	10800
5	Малчин	437	8402	1860	59	1000	59	1000	60	1000	60	1000	60	1000	60	1000	358	6000
6	Наранбулаг	1144	1440,0	1012	31	500	31	500	33	500	33	500	33	500	33	500	194	3000
7	Өндөрхангай	-	-	5167	162	4000	162	4000	162	4000	162	4000	163	4000	163	4000	974	24000
8	Сагил	1038,0	29690,0	1112	36	1800	36	1800	38	1800	38	1800	39	1800	39	1800	226	10800
9	Тариалан	-	-	212	7	100	7	100	8	100	8	100	8	100	8	100	46	600
10	Түргэн	458	7520	2158	69	1200	69	1200	70	1200	70	1200	70	1200	70	1200	418	7200
11	Тэс	-	-	2586	81	1300	81	1200	82	1200	82	1200	82	1200	82	1200	490	7800
12	Ховд	-	-	1150	38	1350	38	1350	38	1350	38	1350	39	1350	39	1350	230	8100
13	Хяргас			2318	73	1200	73	1200	74	1200	74	1200	75	1200	75	1200	444	7200
14	Цагаанхайрхан	799	30940	2567	81	1200	81	1200	82	1200	82	1200	82	1200	82	1200	490	7200
15	Улаангом			2675	84	1000	84	1000	85	1000	85	1000	86	1000	86	1000	510	6000
16	Аймгийн дүн	16586	414950	30981	983	20250	983	20250	993	20250	993	20250	1002	20250	1002	20250	5956	121500



Зураг №5.4. Ойн арчилгаа цэвэрлэгээний огтлолт хийх шаардлагатай газрын байршлын зураг

Ойг нөхөн сэргээлт, байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээ


Тус аймгийн хэмжээнд өнгөрсөн 5 жилд нийт 893 га талбайд ойжуулалт, 130 га талбайд байгалийн сэргэн ургалданд туслах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Гэтэл тус аймгийн хэмжээнд түймэрт нэрвэгдсэн, мод бэлтгэлийн ажил явуулсан 13013 га талбай байгаа юм. Иймээс ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг цаашид нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймээс ойжуулалтын болон байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын хэмжээг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. 2015-2020 онд ойжуулах болон байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын хэмжээг хүснэгт 5.7, 5.8-д харуулав.

Хүснэгт №5.7. 2015-2020 онд ойжуулах талбай, га

д/д	Сумдын нэр	Ойжуулах шаардлагатай талбай га			5 жилд ойжуулсан талбай га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
		Түймэрт нэрвэгдсэн	Мод бэлтгэсэн	Нийт								
1	Баруунтуруун	325	30	355	50							
2	Бөхмөрөн	-	35	35	70							
3	Давст	-	-	-	30							
4	Зүүнхангай	-	61	61	-							
5	Малчин	80	-	80	50							
6	Наранбулаг	78	-	78	30	5	5	5	5	10	15	45
7	Өндөрхангай	949	605	1554	123							
8	Сагил	372	21	393	60							
9	Тариалан	-	60	60	30	5	5	10	10	10	15	55
10	Түргэн	-	266	266	-	5	5	5	5	10	15	45
11	Тэс	-	-	-	10							
12	Ховд	-	-	-	-							
13	Хяргас	-	71	71	50							
14	Цагаанхайрхан	396	649	1045	-							
15	Улаангом		15	15	295	5	5	5	10	10	15	50
16	Өмнөговь				-							
17	Өлгий				-							
18	Завхан				15	5	10	10	10	10	15	60
19	Зүүнговь				80							
	Аймгийн дүн	2042	10971	13013	893	25	30	35	40	50	75	255

Хүснэгт №5.8. 2015-2020 онд байгалийн сэргэн ургалтанд туслах талбай, га

д/д	Сумдын нэр	Ойжуулах шаардлагатай талбай га			5 жилийн арга хэмжээ га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
		Түймэрт нэрвэгдсэн	Мод бэлтгэсэн	Нийт								
1	Баруунтуруун	325	30	355	90		30	35	35	40	40	180
2	Бөхмөрөн	-	35	35								
3	Давст	-	-	-								
4	Зүүнхангай	-	61	61		20	25	25	30	30	30	130
5	Малчин	80	-	80								
6	Наранбулаг	78	-	78								
7	Өндөрхангай	949	605	1554		10	15	15	20	20	20	80
8	Сагил	372	21	393								
9	Тариалан	-	60	60								
10	Түргэн	-	266	266								
11	Тэс	-	-	-	40		10	15	15	20	20	80
12	Ховд	-	-	-								
13	Хяргас	-	71	71								
14	Цагаанхайрхан	396	649	1045		10	10	10	20	20	20	70
15	Улаангом		15	15								
16	Өмнөговь											
17	Өлгий											
18	Завхан											
19	Зүүнговь											
	Аймгийн дүн	2042	10971	13013	130	-	80	100	100	130	130	540



Зураг№5.5. Ойн нөхөн сэргээлт хийх, байгалийн сэргэн ургалтад туслах шаардлагатай газрын байршлын зураг

5.2.2. Хэтийн төсөөлөл

Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний алс хэтийн 2021-2030 оны төсөөллийг гаргахдаа одоогийн ойн хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хийж буй ажлын хэмжээ, ой ангийн хүчин чадалд үндэслэн алс хэтэд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулав. Хэтийн төсөөллийг аймгийн хэмжээнд баримжаалан хийсэн бөгөөд сумдаар төлөвлөх боломжгүй бөгөөд ой зохион байгуулалтын материалд тулгуурласан ойрын хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлж дууссаны дараа дахин судалгаа явуулж ойг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай газруудыг тогтоон нарийвчилсан төлөвлөгөө хийх шаардлагатай. Ойг хамгаалах арга хэмжээний хувьд төв, орон нутгийн уламжлалтын зохион байгуулалтын ажлыг харуулах боломж хязгаарлагдмал юм. Мөн түүнчлэн ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтыг 2017 онд зогсоохоор ойрын зорилт болгон дэвшүүлсэн болно. Иймээс тухайн үеийн ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгаанд тулгуурлан 2021-2030 онд тэмцэх ажлыг төлөвлөх боломж бүрдэнэ. 2021-2030 онд байгуулах түймрийн зурвасны хэмжээг хүснэгт 5.9-д харуулав.

Хүснэгт №5.9. Увс аймгийн 2021-2030 онд байгуулах түймрийн зурвас, га

Д/д	Сумын нэр	2015-2020 оны түймрийн зурвас га	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Баруунтуруун	10	30	30	60
2	Бөхмөрөн		25	25	50
3	Давст		30	30	60
4	Зүүнхангай	5	25	25	50
5	Малчин	5	20	20	40
6	Наранбулаг	5	20	20	40
7	Өндөрхангай	5	24	24	48
8	Сагил	5	30	30	60
9	Тариалан		25	25	50
10	Түргэн	5	30	30	60
11	Тэс		40	40	80
12	Ховд		25	25	50
13	Хяргас		30	30	60
14	Цагаанхайрхан	10	30	30	60
15	Улаангом		25	25	50
	Аймгийн дүн	50	409	409	818

Хүснэгт №5.10. Увс аймгийн 2021-2030 онд ойн арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх модны хэмжээ/сумдаар/

Д/д	Сумдын нэр	2015-2020 оны		2021-2025 он		2026-2030 он		2021-2030 оны дүн	
		Нийт	дундаж	Талбай га	Нөөц ш.м	Талбай га	Нөөц ш.м	Талбай га	Нөөц ш.м
1	Баруунтуруун	7200	1200						7200
2	Бөхмөрөн	6600	1100						6600
3	Давст	9000	1500						9000
4	Зүүнхангай	10800	1800						10800
5	Малчин	6000	1000						6000
6	Наранбулаг	3000	500						3000
7	Өндөрхангай	24000	4000						24000
8	Сагил	10800	1800						10800
9	Тариалан	600	100						600
10	Түргэн	7200	1200						7200
11	Тэс	7800	1300						7800
12	Ховд	8100	1350						8100

13	Хяргас	7200	1200						7200
14	Цагаанхайрхан	7200	1200						7200
15	Улаангом	6000	1000						6000
	Аймгийн дүн	121500	20250	94750	18950	94750	18950	189500	121500

Хүснэгт №5.11. Увс аймгийн 2021-2030 онд ойжуулах талбай, га

Д/д	Сумын нэр	2015-2020 оны ойжуулах талбай га	2015-2020 оны дундаж	2021- 2025 он	2026- 2030 он	Дүн
1	Баруунтуруун					
2	Бөхмөрөн					
3	Давст					
4	Зүүнхангай					
5	Малчин					
6	Наранбулаг	45				
7	Өндөрхангай					
8	Сагил					
9	Тариалан	55				
10	Түргэн	45				
11	Тэс					
12	Ховд					
13	Хяргас					
14	Цагаанхайрхан					
15	Улаангом	50				
16	Өмнөговь					
17	Өлгий					
18	Завхан	60				
19	Зүүнговь					
	Аймгийн дүн	255	43	870	960	1830

Хүснэгт №5.12. Увс аймгийн 2021-2030 онд байгалийн сэргэн ургалтанд туслах талбай, га

Д/д	Сумын нэр	2015-2020 оны нийт арга хэмжээ	2015-2020 оны дундаж арга хэмжээ	2021-2025 он	2026- 2030 он	Дүн
1	Баруунтуруун	180		180	180	360
2	Бөхмөрөн					
3	Давст					
4	Зүүнхангай	130		130	130	260
5	Малчин					
6	Наранбулаг					
7	Өндөрхангай	80		80	80	160
8	Сагил					
9	Тариалан					
10	Түргэн			100	110	210
11	Тэс	80		80	80	160
12	Ховд					
13	Хяргас			20	40	60
14	Цагаанхайрхан	70		70	70	140
15	Улаангом					
16	Өмнөговь					
17	Өлгий					
18	Завхан					
19	Зүүнговь					
	Аймгийн дүн	540	90	660	690	1350

5.2.3. Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлтийн товчоо, зөвлөмж

Ойг хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг цаг хугацаанд нь явуулж, түүнд тусгагдсан ой хамгаалах арга хэмжээг хэрэгжүүснээр ойн экологийн ач холбогдол дээшилж, түүний таваарлаг чанар сайжирна. 2015-2020 онд ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах уламжлалт зохион байгуулалтын арга хэмжээг авахын зэрэгцээ түймрийн зурвасыг 50 га-д байгуулж, 50.5 мянган га талбайд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг гүйцэтгэнэ. Харин хэтийн төсөөллөөр түймрийн шороон зурвасыг 2021-2025 онд 409 га-д, 2026-2030 онд 409 га-д тус тус байгуулна.

Ойн ашиглалтын төлөвлөлт

Модон түүхий эдийн ашиглалтын түвшинг дээшлүүлэх, түлшний модыг өөр эх үүсвэрээр хангахад анхаарч, 2015-2020 онд нийт 121.5 мянган шоометр мод бэлтгэж, аймгийн хэрэглээний болон түлшний модны хэрэгцээг хангана. Харин 2021-2025 онд 94.75 мянган шоометр, 2025-2030 онд 94.75 мянган шоометр мод бэлтгэхээр төсөөлөж байна. Ингэснээр түймэрт нэрвэгдсэн болон мод бэлтгэсэн 17.9 мянган га талбайн ой цэвэрлэгдэж, энэ талбайд байгалийн сэргэн ургалт явагдах, ойг нөхөн сэргээх арга хэмжээ авах боломж хангагдах юм. Мөн дээрх талбайд түймэр гарах, ойн хөнөөлт шавьж, өвчин тархах магадлал эрс багасна. Ойн дагалт баялгийн ашиглалтыг сайжруулах замаар хүн амын хүнсний хангамж, өрхийн орлогыг нэмэгдэнэ.

Ойг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах ажлын төлөвлөлт

Мод үржүүлгийн газруудыг өргөтгөн бойжуулах тарьц суулгацын хэмжээг нэмэгдүүлэх замаар ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг нэмэгдүүлнэ. 2015-2020 онд ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг 255 га-д, 2021-2025 онд 870 га-д, 2025-2030 онд 960 га-д тус тус хийхээр төлөвлөв. Мөн түүнчлэн байгалийн сэргэн ургалтанд туслах арга хэмжээг 2015-2020 онд 540 га-д, 2021-2025 онд 660 га-д, 2026-2030 онд 690 га-д тус тус авахаар тусгав.

Хүрэх үр дүн шалгуур үзүүлэлт

Газар зохион байгуулалтын тусгагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд ойн тогтвортой менежмент нэвтэрч, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд чанарын ахиц гарч, экологийн ач холбогдол бүхий эрүүл ой бий болно. Ойн экосистем, биологийн олон янз байдлын хадгалалт, хамгаалалт сайжирна. Модон түүхий эдийн ашиглалтын түвшин дээшилж, аймгийн мод, модон бүтээгдэхүүний хэрэгцээг хангана. Ойн дагалт баялгийн ашиглалтыг сайжруулах замаар хүн амын хүнсний хангамж, өрхийн орлого нэмэгдэнэ.

Шаардагдах зардал

2015-2030 онд явуулах ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд 6195.7 сая төгрөг шаардагдах тооцоо гарч байна. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын тооцоог хүснэгт 5.13-т харуулав

Хүснэгт №5.13. 2015-2030 онд явуулах ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоо

Д/д	Ойн аж ахуйн арга хэмжээ	Нэг бүрийн үнэ Мян.төг	2015-2020 он		2021-2025 он		2026-2030 он		Дүн	
			Хэмжээ	Зардал сая.төг	Хэмжээ	Зардалса я.төг	Хэмжээ	Зардалса я.төг	Хэмжээ	Зардалса я.төг
1	Түймрийн шороон зурвас	230.0	50	11.5	409	94.07	409	94.07	868	199.64
2	Ойн хөнөөлт өвчинтэй тэмцэх	48.0	50500	2444.2	-	-	-	-	50500	2444.2
3	Арчилгааны огтлолт хийх	20.0	5956	119.12	6015	120.3	6265	125.3	17936	358.72
4	Ойжуулалт	695.0	255	510.0	870	1740.0	960	1920.0	2085	4170.0
5	Байгалийн сэргэн ургалтанд туслах	200.0	540	108.0	660	132.0	690	138.0	1890	378.0
	Дүн			3192.82		2086.37		2277.37		7550.56


ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**6.1. Усны сан бүхий газрын өнөөгийн байдал**

Увс аймгийн хэмжээнд 2013 оны байдлаар усан сан бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 1.2 хувь буюу 85420.54 га газрыг эзэлдэг. Усны сан бүхий газарт мөрөн, гол 29979.1 га буюу 35.0 хувийг, нуур цөөрөм, тойром 54714.3 га буюу 64.0 хувийг, горхи, булаг шанд 727.14 га буюу 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Тогтвортой амжиргаа-2 төслөөр Түргэн сумын Хээр морьтод 5000м³ багтаамжтай хөв байгуулж “Усны үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10 сумын нутагт инженерийн хийцтэй 17 худаг шинээр гаргасан байна.

Хүснэгт №6.1. Усан сан бүхий газар /2013 оны газрын нэгдмэл сангийн ангиллаар/

Сумдын нэр	Бүгд	Гол, мөрний эзлэх газар	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	Горхи, булаг шандын эзлэх газар
Баруунтуруун	53	53		
Бөхмөрөн	16023	638	15385	
Давст	101	101		
Завхан	25347	22847	2500	
Зүүнговь	3114	146	2968	
Зүүнхангай	952	74	878	
Малчин	89		53.3	35.7
Наранбулаг	525.1	78.1	447	
Өлгий	495	10	485	
Өмнөговь	7996	1388	6608	
Өндөрхангай	905.94		459	446.94
Сагил	24323	243	24080	
Тариалан	968	671	282	15
Түргэн	275	272	3	
Тэс	3552	3091	461	
Ховд	229.5			229.5
Хяргас	78	67	11	
Цагаанхайрхан	122	28	94	
Улаангом	272	272		
Дүн	85420.54	29979.1	54714.3	727.14



Зураг №6.1. Сумдын усан сан бүхий газрын талбайн хэмжээ /га/

Увс аймгийн хэмжээнд 2011 оны усны тооллогын дүнгээр 146 гол горхи тоологдсоноос бүгд устай, 107 нуур тойром тоологдсоноос 12 нь ширгэж 95 устай, 493 булаг шанд тоологдсоноос 19 булаг шанд ширгэж, 474 булаг шанд устай, 32 рашаан тоологдсоноос бүгд устай, байна. Ширгэсэн, усгүй байгаа газрууд нь хур бороо элбэгтэй, хур тунадас ихтэй жил сэргэдэг байна.

Хүснэгт №6.2. Усны улсын тооллогын харьцуулсан тоон үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	2007	2011
1	Гол горхи	177	146
2	Нуур цөөрөм	113	107
3	Булаг шанд	462	493
4	Рашаан	28	32
5	Бүгд	780	778

Увс аймагт Монгол орны хэмжээнд талбайн хэмжээгээрээ нэгдүгээр байранд ордог 335000 га талбайтай Увс нуур оршдог. Газарзүйн байрлалын хувьд Их нууруудын хотгорын ихэнх нуурууд байдаг. Увс нуур, Айраг, Ачит нуур нь Рамсарын олон улсын конвенцид бүртгэгдсэн, Увс нуур нь ЮНЕСКО-ийн Шим мандлын дархан газарт, мөн Дэлхийн өвд тус тус бүртгэгдсэн өвөрмөц тогтоц бүхий усны шувуудын байршил нутаг юм.

6.2. Усны сан бүхий газрын төлөвлөлт**6.2.1. Ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн ус ашиглалт**

Увс аймгийн хэмжээнд ус ашиглагч 146 байгаагаас үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагч байгууллага, иргэн 43, газар тариалангийн зориулалтаар ус ашиглагч байгууллага, иргэн 103 байна.

Улаангом сумын төвлөрсөн ус хангамжийн шугамын 1, 2-р станцуудыг Чандмань-Увс ХХК эзэмшдэг бөгөөд 2-р станц нь хэрэглэгчгүйгээс одоохондоо ашиглалтанд ороогүй байна.

1-р станц нь гүн өрмийн 4 худгаас тэжээгддэг 1500 м³ багтаамжтай резервуарт усаа хуримтлуулан түгээдэг бөгөөд Улаангом сумын төвд шахуу байрлана. Харин 2-р станцыг 2013 оны сүүлчээр ашиглалтанд хүлээлгэн өгсөн бөгөөд нийт 6 гүний худгийн усаар тэжээгдэн 4000 м³ багтаамжтай бетонон резервуарт усаа нөөцлөн хэрэглэгчдэд түгээх боломжтой юм. Шинээр ашиглалтанд орж буй цэвэр усны нөөцийн худгуудаас 2 худаг нь айлын хашаан дотор орсон, гэр хорооллын дунд хэсэгт гаргасан нь ариун цэврийн бүсийн нөхцлийг хангаагүй байгааг анхаарч, ариун цэврийн бүсийг тогтоож хамгаалах.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагчдын бүртгэл явуулах үед сав газрын хэмжээнд ус ашиглагч 146 иргэн, аж ахуй нэгж байгууллага бүртгэгдэв. Үүнээс хамгийн их ус ашиглагч Увс аймгийн Улаангом сумын хэмжээнд 96 ус ашиглагч байна. Үүнээс ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага 22, хүнсний зориулалтаар 5, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашиглагч 12, газар тариалангийн үйлдвэрлэлд жимс, чацаргана тариалагч 57 иргэн, аж ахуйн нэгж байрлаж байна.

Эдгээрээс халуун ус, сауны үйлчилгээ явуулж буй 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ус ашиглалтын байдлыг харахад төвлөрсөн шугамаас ус ашиглагч иргэн байгууллага 4, бусад нь хувийн гүний худгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулж байна. Бохирын шугамын байдлыг хянахад төвлөрсөн шугамд 4, бохирын цооногоос хөрсөнд нь нэвчүүлж шингээх аргаар зайлуулдаг 2, цооногоос машинаар соруулан зөөвөрлөдөг 8 халуун ус, саун байна.

Хархираа голоос 8 чиглэлд суваг шуудуугаар ус авч Тариалан сумын 74 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг. Иргэд нийт 111 га-д үр тариа, хадлан, төмс хүнсний ногоо, жимс чацаргана тариалж ардын уламжлалт энгийн усалгаат газар тариалан эрхлэн амьдарч байна.

“Алтан дуулга” ХХКомпани нь хуучин Хархираагийн 2000 га-ийн усалтын системийн 250 га-д үр тариа, хадлан тариалж өөрийн даралтат “Фрегат” агрегатаар бороожуулах усалгааг хийж ажиллаж байна.

Хархираа голын ай сав газрын дагууд хүн амын төвлөрөл, суурьшил ихтэй, нутгийн ард иргэд нь ардын уламжлалт энгийн усалгаатай газар тариалан эрхэлдэгээс эдгээр голууд нь хамгийн их ачаалалтай гол болох нь харагдаж байгаа бөгөөд ус ашиглагчдын хэрэглээ нь гольдролын хэвийн урсацанд сөргөөр нөлөөлж байгаа болно.

Улаангом сум нь нийт 7043 өрхийн 25,1 мян хүн амтай, засаг захиргааны 11 багтай, газар нутаг 260,4 мян км квадрат бөгөөд сумын 150 иргэн 563 га-д, 17 аж ахуйн нэгж байгууллагууд 492-га талбайд дээрхи голуудаас усыг бух шуудуугаар татан авч газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэн амьжиргаагаа явуулдаг байна. Эдгээрээс зөвхөн жимс, чацарганы аж ахуйд 267 га-д тариалалт хийж ашиглаж байна.

Увс аймгийн төв Улаангом сум нь “Гашууны гол”-ын эрэг дагуу байрладаг. Ихэнхи ус ашиглагчид ус ашиглах зөвшөөрөл аваагүй, ус ашиглах дүгнэлтгүй, БО-ны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй үйл ажиллагаа явуулж байна.

Сумдын унд ахуйн хэрэглээний усны чанарт шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн Цагаанхайрхан, Наранбулаг, Өлгий, Зүүнхангай, Түргэн сумдын ундны эх үүсвэрийн чиглэлээр нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай байна.

6.2.2. Усны сан бүхий газрын талхагдал доройтлыг бууруулах


Усны сан бүхий газрын доройтолд бэлчээр ашиглалтын хэв маяг, гол горхи, нуур, худаг уст цэг дагасан бэлчээрийн талхагдал нь усны сан бүхий газрын чанар нөөцөд ихээхэн нөлөөлж байгаа бөгөөд Увс аймгийн ихэнхи сумдын бэлчээрийн даац хэтэрсэнээс бэлчээр ихээр талхлагдаж цөлжиж байна. Тус аймгийн бэлчээр усжуулалтын хувьд говийн бүсийн аймгуудыг бодвол харьцангуй сайн хэдий ч 2013 онд нийт 312 худаг ашиглагдаж байна.

Хүснэгт №6.3. Увс аймгийн худгийн тоо

Аймгийн нэр	Сумын нэр	Худгийн тоо	зориулалт
Увс	Баруун-туруун	14	бэлчээрийн усан хангамж
	Бөхмөрөн	11	бэлчээрийн усан хангамж
	Давст	7	бэлчээрийн усан хангамж
	Завхан	34	бэлчээрийн усан хангамж
	Зүүнговь	20	бэлчээрийн усан хангамж
	Зүүнхангай	8	бэлчээрийн усан хангамж
	Малчин	49	бэлчээрийн усан хангамж
	Наранбулаг	28	бэлчээрийн усан хангамж
	Өлгий	36	бэлчээрийн усан хангамж

	Өмнөговь	80	бэлчээрийн усан хангамж
	Өндөрхангай	25	бэлчээрийн усан хангамж
	Сагил	11	бэлчээрийн усан хангамж
	Тариалан	12	бэлчээрийн усан хангамж
	Түргэн	13	бэлчээрийн усан хангамж
	Тэс	21	бэлчээрийн усан хангамж
	Ховд	16	бэлчээрийн усан хангамж
	Улаангом	8	бэлчээрийн усан хангамж

Хүснэгтээс үзэхэд 2013 оны байдлаар Увс аймагт нийтдээ 312 худаг тоологдож бүртгэгдсэнээс хамгийн их худагтайд Малчин сум, хамгийн цөөн худагтай Давст сум байна.



Зураг №6.2. Увс аймгийн бэлчээр усжуулалтын байдал

Хүснэгт №6.4. Увс аймгийн бэлчээрийн усан хангамж

/Сүүлийн 15 жилд засварласан болон шинээр гаргасан худгийн судалгаа/

Онууд	Зассан инженерийн хийцтэй худаг	Шинээр гаргасан инженерийн хийцтэй худаг	Хөрөнгийн эх үүсвэр /мян.төг/	Хамрагдсан сум	Бэлчээрийн усан хангамжийн	Усжуулагдсан бэлчээр ан бэлчээр /га/	Гүйцэтгэсэн компаний нэр
1999	Өрөмдмөл худаг-1 Богино хашлагат- 2, богино яндант-7		Улсын төсөв	Бөхмөрөн, Тариалан, Давст, Наранбулаг, Завхан	33.8	11000	"Ус эрдэнэ" ХХК
2000	Өрөмдмөл худаг-7 Богино хашлагат- 2,		Улсын төсөв	Малчин, Өндөрхангай, Баруунтуруун, Өлгий, Өмнөговь, Зүүнхангай, Зүүнговь	38.3	76000	"Ус эрдэнэ" ХХК

	Өрөмдмөл худаг-9 Богино хашлагат- 24, богино яндант-1		Кёкүшюзан хөгжлийн сан	Тэс, Наранбулаг, Завхан, Ховд, Давст, Зүүнговь, Өндөрхангай, Сагил, Бөхмөрөн, Малчин, Өлгий, Хяргас, Цагаанхайрхан			"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-1		Германы ЭСЯ-ны хөрөнгөөр	Малчин			"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-2		Швецарийн Засгийн газрын хөрөнгөөр	Түргэн			"ССТ-Од"
Бүгд дүн 46							
2001	Өрөмдмөл худаг-4		Өвсний үндэс	Завхан			"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-5 Богино хашлагат- 1		Ус 21 хөтөлбөр	Өмнөговь, Тариалан, Тэс, Зүүнговь, Баруунтуруун	39.3	90000	"Ус эрдэнэ" ХХК
Бүгд дүн 10							
2002	Өрөмдмөл худаг-3 Богино хашлагат- 1, Энгийн уурхай 1		Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн төсөл ХААСХТөсөл	Ховд, Зүүнхангай	39.8	98000	"БТБ-МСС" ХХК
	Бүгд дүн 5						
2003	Өрөмдмөл худаг-6 Богино хашлагат- 2,		Өвсний үндэс	Бөхмөрөн	43.2	160000	"Ус эрдэнэ" ХХК
	Өрөмдмөл худаг-1		Гаалийн ерөнхий газар	Сагил			"ССТ-Од" ХХК
	Өрөмдмөл худаг-20 Богино хашлагат- 5,		ХААСХТөсөл	Өлгий, Өмнөговь, Бөхмөрөн, Сагил, Давст			"БТБ-МСС" ХХК
Бүгд дүн 34							
2004	Өрөмдмөл худаг-16 Богино хашлагат- 3,		ХААСХТөсөл	Хяргас, Баруунтуруун, Малчин, Тариалан, Улаангом, Завхан	47.5	204000	"БТБ-МСС" ХХК
	Өрөмдмөл худаг-18 Богино хашлагат- 6,		ӨАЧД төсөл	Баруунтуруун, Зүүнговь, Тэс, Завхан, Наранбулаг, Малчин, Хяргас, Түргэн, Өндөрхангай, Цагаанхайрхан			"Ус эрдэнэ" ХХК
Бүгд дүн 44							
2005	Өрөмдмөл худаг-9 Богино хашлагат- 1,		ХААСХТөсөл	Малчин, Түргэн, Тариалан, Наранбулаг, Зүүнхангай	60.6	255000	"БТБ-МСС" ХХК
	Өрөмдмөл худаг-11 Богино хашлагат- 5, богино яндант-5		ӨАЧД төсөл	Баруунтуруун, Зүүнговь, Тэс, Завхан, Наранбулаг, Малчин, Хяргас, Түргэн, Өндөрхангай, Цагаанхайрхан			"Ус эрдэнэ" ХХК
Бүгд 31							
2006		Өрөмдмөл худаг 12	Улсын төсөв	Өмнөговь, Завхан, Наранбулаг, Зүүнхангай, Баруунтуруун, Хяргас, Тэс, Улаангом, Түргэн	54.2	317000	"Ус эрдэнэ" ХХК
	Бүгд 12						

	Өрөмдмөл худаг-13 Богино хашлагат- 3, богино яндант-9		Улсын төсөв	Ховд, Өмнөговь, Өлгий, Сагил, Давст, Наранбулаг, Өндөрхангай, Цагаанхайрхан, Улаангом, Тариалан			"БТБ-МСС" ХХК
Бүгд 25							
2007	Өрөмдмөл худаг-25 Богино хашлагат- 1,	Өрөмдмөл худаг-13	Улсын төсөв	Малчин, Тэс, Сагил, Өлгий, Цагаанхайрхан, Зүүнговь, Завхан, Давст	61.7	467000	"БТБ-МСС" ХХК
		Өрөмдмөл худаг-12 Богино хашлагат- 1,	Улсын төсөв	Өндөрхангай, Завхан, Малчин			"БТБ-МСС" ХХК
		Өрөмдмөл худаг-14	Улсын төсөв	Ховд , Бөхмөрөн, Сагил, Өмнөговь,			"ССТ-Од" ХХК
		Өрөмдмөл худаг-10	Улсын төсөв	Наранбулаг, Өндөрхангай Давст, Малчин			"Ус эрдэнэ" ХХК
Бүгд 50							
2008	Өрөмдмөл худаг-10 Богино хашлагат- 3,	Өрөмдмөл худаг-28	Улсын төсөв	Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Малчин, Хяргас, Наранбулаг, Завхан, Өмнөговь, Улаангом, Сагил, Тариалан, Өлгий, Түргэн	65.8	539000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК "ССТ-од" ХХК
	Бүгд 13		Бүгд 28				
2009		Өрөмдмөл худаг-15	Улсын төсөв	Өндөрхангай, Зүүнхангай, Улаангом, Хяргас, Малчин, Баруунтуруун, Зүүнговь, Ховд, Өмнөговь, Бөхмөрөн	67.3	569000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	Бүгд 15						
2010		Өрөмдмөл худаг-19	Улсын төсөв	Давст, Өмнөговь, Бөхмөрөн, Түргэн, Хяргас, Улаангом, Наранбулаг, Малчин, Тэс, Зүүнговь, Өндөрхангай, Цагаанхайрхан, Завхан	69.3	607000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	Бүгд 19						
2011		Өрөмдмөл худаг-28	Улсын төсөв	Давст, Өмнөговь, Бөхмөрөн, Хяргас, Улаангом, Наранбулаг, Малчин, Тэс, Зүүнговь, Өндөрхангай, Өлгий Цагаанхайрхан, Завхан, Тариалан, Баруунтуруун, Зүүнхангай, Сагил,	71.8	659000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	Бүгд 28						
2012		Өрөмдмөл худаг-19	Улсын төсөв	Ховд, Давст, Түргэн, Өндөрхангай, Зүүнхангай, Малчин, Хяргас, Цагаанхайрхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Зүүнговь, Баруунтуруун, Завхан	73.7	697000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	Бүгд 19						
2013		Өрөмдмөл худаг-25	Улсын төсөв	Бүх сумдад	76.2	747000	"Энержи флоу констракшн"ХХК, "Ус-эрдэнэ" ХХК
	Бүгд 25						

Худаг уст цэг гаргах бэлчээрийн усжуулах саналуудыг бэлчээрийн газрын ашиглалтыг сайжруулах төлөвлөлтөд тусгаж, худаг гаргах боломж нөхцөлийг гидрогеологийн зураг, материалд тулгуурлан үнэлж төлөвлөлтөд тусгасан. Усны сан бүхий газрын талхагдал доройтлыг бууруулахад тус төлөвлөлтөд тусгасан бэлчээр усжуулалтын арга хэмжээ нь бэлчээр нутгийн талхагдал доройтлыг бууруулахад онцгой ач холбогдолтой тул зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ болно.

6.2.3. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

Усны нөөцийн судалгаанд үндэслэн сум, орон нутгийн иргэдийн саналыг харгалзан хуучин ашиглагдаж байсан инженерийн болон энгийн хийцтэй услалтын системүүдийг сэргээн засварлах, үйлдвэр, үйлчилгээний байгууллага болон нийтийн орон сууцны иргэдийн хэрэгцээний цэвэр, хаягдал усны шугамыг тоолууржуулах

Хүн, мал бэлчээрийн усан хангамжийн бүрэн шаардлага хангахгүй болж эвдэрч гэмдсэн худаг бусад уст цэгийг хэрхэн шийдэх талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж шийдвэрлэх.

Увс аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд уул уурхайн олборлолтонд өртсөнөөс бохирдож байгаа, усны нөөц нь хомсдож байгаа гол горхи хэд хэд байна. Түргэн сумын нутаг Улаан начин гэдэг газарт алт олборлолтоос үүдэлтэй Шавь нарын булаг сүүлийн арваад жил хүний үйл ажиллагаанд өртөж усны нөөц нь хомсдож байна. Увс аймгийн хэмжээнд хүн амын унд ахуйн усан хангамжинд нийтдээ 198 худаг ашиглагдаж байна. Энгийн хамгаалалтын бүсэд Увс аймагт 181 гол горхи, 116 нуур цөөрөм, 462 булаг, 34 рашааныг хамруулан тогтоогдсон.

Гол горхи нуур, тойрмын усны эрэг болон гүн хэсгийн хооронд байнгын хөдөлгөөнтэй солилцоо зурвас хэсэг байдаг. Гол горхи, нуур тойрмын эрэг хөвөө дагуу хэсэг зурвас газар нь экологийн хувьд онцгой ач холбогдолтой бүс байдаг. Ийм бүсийн зурвас орчмыг усны бүс гэх бөгөөд усны болон хуурай газрын биологийн төрөл зүйлийн хувьд харьцангуй баян хэсэг бөгөөд хамгаалалтын бүсийг доорхи байдлаар тогтоов.

Хүснэгт №6.5. Гол горхины ус хамгаалах бүс

Гол горхины урт, (км)	Хамгаалах бүсийн өргөн, голын захаас, (м)	Хориглох бүс, голын захаас, м
<24	50	25
24-49	100	50
50-100	200	100
>101	300	150

Хүснэгт №6.6. Нуур, цөөрмийн ус хамгаалах бүс

Нуур цөөрмийн ил гадаргын талбай, (ам)	Хамгаалах бүсийн өргөн, голын захаас, (м)	Хориглох бүс (м)
<1	150	50
1-25	200	100
>3	500	250

Хүснэгт №6.7. Булаг, шандын ус хамгаалах бүс

Ундарга л/сек	Хязгаарлах бүс, м	Хориглох бүс (м)
<1	150	50
1-25	175	75
>3	200	100

Усны хөвөө, эрэг орчмын газар, гол горхи, нуур тойром, суваг шуудуу зэрэг байнгын юмуу, түр зуурын урсгалтай тогтмол устай ч байнга сэлбэгдэж байдаг. Гадаргуугын ус бүхий газрын тодорхой хэсэг нь эх газар буюу хуурай газрын экологийн тогтолцоо, түүний бүрэлдэхүүний орчинд сэлгээний системийн үүрэг гүйцэтгэдэг байна. Иймээс газар бүсчлэлийн асуудалд усны эрэг, хөвөө орчмын газар гэдэг бичил бүсийг харгалзан үзэх нь арга зүйн өндөр ач холбогдолтой юм. Урсгал ус нь чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд усны ургамал амьтны оршин амьдрах орчин, хүнс тэжээлийнх нь агуулга болдог.

Газар бүсчлэлийн бодлогод усны хөвөө газрын хөрс, ургамлын нөмрөг ландшафтын тогтолцоог аж ахуйн эргэлтэнд хэрхэн ямар хэмжээгээр оруулах, яаж хадгалан хамгаалах асуудал гол байр эзэлдэг. Гол мөрөн, нуурын дүрс зүйн элемент, булаг шандын ундаргаас хамааруулан ус хамгаалах бүс ба аж ахуйн үйл ажиллагааг хориглох бүсийн өргөнийг тогтоосныг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт №6.8. Гол горхины эргийн хамгаалалтын бүсийн хэмжээ

№	Сумдын нэр	Гол горхины нийт талбай /га-аар/	Гол горхигны эх газрыг хамгаалах талбай	
			Хувиар /%/	/ га-аар /
1	Баруунтуруун	53	0.18	84.14
2	Бөхмөрөн	638	2.13	1012.90
3	Давст	101	0.34	160.35
4	Завхан	22847	76.21	36272.19
5	Зүүнговь	146	0.49	231.79
6	Зүүнхангай	74	0.25	117.48
7	Малчин			
8	Наранбулаг	78.1	0.26	123.99
9	Өлгий	10	0.03	15.88
10	Өмнөговь	1388	4.63	2203.61
11	Өндөрхангай			
12	Сагил	243	0.81	385.79
13	Тариалан	671	2.24	1065.29
14	Түргэн	272	0.91	431.83
15	Тэс	3091	10.31	4907.31
16	Ховд			
17	Хяргас	67	0.22	106.37
18	Цагаанхайрхан	28	0.09	44.45
19	Улаангом	272	0.91	431.83
	Дүн	29979.1	100.00	47595.2

Хүснэгт №6.9. Нуур цөөрөм бүхий газрын хамгаалах зурвасын хэмжээ

№	Сумдын нэр	Нуур цөөрөм бүхий газрын нийт талбай /га-аар/	Нуур цөөрөм бүхий бүхий газрын хамгаалах талбай	
			хувиар	га-аар
1	Баруунтуруун	-	-	-
2	Бөхмөрөн	15385	28.12	11968.23
3	Давст			
4	Завхан	2500	4.57	1944.79
5	Зүүнговь	2968	5.42	2308.85
6	Зүүнхангай	878	1.60	683.01
7	Малчин	53.3	0.10	41.46

8	Наранбулаг	447	0.82	347.73
9	Өлгий	485	0.89	377.29
10	Өмнөговь	6608	12.08	5140.47
11	Өндөрхангай	459	0.84	357.06
12	Сагил	24080	44.01	18732.20
13	Тариалан	282	0.52	219.37
14	Түргэн	3	0.01	2.33
15	Тэс	461	0.84	358.62
16	Ховд	-	-	-
17	Хяргас	11	0.02	8.56
18	Цагаанхайрхан	94	0.17	73.12
19	Улаангом	-	-	-
Дүн		54714.3	100.00	42563.10

Хүснэгт №6.10. Булаг, рашаан бүхий газрын хамгаалах зурвасын хэмжээ

№	Сумдын нэр	Булаг, рашаан бүхий газрын нийт талбай /га-аар/	Худаг, булаг, рашаан бүхий газрыг хамгаалах талбай	
			хувиар	га-аар
1	Баруунтуруун	-	-	-
2	Бөхмөрөн	-	-	-
3	Давст	-	-	-
4	Завхан	-	-	-
5	Зүүнговь	-	-	-
6	Зүүнхангай	-	-	-
7	Малчин	35.7	4.91	678.77
8	Наранбулаг	-	-	-
9	Өлгий	-	-	-
10	Өмнөговь	-	-	-
11	Өндөрхангай	446.94	61.47	8497.72
12	Сагил	-	-	-
13	Тариалан	15	2.06	285.20
14	Түргэн	-	-	-
15	Тэс	-	-	-
16	Ховд	229.5	31.56	4363.51
17	Хяргас	-	-	-
18	Цагаанхайрхан	-	-	-
19	Улаангом	-	-	-
Дүн		727.14	100.00	13825.20

6.2.4. Усан сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх

Усны ай сав, усан хагалбарын доторх газар нутгаас угаагдсан туугдас нь биогехимийн элементүүд усны хөвөө газарт тогтох ба зарим хэсэг уст цэгүүдэд орж улмаар усны болон усны хөвөө газрын биологийн төрөл зүйлсийн хүнс тэжээл, амьдрах орчинг баяжуулж, ус сэлгэх явцад найрлага төрөл тоо хэмжээ нь зохицуулагдаж байдаг. Усны хөвөө газар нь зэрлэг ан амьтан, мал сүрэг усанд орох сэрүүцэх үедээ түр саатан тогтох нутаг болдог. Тэрчлэн бэлчээрийн мал аж ахуйн нөхцөл дулааны улирлын нутгийн гол цөм нь болдог онцлогтой. Усны хөвөө газрын ашиглалтын хэлбэр, ашиглалтын горим, ялангуяа ургамалжилт нь нуур тойром, гол горхины усны урсгал болон ус сэлгэх чадавх усны чанар найрлагад нөлөөлдөг бол усны урсгал, ус сэлгэх чадавх хэлбэр маяг нь усны

хөвөө газрын биологийн төрөл зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ ялангуяа ургамлын бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн хэв шинж бүрэлдэхүүн чанар зэрэгт нөлөөлдөг.

Усалгааны эх үүсвэрт гадаргуугийн усыг өргөн ашиглаж байна. Гадаргын ус нутаг дэвсгэртээ харилцан адилгүй тархах тул зарим усны эх үүсвэрийн нөөц нь усалгаанд хүрэлцэхгүй тохиолдол нилээд тохиолдоно. Иймд усан сан, цөөрөм байгуулж, усыг хуримтлуулан ашиглах нь усны нөөцийг нэмэгдүүлэн усалгааны хэрэгцээг найдвартай хангах үндэс нь болно.

Манай орны голуудын урсацын ихэнх нь хур борооны уснаас бүрддэг учраас зуны үерийн ус болон хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглахад голлон анхаарвал зохино.

- Жижиг гол горхийн урсацад тохируулга хийж хэрэглээний усыг хуримтлуулах
- Хуучин ашиглаж байсан усан сан, цөөрмийг сэргээх
- Хаврын шар ус, зуны борооны ус хуримтлуулах сан, цөөрөм байгуулах
- Баян бүрдүүдийг сэргээх
- Гол, горхийн хөндийн мод, бут, сөөг, хөрс, ургамлын бүрхэвчийг хамгаалах, нөхөн сэргээх
- Усалгаанд ашигласан илүүдэл усыг эргүүлэн ашиглах
- Усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах зэрэг болно.

Ус ашиглагч байгууллага нь тухайн усны эх үүсвэрт өөрийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд нарийвчилсан үнэлгээ хийлгэж, экологийн урсацын хэмжээг тогтоох, хэрвээ авч ашиглах усны хэмжээ хүрэлцэхгүй, экологийн урсацын зарим хэсгийг бага хугацаанд ашиглахад хүрвэл ус хуримтлуулж, нөөцөлж ашиглах хувилбарыг сонгож, ялангуяа хуурай улиралд дутагдал усыг нөхөх эзлэхүүн бүхий усан сан, цөөрөм байгуулах замаар голын экологийн нөхцлийг хангах шаардлагатай байна.

Усны эх үүсвэрээс усыг эмх замбараагүй, их хэмжээгээр авч ашигласнаар усны түвшин буурах, горим нь алдагдах, улмаар нөөц нь хомсдох, бүр ширгэж алга болох зэрэг нөлөөллүүд гарах магадлалтай. Мөн тухайн орон нутгийн гол, горхи, нуурын загас, шувуу, усны амьтан ургамлын төрөл зүйл хорогдоход хүрдэг. Иймд усыг авахдаа орчны экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр батлагдсан хэм хэмжээг /урсацын 5-10%/ баримтлах шаардлагатай.

Усны сан бүхий газрыг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр сумдаас доорхи саналууд ирсэн бөгөөд шаардагдах төсөв хөрөнгийг хүснэгт 6.11-т үзүүлэв.

Хүснэгт №6.11. Увс аймгийн хамгаалалтанд авах шаардлагатай булгийн судалгаа, шаардагдах хөрөнгө оруулалт

Д/д	Сумын нэр	Булгийн нэр	Газар нутгийн нэр	Эзэмшигчид	Үе шат	Шаардагдах төсөв
1	Наранбулаг	Хайстын шил	тосгууртын булаг	Хужирт баг	2015-2020	35,000,000
		Тогтохын шил	Адуунчулууны ус	Алдар баг		
2	Улаангом	Мөстийн булаг	2-р багийн малчид	2-р баг нутгийн иргэд		
		Гашуун усны булаг	2-р багийн малчид	2-р баг нутгийн иргэд		
		Улааны дээд булаг	-	Нутгийн иргэд		
3	Тариалан	Нүцгэний булаг	Нүцгэн	Мянган баг нутгийн иргэд		
		Бэлийн булаг	Мянганы шил	Мянган баг		

		Тавтын булаг	Тавт	Нутгийн иргэд				
		Хавтгайн булаг	Хавтгай	Нутгийн иргэд				
		Өртөөн салааны булаг	Өртөөний салаа	Нутгийн иргэд				
		Овоотын булаг	Овоот	Нутгийн иргэд				
4	Түргэн	Ендэрт	Ендэрт	Нутгийн иргэд				
		Бага модот	Бага модот	Нутгийн иргэд				
5	Сагил	Зуун мод	Сумын төвд	Нутгийн иргэд	2021-2025	70,000000		
		Марц	-	Нутгийн иргэд				
		Гашуун	-	Нутгийн иргэд				
		Хагийн нуур	Олон булаг	Нутгийн иргэд				
		Хустын хажуу	-	Нутгийн иргэд				
		Булин	-	Нутгийн иргэд				
		Хавирга булаг	-	Нутгийн иргэд				
		Бижийн булаг	-	Нутгийн иргэд				
6	Хяргас	Бэл булаг	Хангай баг	Нутгийн иргэд				
		Булгууд	Хар цагааны усны орчим	Нутгийн иргэд				
7	Малчин	Өгөөмөрийн булаг	Өгөөмөр	Нутгийн иргэд				
		Мухар булаг	Мухар булаг	Нутгийн иргэд				
8	Баруунтуруун	Хярын эхний булаг	Хярын эх	Нутгийн иргэд				
9	Сагил сум	Хагийн нуур	Олон булаг	Нутгийн иргэд				
		Бижийн булаг	-	Нутгийн иргэд				
10	Түргэн сум	Хоо толгойн булаг	Хоо толгой	Нутгийн иргэд				
		Шавь нар	-	Нутгийн иргэд				
11	Бөхмөрөн	Утын булаг	Ут	Нутгийн иргэд				
		Рашаан толгойн булаг	Рашаан толгой	Нутгийн иргэд				
12	Ховд	Хатуу	-	Нутгийн иргэд				
		Шивэрийн булаг	Шивэрийн гол	Нутгийн иргэд				
13	Цагаанхайрхан	Рашаан булаг	-	Нутгийн иргэд	2026-2030	30,000000		
		Эхний булаг	-					
		Шар нуур	-					
		Ганц мод	-					
		Түргэний рашаан булаг	-					
		Гахайн булаг	Сумын төв					
14	Зүүнхангай	Бэрхийн булаг	Бэрхийн урд хэсэгт	Нутгийн иргэд				
		Яргайт булаг	Ялигар цанж, яргайтын хойд хэсэг					
		Булаг	Баяновоо орчим баруун талаар модны зааг орчим					
16	Зүүнговь	Чойн булаг	-	Нутгийн иргэд				
17	Өндөрхангай	Толийн булаг	-	Нутгийн иргэд				28,000000
18	Давст	Баруун мод	-	Нутгийн иргэд				
19	Өлгий	Өгөөмөр	-	БОНХЯ, Орон нутгийн ЗДТГ, БОГ, СГЗ, ГТХ			2014-2025	80,000000
		Улаан эх	-	БОНХЯ, Орон нутгийн ЗДТГ, БОГ, СГЗ, ГТХ				

6.2.5. Ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах

Хөв цөөрөм байгуулаж хуурай газрыг усан толь болгон нэмэгдүүлэх нь усны сан бүхий газрын зохистой ашиглалт, хамгаалалтад чухал арга хэмжээ бөгөөд хээрийн судалгааны үе шатанд энэ чиглэлээр сумдаас доорхи саналууд гарсан байна.

Хөв цөөрөм байгуулах санал бүхий газруудад нарийвчилсан судалгаа хийж, техникийн нөхцөлийг тодорхойлсны үндсэн дээр нэмэлтээр төлөвлөлтөд тусгах боломжтой.

Хүснэгт №6.14. Хөв цөөрөм байгуулах санал бүхий газруудад хэрэгжүүлэх арга хэмжээ

дд	Сумдын нэр	Газрын нэр	Байршил	Зориулалт	Он	Шаардагдах арга хэмжээ
1	Наранбулаг	Түргэний гол	Хайстын шилийн зүүн бэл	Бэлчээр усжуулалт,	2015-2020	Зураг төсөл боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх, барьж байгуулах
		Босгын хөндий	-	Бэлчээр усжуулалт,		
3	Баруунтуруун	Зүүнтуруун	Зүүнтурууны гол	Усалгаатай тариалан		
4	Хяргас	Хангилцагийн гол	Овооны үзүүр	Бэлчээр усжуулалт, газар тариалан		
5	Тариалан	Унхараг	Галдан бошигтын бухын адаг	Бэлчээр усжуулалт, тариалан		
6	Зүүнговь	Харбураа	Харбураагийн систем	Усалгаатай тариалан, бэлчээр усжуулалт		
7	Өлгий	Баруун хөвөө	Баруун хөвөө орчим	Бэлчээр усжуулалт	2015-2020	Зураг төсөл боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх, барьж байгуулах
		Сондуултын гол	Сондуултын гол орчим			
8	Өндөрхангай	Чигжийн гол	Чигжийн гол дагуу	Бэлчээр усжуулалт		
		Цагаан дэрс		Бэлчээр усжуулалт		
9	Малчин	Сэргийн хөндий	Улаан толгой худаг орчим	Бэлчээр усжуулалт, газар тариалан		
		Овоот	Эрдэнэтолгой орчим	Бэлчээр усжуулалт, газар тариалан		
		Дархад уул	Эртний булш орчим	Бэлчээр усжуулалт, газар тариалан		
		Цагаан бургастай	Цагаан бургастайн гол орчим	Усалгаатай тариалан		
		Гэдэргийн боом	-	Бэлчээр усжуулалт		
10	Улаангом	Даваан улиастай	-	Бэлчээр усжуулалт	2015-2020	
		Гашууны адаг довон орчимд	Аймгийн төвөөс зүүн хойн нуурын орчимд	Ус хуримтлуулах сан байгуулах, усан хангамжийг сайжруулах		
		Ар сайрын усны нөөцийг нэмэгдүүлэх /Шургадагын сайр/	Аймгийн төвөөс урагшаа	Ус хуримтлуулах сан байгуулах, усан хангамжыг сайжруулах		
11	Цагаанхайрхан	Шалын толгой		Бэлчээр усжуулалт,		

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**7.1. Тусгай хэрэгцээний газрын өнөөгийн байдал**

Увс аймгийн хэмжээнд 2013 оны 3-р сарын байдлаар 13 сумын 551457.95 га талбай бүхий 26-н газрыг аймаг, сумын ИТХ-аар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байна. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар нь аймгийн нийт газар нутгийн 7.92%-ийг эзэлж байна. Үүнд:

Увс нуурын дархан цаазат газар

Түргэн уулыг дархан цаазат газар

Түргэн уулын дархан цаазат газрын өргөтгөл Гоожуур хэсэг

Цагаан шувуутын дархан цаазат газар

Алтан элсний дархан цаазат газар

Хан-хөхийн нурууны Байгалийн цогцолборт газар


Хяргас нуурын Байгалийн цогцолборт газрын Хэцүү хад, Баян хошуу, Түвшин санаа

Тэсийн голын байгалийн нөөц газар

Мөнгөт цахирын байгалийн дурсгалт газар

Булган хангай уулын Байгалийн нөөц газар зэрэг болно

Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газрын дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 7.1.-ээр гаргав. Байгалийн унаган төрхийг хадгалах хамгаалах, байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах, түүх соёлын дурсгалт газар, рашаан, ховордсон ургамал, амьтан, голын эхийг хамгаалах зорилгоор газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байна.



Зураг №7.1. Увс аймгийн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын зураг

Хүснэгт №7.1. Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газруудын жагсаалт

Сумын нэр	Үндэслэл	Аймаг, Сумын	Он тогтоол	Газрын нэр	Талбай /га/
Өмнөговь	Байгалийн үзэсгэлэнт газар	сумын	2006/04/12, 07-р тогтоол	Яргайт	9769.8
Сагил	Ан амьтан, Ховор ургамал хамгаалах	сумын	2007/02/15, 09-р тогтоол	Цагаан гол, Бураат, Хайргат, Шилүүстэй уул	36955.9
Бөхмөрөн	Ан амьтан, Ховор ургамал хамгаалах	сумын	2007/02/15, 01-р тогтоол	Уушгийн улаанаас Байрмын даваа ацат хар, Мандахын аараг	86410.9
Улаангом	Байгалийн өвөрмөц тогтоцтой газар	аймгийн	1994/06/15, 108-р тогтоол	Огзом	2199.4
Ховд	Байгалийн үзэсгэлэнт газар	сумын	1996	Гоожуур орчим	24998.8
Цагаанхайрхан	Байгалийн тэнцвэрт байдлыг хамгаалах	сумын	2007/06/27, 05-р тогтоол 1-р х	Хангилцгийн гол	37262.4
Цагаанхайрхан	Түүх соёлын дурсгалт газар	сумын	2006/01/16, 03-р тогтоол 4-р х	Хурган нуруу, алаг нуруу орчмын	71209.7
Цагаанхайрхан	Отрын нөөц нутгыг хамгаалах	сумын	2006/01/16, 03-р тогтоол 4-р х	Хунт, Зэгстэй бүрдэнгийн нуур, Хулжийн г	79441.6
Хяргас	Голын ай савыг хамгаалах	сумын	2001/05/03, 17-р тогтоол	Билүүгийн гол	2284.6
Хяргас	Түүх соёлын дурсгалт газар	сумын	2002/05/13, 15-р тогтоол	Булганхангай уул	2698.1
Өндөрхангай	Голын ай савыг хамгаалах	сумын	2006/01/20, 04-р тогтоол 4-р х	Чигжийн гол	171.2
Зүүнговь	Нуурын усыг хамгаалах	сумын	2000/04/27, 05-р тогтоол	Урт булаг	12122.0
Өмнөговь	Тусгай хамгаалалттай газрын тухай хууль.	сумын	2007/11/23, 7/01-р тогтоол	Ёлын шил, Ногооны рашаан, Орлогын гол	27172.9
Зүүнговь	Рашаан хамгаалах	сумын	2009/09/27 5-р тогтоол	Урт булагийн гол	300.4
Малчин	түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах	сумын	2003/04/07, 07-р тогтоол	Хар тэрмис	32642.2
Наранбулаг	Байгалийн өвөрмөц тогтоц, соёлын дурсгалт	сумын	2002/09/26 5/4 р тогтоол	Бор залаа орчмын газар	4399.2
Өндөрхангай	Рашаан хамгаалах	сумын	2010/01/08, 4/6 тоот	Усны овгорын рашаан	60.6
Өндөрхангай	Түүхийн дурсгалт газар	сумын	2010/01/08, 4/6 тоот	Сумын төвд түүхийн дурсгал модон гэр	0.49
Сагил	Булагийн эх хамгаалах	сумын	2005/01/29, 2/03 тоот	Сумын төвөөс баруун хойд зүгт Зуун мод	12.3
Сагил	Голын эх	сумын	2005/01/29, 2/03 тоот	Боршоон хавцал	15.8
Сагил	Бэлчээр, усан хангамж, ан амьтаны нутаг хамгаалах	сумын	2010/09/08, 01-р тоот	Нарийн салаа	21461.8
Тариалан	Газар тариалангийн бүс нутгийг хамгаалах	сумын	2009/12/30, 3/5	Тээл	11422.14603
Тариалан	Голын ай сав хамгаалах	сумын	2009/12/30, 3/5 - р тогтоол	Сумын төвийн баруун хэсэг	2175.847909
Улаангом	ховор ан амьтан, ургамал хамгаалах	сумын	2009/12/31 4/06 тоот тогтоол	Арцны гом	5691.663718
Улаангом	Түүх соёлын дурсгалт газар	аймгийн	2010/12/25, 6/06 тоот	Улаан уул	351.546753
Зүүнхангай	Байгалийн унаган төрх тогтоц хамгаалах	сумын	2009/12/28, 03/10 тоот тогтоол	Баянгол	3596.282276

7.2. Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт

Нэн ховор болон ховордсон ан амьтныг хамгаалах, байгалийн өвөрмөц, унаган тогтоцыг хамгаалан, хадгалж хойч үедээ өвлүүлэн үлдээхэд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ ихээхэн үүрэг гүйцэтгэх бөгөөд монгол улсын хувьд нийт нутаг дэвгэрийн 30%-ийг улсын тусгай хамгаалалтад авах зорилт тавьсан байгаа билээ. Тус аймгийн хувь улсын тусгай хэрэгцээний газрыг нэмэгдүүлэх чиглэлээр улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд доорхи газруудыг 2023 он хүртэлх хугацаанд хамгаалалтад авахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №7.2. 2013-2023 онуудад улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай, экологийн чухал ач холбогдолтой газруудын жагсаалт /санал/


№	Газрын нэр	Үндэслэл, ангилал	Харьяалагдах аймаг
1	Хавцал баян уул	Байгалийн нөөц газар	Увс
2	Үүрэг нуур	Байгалийн нөөц газар	Увс
3	Ачит нуур	Дэвэлийн нөөц газрын өргөтгөлийн хамт	Увс
4	Согоот -Ногоон нуурын эхэн	Байгалийн нөөц газар	Увс
5	Хөвд голын цутгал	Байгалийн нөөц газар	Увс
6	Гурван хорио	Дурсгалт газар	Увс

Харин хээрийн судалгааны явцад сумдаас ирсэн саналыг нэгтгэн үзэхэд Зүүнговь сум Баяннуур, болон уртын булаг гэсэн газруудыг улсын тусгай хамгаалалтад авах нь зүйтэй гэсэн санал өгсөн.

Мөн 4-н газрыг аймгийн тусгай хэрэгцээнд авч хамгаалах, 15-н газрыг сумын тусгай хэрэгцээний газарт хамруулан хамгаалах саналуудыг өгсөн байна.

Улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай гэж үзсэн Баяннуур, Уртын булгийн тусгай хамгаалалтад авах үндэслэл нь Тус бүс нутаг нь хойт талаараа Өгөөмөр уул, баруун өмнө, зүүн талаараа элсэн манхнаар хүрээлэгдсэн бөгөөд элсэн дундаас эх авсан олон булаг, шандуудаар тэжээгдэж байдаг байгалийн гоёмсог тогтоц бүхий газар бөгөөд Баяннуур нь Алтайн шар сугас зэрэг загас жараахайтай, цэнгэг устай нуур юм. Баяннуураас Хойт гол эх аван урсаж Нарийний голд цутгадаг. Баяннуурын усан мандлын талбай 27.8 км²,

Уртбулаг нь Манхан элснээс эх авч элсэн манхан дундуур урсаж Хойт голд цутгадаг цэвэр хүйтэн устай, голын хөндийгөөр бургас хус, харгана зэрэг бутлаг ургамал холилдон ургасан ой модтой шугуй юм. Уг булаг нь газрын гүний цэвэр усаар тэжээгддэг булаг юм. Нутгийн ард түмэн эрт дээр үеэс элэг цөсний өвчнийг анагаахад өргөн ашиглаж ирсэн бөгөөд рашааны эхийг хамгаалсан, зуны улиралд хүмүүс ирж амарцгаадаг үзэсгэлэнтэй газар юм. Уртбулагийн шугуй, голын хөндийгөөр чихэр өвс, таана, жууцай, царван зэрэг эмийн ургамалтай. Баяннуур, Уртбулаг орчмын нутагт 1900 орчим мал өвөлждөг. Зуны улиралд Өгөөмөр, Баяннуур багийн 40 гаруй өрх, 200 хүн, 16000 толгой мал хаваржиж, зусаж намарждаг байна.



Зураг №7.2. Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамруулах санал бүхий газруудын байршил

Хүснэгт №7.3. Улсын тусгай хамгаалалт болон, аймаг, сумын тусгай хэрэгцээний газарт шинээр хамруулан хамгаалахаар санал өгсөн нутгийн газрын нэгдмэл сангийн бүтэц, тусгай хамгаалалтад авах үндэслэл

Газрын нэр	Сумын нэр	ТХ-д авах үндэслэл	Бэлчээр	Хадлан	Тариалан	Өвөлжөө хаваржааны газар	Зам, шугам сүлжээний газар	Гол, мөрөн	Булаг шанд	Нуур цөөрөм тойром	Ойн сан бүхий газар	Дүн
Улсын тусгай хамгаалалтад шинээр хамруулах санал бүхий нутгийн ГНС-н ангилал												
Баяннуур	Зүүнговь	Байгалийн үзэсгэлэнт газар	7322.28	5.76		3.13	7.36	14.90	0.11	3272.89		10626.44
Уртын булаг	Зүүнговь	Байгалийн үзэсгэлэнт газар	1763.35			3.13		35.86	0.02	32.35		1834.71
		Дүн										12461.14
Аймгийн тусгай шинээр хэрэгцээнд хамруулах санал бүхий нутгийн ГНС-н ангилал												
Зуслан тээл	Давст	Байгалийн үзэсгэлэнт газар	3894.61									3894.61
Жаргалант	Давст	Байгалийн үзэсгэлэнт газар	5011.11			10.18						5021.29
Баруун мод	Давст	Байгалийн үзэсгэлэнт газар	792.28					2.23	1.28		1534.39	2330.19
Ачит нуур	Бөхмөрөн	Ховор ан амьтан, Ачит нуурыг хамгаалах	20223.90	2622.24	4.79	3.13		410.36		16142.29		39406.71
		Дүн										50652.79
Сумын тусгай хэрэгцээнд шинээр хамруулах санал бүхий нутгийн ГНС-н ангилал												
Цалгар уул	Түргэн	Ховор ан амьтан хамгаалах	4808.69			10.05	27.03	4.33			3142.89	7992.99
Цагаан хайрхан	Хяргас	Ховор ан амьтан хамгаалах	2047.19			1.63		2.62			3.20	2054.63
Цогт хайрхан	Хяргас	Байгаль хамгаалах	682.26					1.57			454.83	1138.66
Хуц уул	Хяргас	Ховор ан амьтан хамгаалах	4120.17	3.57		9.50		3.45			513.18	4649.87
Бор хайрхан	Хяргас	Ховор ан амьтан хамгаалах	3261.36			0.78						3262.15
Хөх орой	Өмнөговь	Байгалийн үзэсгэлэнт газар	11267.46			21.93	63.24					11352.63
Нарийн салаа	Сагил	Ховор ан амьтан хамгаалах	16043.74			7.37	64.94	32.83	0.78		124.34	16274.01
Хар азарга	Малчин	Байгалийн үзэсгэлэнт	465.17				1.55				266.35	733.07

		газар										
Гэдрэг булгийн эх	Малчин	Усны эх	27.34			0.64	1.46	0.01				29.45
Баянхайрхан	Малчин	Байгалийн үзэсгэлэнт газар	287.04		2.35					2653.76		2943.15
Шаргат	Өлгий	Ховор ан амьтан хамгаалах	2677.11		1.18							2678.29
Баруун улаан	Өлгий	Ховор ан амьтан хамгаалах	4768.75	0.35	3.13		5.20					4777.43
Рашаантын эх	Өлгий	Байгалийн үзэсгэлэнт газар	221.00									221.00
Өгөөмөр	Өлгий	Эртний бичээс	419.64			10.76						430.41
Баруун дооно	Зүүнхангай	Байгалийн үзэсгэлэнт газар	166.08				0.92	0.01		1879.91		2046.92
		Дүн										60584.66

НАЙМДУГААР БҮЛЭГ. АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТ ЗУГААЛГЫН БҮС НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

8.1. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ

8.1.1. Салбарын өнөөгийн байдал


Увс аймаг нь байгалийн бүс бүслүүр, экосистемийн олон иж бүрдлийг агуулсан “Дэлхийн өв”-ийн өлгий нутаг. Увс нуурын ай сав газар нь 1993 онд дархан цаазат газар, 1997 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын Соёл, Шинжлэх ухаан, боловсролын байгууллагын “Хүн ба шим мандал” хөтөлбөрийн хүрээнд хамрагддаг Дэлхийн Шим мандлын нөөц газарт, 2003 оны 8-р сард Дэлхийн байгалийн өвд, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай РАМСАР-ын конвенцид 1999 онд Айраг нуур, 2004 онд Увс, Ачит нуур тус тус бүртгэгдсэн ба аймгийн түүх соёлын болон байгалийн үзэсгэлэнт газар нутаг нь аялал жуулчлал хөгжүүлэх үндсэн боломж шинж чанар бүрдсэн гэж үзэж байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр (2008-2012)-т бүсийн аймгуудтай хамтран, аялал жуулчлалын сүлжээ байгуулах, сонгосон газар нутагт НИТАЖ-ын загвар бий болгож, түүний боломж, ашиг шимийг малчдад таниулах, бусад орнууд руу аялах суваг нээх, танилцах аялал, уулзалт зохион байгуулж, санал солилцох зорилтыг тавьжээ.

Аймгийн нутагт 1993 оны үеэс эхлэн аялал жуулчлалын компаниуд жуулчны бааз байгуулан, үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Энэ үеэс тусгай зөвшөөрлийн ан агнах аяллыг Өмнөговь, Түргэн, Наранбулаг, Ховд, Сагил, Бөхмөрөн сумдын нутагт нүүдлийн отог байгуулан, зохион байгуулж байсан. Одоогийн байдлаар 6 жуулчны бааз, амралтын газар ажиллаж байна. “ССТ-Од” ХХК Хархираа амралт жуулчлалын төвийг, “Баян барс” ХХК Хар тэрмэсийн рашаан сувиллын газруудад 30-40 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар засвар үйлчилгээ хийж, байр, гадна талбай, хоолны болон хүлээн авалтын танхимыг засварлаж, нэг ээлжиндээ 100-250 хүн хүлээн авч үйлчлэх боломжтой болсон. Хархираа, Хэцүү хад, Хар тэрмэсийн баазууд хамтран ажиллаж, аялал жуулчлалын сүлжээний эхлэл тавигдсан. “Онцын тасархай” ХХК Түргэн сумын Хиргэнэд, “Аргай аз” ХХК Увс нуурын орчинд жуулчны гэр бааз барьж ашиглалтад оруулсан. Увс нуурын ай савын Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа онгоцны буудалд мэдээллийн эко гэр барьж, дотоод, гадаадын жуулчид, аялагчдад үйлчилж байна. Жуулчдын аяллын маршрутыг сонгосон байдлыг авч үзвэл 50 хувь нь Хархираа, Түргэн, Цагаан шувуут уулсаар, 25 хувь нь Увс, Хяргас нуур, 5 хувь нь Алтан элс, Ханхөхийн чиглэлээр аялсан байна. Аймгийн төв Улаангом хотод хэд хэдэн зочид буудал, үйлчилгээний төв нээгдэж, зочдын байрлах орны тоо жуулчны баазуудынх ороод нийтдээ 600-д хүрч нэмэгдсэн. Улаангом-Хандгайтын чиглэлд хатуу хучилттай зам баригдаж, Боршоо боомтыг олон улсын статустай болгох шийдвэр гарч, гаалийн цогцолборыг барих асуудал эхэлснээр Оросын Холбооны Улс, бусад орнуудаас ирэх жуулчид, аялагч, амрагчдын тоо нэмэгдэх нөхцөл бүрдлээ.

Увс аймгийн нутагт 2009 онд Европ, Ази, Африк, Австрали, Америкаас 650 жуулчин, 2010 онд 715 жуулчид шууд буюу Ховд, Баян-өлгий аймгаас дамжиж ирсэн

байна. Дотоодын жуулчдын хувьд Хар тэрмис, Хархираа амралтын газар, Увс нуур, Онцын тасархай гэр баазуудад 2010 онд 5000 гаруй амрагчид амарч сувилуулсан байна. 2013 онд дотоодын -6868 жуулчин, гадаадын 1595 жуулчин аялсан байна.



Зураг №8.1. Увс Аймгийн жуулчны баазуудын байршил

Монголын аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний тухай мэдээллийн дүн шинжилгээний анхдагч эх үүсвэр болох Монголын аялал жуулчлалын жилийн эмхэтгэлээс үзэхэд аяллын оргил үе нь 4-10 сар хүртэл байгаа бөгөөд үүнээс 5-9 саруудад өндөр байна.

2010 онд Боршоогийн боомтоор нэвтэрсэн зорчигчдын тоог аяллын зорилгоор нь авч үзвэл, хувийн журмаар 8559, албан ажлаар 1411, байнга суух 4577, бусад зорилгоор 2082 хүн бүгд 16629 хүн орж ирсэн байна.



Зураг №8.2. Увс аймагт аялсан гадаад жуулчдын тоо

8.2. Аялал-рекреацийн бүс нутгийн төлөвлөлт

8.2.1. Аялал-рекреацийн чадавхын үнэлгээ, шинжилгээ

8.2.1.1. Нөхцөл байдлын шинжилгээ

Увс аймгийн аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал болон аймгийн нутаг дэвсгэрт хийсэн судалгааны баримт мэдээлэлд тулгуурлан, SWOT шинжилгээний аргаар аялал жуулчлалыг хөгжүүлэх давуу болон сул тал, таатай боломж болон эрсдэлийг авч үзсэнийг танилцуулъя. Үүнд:

Давуу тал

- Байгалийн бүс бүслүүр, экосистемийн олон иж бүрдлийг агуулсан “Дэлхийн өв” нутаг
- Мөнх цаст өндөр уулс, ойт хээр, хээр, говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс бүслүүрийг хамран оршиж байгаа нь аялал жуулчлалын олон төрөл, хэлбэрийг хөгжүүлэх
- Явган аялал явуулах байгалийн сайхан тогтоцтой /Хархираа-Түргэн-Цагаан Дэглий/
- Увс нуурын ай савын Дархан цаазат газрын Хархираа, Түргэн, Дэглий цагаан уулс нь эгц хажуутай, мөсөн голын хөндий, цавчим хадан хясаа бүхий авиралтын хүнд нөхцөлтэй нь адал явдал, эр зоригийн уулын аяллыг хөгжүүлэх
- Цэнгэг агаартай, цэлмэг өдрийн тоо олон тул шөнийн оддыг ажиглах
- Өргөн уудам нутаг, хүний гарт бага өртсөн онгон зэрлэг байгальтай. Дэлхийн улаан номонд орсон нэн ховор ирвэс болон алтайн аргаль, угалз, янгир, тэх, буга зэрэг өндөр уулын нэн ховор ан амьтантай нь гадаадын анчин жуулчдын сонирхлыг татах тул ан агнуурын аяллыг хөгжүүлэх
- Монгол орны хамгийн том нуур болох дархан цаазат Увс нуураар аялах, усанд сэлэх, шувуудын цуглааныг үзэх, дэлхийн бөмбөрцгийн хамгийн хойд захын элстэй цэг болох Алтан элсийг үзэх зэрэг дахин давтагдашгүй өвөрмөц гайхамшгийг аяллын нэг маршрутаар үзэх ховорхон боломжтой
- Хяргас нуурын сувилалд амрах, усанд сэлэх, наранд шарах их элсэн хаялгатай ба загасчлах, хар галуу, цахлайн өвөрмөц амьдралтай танилцах

- Түүх соёлын дурсгалт газар олонтой
- Нүүдлийн соёл иргэншил, ахуйг өнөөг хүртэл хадгалсан олон ястны уламжлал зан заншил бүхий нутаг
- Цаг уурын эрс тэс уур амьсгалтай, өөрөөр хэлбэл хэт халуун, хэтэрхий хүйтэн нь зарим адал явдалтангуудад таалагдана.
- Хоёр хөрш орныг холбосон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Сул тал

- Монгол орны баруун хойд хэсэгт орших бөгөөд улсын нийслэлээс алслагдсан тул аялал жуулчлалын нөөцийг зах зээлийн эргэлтэнд оруулах боломж хязгаарлагдмал
- Дэд бүтэц, зам тээврийн сүлжээ муу, хэт алслагдсан тул үүнээс шалтгаалан аяллын зардал өндөр, хугацаа урт байдаг нь хямд аялах сонирхолтой жуулчдын хувьд бэрхшээлтэй
- Жуулчны бааз, шаардлага хангах үйлчилгээний иж бүрэн байгууламж, материаллаг бааз хангалтгүй
- Экологийн хувьд эмзэг, эрс тэс уур амьсгалтай
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, даац нь бүрэн тогтоогдоогүй
- Аялал жуулчлалын удирдлага зохион байгуулалтын бүтэц бүрдээгүй, мэргэжлийн боловсон хүчин дутмаг, нутгийн захиргааны байгууллагад нь аялал жуулчлалын мэргэжилтэн дагнан ажилладаггүй
- Аялал жуулчлалын мэргэжилтэй ажилчид /хэлмэрч, тогооч, үйлчлэгч, газарч бэлтгэгдээгүй
- Байгаль орчин, ан амьтан, ургамал, зах зээлийн талаар хийсэн орон нутгийн суурь судалгаа дутмаг
- Орон нутгийн онцлогийг тусгасан бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэл, борлуулах нэгдсэн сүлжээ байхгүй
- Баруун аймгуудын хэмжээнд нэгдсэн маршрут сүлжээ гараагүй, хамтран томоохон сурталчилгаа хийх боломж хомс, төрөлжсөн зар сурталчилгааны ач холбогдлыг үнэлдэггүй
- Гадаадад шууд нислэггүй
- Замын тэмдэг тэмдэглэгээ бүрэн хийгдээгүй
- Аялал жуулчлалын улирал богино
- Жуулчдад зориулсан арга хэмжээ зохион байгуулдаггүй.

Боломжит нөхцөл

- Монгол улс аялал жуулчлалын зорих газар хэмээн дэлхийд танигдах болсон нь манай улсыг зорин ирэх гадаадын жуулчдын тоо нэмэгдэхэд нөлөөлж байгаа
- Олон улсын хэмжээнд идэвхитэй болон тусгай сонирхолын аяллын хэлбэрүүд тухайлбал: явган болон морин аялал, малчин айлын ахуй амьдралын хэв маягтай танилцах, суралцах аялалд оролцогчдын тоо өсөн нэмэгдэх боломжтой
- Гадаргын олон хэлбэрт хэв шинжийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон зөв зохистой ашиглах

- Байгаль орчинд эвсэг аяллыг нутгийн иргэдэд түшиглэн зохион байгуулж, тэднийг ажлын байр, орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх
- Ховд их сургууль, Улаангом коллежийг түшиглэн аялал жуулчлалын мэргэжилтэй ажилтанг бэлтгэх
- Ссургалт сурталчилгааны нэгдсэн сүлжээг үүсгэх, хөгжүүлэх
- Олон улсын аялал жуулчлалын байгууллага, агентлагын гишүүнээр элсэж, олон талын хөнгөлөлт эдлэх, сурталчилгаа хийх боломжыг нэмэгдүүлэх
- Дэлхийн том гүрэн ОХУ-тай шууд хиллэдэг, тэрчлэн Боршоо боомтыг олон улсын статустай болгох асуудлыг шийдсэн нь хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлж эхэлсэн
- Чацаргана, жамц давс, арвайн гурил зэрэг брэнд бүтээгдэхүүний аяллыг зохион явуулах боломжтой
- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 18.3% нь Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан
- Дэглий цагаан нисэх онгоцны буудал шинээр нээгдэж, том онгоц буух нөхцөл бүрдсэн
- Хяргас нуурын хөвөөгөөр хатуу хучилттай зам барьж эхэлсэн, Хархираа-Улаангом-Увс нуур чиглэлд хатуу хучилттай зам барих зураг, төсөв хийгдсэн
- Дотоодын аялагчдын тоо сүүлийн жилүүдэд ихээхэн өсөж байгаа.
- Нүүдэлчин угсаатны соёлыг харуулсан төв байгуулах боломж өндөр

Эрсдэл

- Ховор амьтдын өлгий нутгийн аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын нөөц төвлөрсөн байгаа нь нөөцийн хэт ачааллаас үүдэж элэгдэл эвдрэлд орох, бүсийн хөгжлийн тэнцвэргүй байдал үүсэх
- Буруу менежмент, хэт ачааллаас хамгаалалттай бүс нутаг, байгалийн нөөц, үзмэрүүд өртөж, сүйдэх
- Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай тул байгалийн гэнэтийн үзэгдэлд /дочир хүйтрэл, ган, үер, шороон шуурга/ өртөх магадлал өндөр
- Аялал жуулчлалын үзмэрүүдэд хадгалалт хамгаалалт дутагдсанаас элэгдэж муудан, ач холбогдол нь буурах
- Гадаргын хэвгийн хэрчигдэл нь дэд бүтцийн хөгжилд сөргөөр нөлөөлөх
- Малчдын уламжлалт соёл, зочломтгой чанар, нүүдэлчний соёл иргэншил өөрийн дүр төрхөө алдаж болзошгүй
- Хувиараа алт олборлогчид байгалийн унаган төрхийг хөндөх, байгаль орчны экологийн тэнцвэрийг алдагдуулах
- Ойн түймэр, хулгайн ан, хууль бусаар мод бэлтгэх болон хог хаягдлын зохицуулалтгүй байдал зэрэг нь байгаль орчны доройтлыг бий болгох
- Дотоодын жуулчдын эмх замбараагүй, хяналтгүй байдал

Дээрхи SWOT шинжилгээнд үндэслэн давуу талыг ашиглан таатай боломжуудыг нэмэгдүүлэх, сул талаа хянах, багасгах арга замыг тодорхойлж, учирч болох эрсдэлээс

урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тооцох нь аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд ач холбогдолтой.

8.2.1.2. Аялал жуулчлалын үйлчилгээний хамгамжийн үнэлгээ

Байрлуулах үйлчилгээ

Тус аймгийн нутагт 1993 оны үеэс эхлэн аялал жуулчлалын компаниуд жуулчны баазууд байгуулан үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Одоогийн байдлаар 7 жуулчны бааз, амралтын газар ажиллаж байна. Хан хөхий Хяргас нуурын байгалийн цогцолборт газарт “Хэцүү хад”, “Хар Тэрмис” жуулчны бааз, Хархираа, Түргэний уулсад “Онцын тасархай”, “Хархираа” жуулчны бааз, Тэсийн Бага жаргалан, “Увс нуур” жуулчны баазууд, Цүнхэг амралтын газар үйл ажиллагаагаа явуулж байна. Сумдын тамгын газрын дэргэд дэн буудал ажилладаг. Одоогийн байдлаар:

а). Зочид буудал:

Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан 80 ор бүхий 3 зочид буудал аймгийн төвд байна. (Баялаг од, ССТ-5 од, Хяргас нуур), .(Хүснэгт 8.3)

Хүснэгт №8.1. Зочид буудлын судалгаа

Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Үйлчилгээний төрөл	Орны тоо, хүчин чадал
1	“ССТ-5 Од” ХХК “Таван Од”	Зочид буудал, ресторан	55 ор, 250 суудал бүхий ресторан
2	“Увс шилтгээн” ХХК “Баялаг од”	Зочид буудал	30 ор, 40 суудал бүхий ресторан
3	“Бумномин” ХХК Их наяд	Зочид буудал, баар ресторан	40 ор, 150 суудал бүхий баар, ресторан
4	Увс Плаза	Зочид буудал	25 ор, 50 суудал бүхий ресторан
5	Ачит нуур	Зочид буудал	40 ор, 100 суудал бүхий ресторан
6	Чингис	Зочид буудал	40 ор, 60 суудал бүхий ресторан
7	Хөдөлмөрийн шим хоршоо “Хяргас нуур”	Зочид буудал	20 ор, 40 суудал бүхий ресторан
8	Хүслэн	Зочид буудал	20 ортой
9	Шинэ Ойрад	Гэуст хаус	15 ортой

б). Жуулчны бааз:

Хэцүү хад, Увс нуур, Онцын тасархай, Хархираа, Хар тэрмис, Бага жаргалан жуулчны баазууд үйл ажиллагаагаа явуулж байна. 470 ор бүхий 5 жуулчны баазтай.

в). Амралт сувиллын газрууд:

Хяргас нуурын Хар тэрмис амралтын газар, Цүнхэгийн амралт, Хархираа хүүхдийн зуслан үйл ажиллагаагаа явуулж байна. Амралт сувиллын газрууд нь 6-9 сард ажилладаг. (Хүснэгт 8.4)

Хүснэгт №8.2. Жуулчны бааз, амралтын газар

Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Үйлчилгээний төрөл	Хүчин чадал
1.	“Сайхан халиун” ХХК “Хэцүү хад”	Жуулчны бааз	45 ортой, 25 суудалтай зоогийн газартай
2.	“Онцын тасархай тур” ХХК “Хиргэнэ”	Жуулчны бааз	55 ортой, 60 суудалтай зоогийн газар
3.	“Увс нуур” Аргай аз ХХК	Жуулчны бааз	30 ортой, 30 суудалтай зоогийн газар

4.	“Престич” ХХК Тэс, “Бага Жаргалан”	Жуулчны бааз	15 ортой, 20 суудалтай зоогийн газар
5.	“Баянбарс” ХХК “Хар тэрмис”	Амралт, рашаан сувилал	100 ортой, 100 суудалтай зоогийн газар
6.	“Их барилга” ХХК “Цүнхэг”	Амралт	50 ортой, 50 суудалтай зоогийн газар
7.	ССТ-Од ХХК “Хархираа”	Амралт	150 ортой, 150 суудалтай зоогийн газар
8.	“Их нуур тур” ХХК “Хархираа”	Амралт	25 ортой
9.	Гивант	Рашаан сувилал	100 ортой

Хоол ундааны үйлчилгээ

Жуулчны баазууд болон, амралт сувиллын газрууд дэргэдээ ази, европ, монгол үндэсний хоолоор үйлчлэх тохилог хоолны газартай. Улаангом хотод 800 гаруй суудалтай 12 зоогийн газар, ресторан ажиллаж байна. (Хүснэгт 8.3)

Хүснэгт №8.3. Зоогийн газар, кафе бусад үйлчилгээ


Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Үйлчилгээний төрөл	Хүчин чадал
1	Баянцагаан ХХК Маргад	Баар, ресторан	100 хүн
2	“Цэнгүүн чингүүн” ХХК “Ачит нуур”	Ресторан	100 хүн
3	“Жангармөрөн” ХХК “Жангар”	Ресторан, зоогийн газар	50 хүн
4	“Увс шилтгээн” ХХК “Улаангом”	Ресторан, зоогийн газар	80 хүн
5	“Өгөөмөр “хоршоо “Билэг төв”	Зоогийн газар	50 хүн
6.	“Улаан сарнай “ХХК “Сарнай”	Ресторан, зоогийн газар	150 хүн
7	“Найрсаг Андууд” ХХК “Андууд”	Баар, зоогийн газар	100 хүн
8	“Гранд плаза “ХХК “Их монгол”	Паб, зоогийн газар	40 хүн
9	“Чингис “	Ресторан	40 хүн
10	“Голд” ХХК	Паб	40 хүн
11	“Газар жимст” ХХК “Уянга”	Кафе	35 хүн
12	“Тунгалаг тамир”	кафе	35 хүн
13	“ССТ-5 од” ХХК Таван од	Ресторан, Зоогийн газар	250 хүн
14	“Бум номин” ХХК Их наяд	Баар, Зоогийн газар	120 хүн
15	“Family”	Паб	40 хүн
16	“Оргилуун”	Зоогийн газар	40
17	“Royal”	Ресторан	50
18	“Ундармал улаан сарнай “	Зоогийн газар	60

8.2.1.3. Гадаргын аялал рекреацийн үнэлгээ

Амралт аялал жуулчлалын хөгжилд газрын гадаргын хотгор гүдгэр нь тэргүүлэх хүчин зүйл болж улмаар аялал рекреацийн танин мэдэхүйн болон гоозүйн үнэт зүйлсийг тодорхойлж байдаг. Увс аймгийн гадаргын аялал рекреацийн үнэлгээг хийхдээ газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээг гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу, байнгын амралтын суурин байгуулах нутаг дэвсгэр гэсэн дөтвөн шалгуур үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийсэн. Л.Баясгалангийн (2010) шалгуур, шатлалыг баримтлав.

Судалгааны үр дүнд тус аймгийн нутагт гадаргын хувьд аялал рекреацийн сул, дунд өндөр, нэн өндөр үнэлгээтэй ландшафтын хэв шинжүүдийг ялган тогтоосон болно.

Увс аймгийн газрын гадаргын аялал рекреацийн үнэлгээгээр хамгийн өндөр буюу Бөхмөрөн, Тариалан, Түргэн, Давст сумдын гадаргын хотгор гүдгэрийн хослолууд нь ландшафтын бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хамт аялал-рекреацийн олон төрлийн үйлдлийг хийж болно.



Зураг №8.3. Аялал-рекреацийн ландшафтын үнэлгээ

8.2.1.4. Уур амьсгалын рекреацийн үнэлгээ

Өнөө үед тухайн нутаг дэвсгэрийн цаг уур хүний эрүүл мэндэд төдийгүй сатгэлзүйн хувьд хэрхэн нөлөөлж буйг үнэлэх нь чухал юм. Уур амьсгалын нөхцлийн аялал рекреацийн үнэлгээ нь юуны өмнө физиологийн үүднээс өөрөөр хэлбэл хүний бие организмд цаг уурын нөлөөг тооцоход чиглэгдэнэ. Тухайн нутаг дэвсгэрийн үнэ цэнэ хүний бие организмд тохитой, эмчилгээтэй гэж тааламжтай нөхцөлтэй үеийн үргэлжлэх хугацаагаар тодорхойлогддог. түүний гол үзүүлэлтүүдэд:

Зуны улиралд :


1. Агаарын температурын тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа
2. Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа
3. Агаарын харьцангуй чийгшил

Өвлийн улиралд:

1. Агаарын температурын тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа
2. Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа
3. Салхины горим

4. Цасан бүрхүүл

Увс аймгийн уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон нар гийгүүлэх хугацаа, агаарын температурын хоногийн дундаж 10^0 ба түүнээс дээш байх өдөр, агаарын харьцангуй чийгийн дундаж, 13 цагт (1-р сар, 4-р сар, 7-р сар, 10-р сар), цасан бүрхүүлийн зузаан, тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа гэсэн 5 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашигласан.




Зураг №8.4. Аялал-рекреацийн уур амьсгалын үнэлгээ

Өвөл, хаврын улиралд харьцангуй сэрүүвтэр, хүйтэн байдаг учраас аялал-рекреацийн төрөл хязгаарлагдмал байна. Энэ үед өвлийн аялал, уулын спорт аялал зэрэг хүний биеэс дулаан ялгаруулах үйлдэлтэй аялал рекреацийн төрлийг илүү явуулах нь зохимжтой. Бидний судалгаагаар аялал рекреацийн үйд ажиллагаанд тохиромжтой хугацаа дулааны улиралд 70-80 хоног байна. Увс аймгийн уур амьсгалын рекреацийн үнэлгээгээр нэн өндөр, өндөр, дунд, сул үнэлгээтэй нутгууд ялгарч байна. Үүнд: Зүүнхангай, Өндөрхангай, Хяргас, Улаангом, Хархираа, Тариалан сумдын нутгийн уур амьсгал нь аялал рекреацийн үйл ажиллагааг явуулахад илүү тохиромжтой байна.

8.2.1.5. Гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээ

Тухайн газар нутгийн ус нь рекреацийн үнэ цэнэ, амралт аялал жуулчлалын олон төрлийг тодорхойлдог. Увс аймгийн гадаргын ус, рашааны рекреацийн нөөцийн үнэлгээг 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар Үндэсний атласаас “Голын сүлжээний нягтшил”

1:12000000 масштабтай газрын зургийг, “Рашаан”, “Гол мөрний нийлбэр урсац” 1:9000000 масштабтай газрын зургуудыг 1:3000000 масштабт шилжүүлэн тулгуур материал болгон ашиглав. Голын сүлжээ, нуур, булаг шанд нь ландшафтын гадаад төрхөд нөлөөлж, аялал рекреацийн объектын байршилтанд олон талаар нөлөөлнө.




Зураг №8.5. Ус, рашааны аялал-рекреацийн үнэлгээний зураг

Зургаас үзэхэд тус аймгийн нутагт гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээгээр нэн өндөр ландшафтын хэв шинж илэрсэнгүй. Харин өндөр, дунд сул үнэлгээтэй нутаг дэвсгэрүүд ялгарч байна. Увс аймгийн Тэс, Баруунтуруун, Ховд, Түргэн, Давст, Зүүнговь, Зүүнхагай, Наранбулаг, Улаангом сумдын нутагт усан спорт аялал, дотоодын жуулчдад зориулан рашаан эмчилгээний төрлүүдийг түлхүү хөгжүүлэх нөөц боломжтой.

8.2.1.6. Увс аймгийн ургамалжилтын аялал рекреацийн үнэлгээ

Увс аймгийн ургамалжилтын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Ургамлын бүлгэмдлийн хэв шинж”, “Нутаг дэвсгэрийн ойрхог байдал”, “Ховор ургамал” гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийлээ.




Зураг №8.6. Ургамалын аялал-рекреацийн үнэлгээний зураг

Увс аймгийн ургамалжилтын аялал рекреацийн үнэлгээгээр Увс, Хяргас нуурын ойр орчмын нутаг дэвсгэр болон Тэс, Давст, Хархираа, Тариалан, Завхан сумдын нутаг өндөр үнэлгээтэй байна. Увс нуурын эрэг орчим, Тэсийн голын адаг орчмоор улиасан төгөл, бургасан шугуй, тэмээн харгана бүхий алаг өвст, үент, нугын бүлгэмдэл зонхилох бөгөөд Алтангагнуур, вансэмбэрүү, алтан хундага, нохойн хошуу, тарваган шийр, халгай, таван салаа, хунчир зэрэг эмийн ургамал, дэрэн алжиргана, Невскийн хиаг, грубовын хунчир зэрэг унаган ургамалуудтай. Чацаргана, үхрийн нүд, гүзээлзгэнэ, тошлой, мойл, анис, зэдгэнэ зэрэг жимс жимсгэнэтэй. Иймээс тус сумдын нутагт байгалийн аяллын төрөл болох цэцэг ажиглах, болон эрдэм шинжилгээ судалгааны аялалын төрлүүдийг түлхүү хөгжүүлэх боломжтой.

8.2.1.7. Увс аймгийн ховор амьтны рекреацийн үнэлгээ

Увс аймгийн амьтны рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Загас”, “Шувууны газарзүйн мужлалт, ховор шувуу”, “Хөхтөний газарзүйн мужлалт, ховор хөхтөн” гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:10000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашигласан. Бидний судалгаагаар тус аймгийн нутаг дэвсгэрт өндөр, дунд, сул хэв шинжүүдийг ялгасан. Увс аймгийн ховор амьтны аялал рекреацийн үнэлгээгээр Бөхмөрөн, Тэс, Зүүнговь, Давст, Хархираа, Улаангом, Завхан сумдын нутагт Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн нэн ховор, ховор ан амьтдаас зэгсний гахай, Азийн минж, хуруут хун, цасч тэглэй, хээрийн галуу зэрэг олон зүйлийн амьтадтай. Иймээс тус сумдын нутагт тусгай сонирхолын аяллын төрөл болох


спорт агнуур, загасчлах болон шувуу ажиглах аяллын төрлүүдийг түлхүү хөгжүүлэх боломжтой.



Зураг №8.7. Ховор амьтны аялал-рекреацийн зураг

8.2.1.8. Увс аймгийн ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээ

Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр ландшафтын болон аялал-рекреацийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг олж тогтоох, ашиглаж байгаа болон ашиглаж болохуйц газруудад учирч буй эрсдэл, энэ эрсдлийг бууруулах болон арилгах боломж, хүн ам байнга оршин суудаг болон эзэмшигдээгүй нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал, түүнтэй уялдан тухайн газарт аялал-рекреацийн нутаг дэвсгэрийн систем бүрэлдэх урьдчилсан нөхцлийг илрүүлэх нь зүйтэй. Тиймээс Увс аймгийн ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээг байгалийн иж бүрдүүлүүдийн үзүүлэлт бүрээр хийсэн үнэлгээнийхээ үр дүнг нэгтгэж гаргав.




Зураг №8.8. Аялал-рекреацийн ландшафтын үнэлгээний зураг

8.2.1.9. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх-соёлын дурсгалуудын аялал-рекреацийн үнэлгээ

Байгалийн үзэсгэлэнт газар, түүх-соёлын дурсгалын аялал-рекреацийн үнэлгээг хийхийн тулд засаг, захиргааны нэгж болох тухайн сумын нутаг дэвсгэр дэхь дурсгалуудын жагсаалтыг гаргаж, үр дүнгээр нь тоон утгыг тооцсон. Энэ тоон үзүүлэлтэнд үндэслэн Увс аймгийн түүх-соёлын чадавхийн аялал-рекреацийн үнэлгээг дөрвөн шатлал, шалгуур үзүүлэлтээр үнэлэв. Сум тус бүрээр дээрхи шалгуур, 4 шатлалын дагуу байгалийн түүх соёлын дурсгалын аялал-рекреацийн ерөнхий үнэлгээг хийх дээрхи дурсгалуудын тоогоор хийсэн үзүүлэлт тус бүрийн үнэлгээний дүнг нэгтгэн гаргаж, түүх, соёлын нөөцийн ерөнхий чадавхийг тогтоосон.


Увс аймгийн байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалуудын аялал рекреацийн үнэлгээгээр Тариалан, Сагил, Давст, Улаангом, Хархираа, Малчин, сумдын нутаг өндөр үнэлгээтэй гарсан бөгөөд 1997 онд Нэгдсэн Үндэсний байгууллагын Соёл, Шинжлэх ухаан, боловсролын байгууллагын “Хүн ба шим мандал” хөтөлбөрийн хүрээнд хамрагддаг Дэлхийн Шим мандлын нөөц газарт, 2003 оны 8-р сард Дэлхийн байгалийн өвд, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай РАМСАР-ын конвенцид 1999 онд Айраг нуур, 2004 онд Увс, Ачит нуур тус тус бүртгэгдсэн нь цаашид түүх соёлын болон байгалийн аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх боломжтой.



Зураг №8.9. Байгалийн болон түүх соёлын аялал рекреацийн үнэлгээний зураг

8.2.1.10. Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээ

Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хийхдээ засаг, захиргааны хувиарыг баримтлав. Тэгэхдээ түүх, соёлын аялал-рекреацийн чадавхийн түвшинг ландшафт-рекреацийн чадавхийн дундаж түвшинтэй харьцуулж тухайн цогцолборт нутаг дэвсгэрийн аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хийсэн. Увс аймгийн ландшафт-рекреацийн чадавхийн дундаж түвшинг, тус нутагт ландшафтын ямар хэв шинж хамгийн их нутгийг хамарч байгаагаар буюу картограммын аргаар тодорхойлов. Увс аймгийн аялал-рекреацийн чадавхийн интеграль үнэлгээний түвшинг тодорхойлохын тулд Л.Баясгалангийн “Өвөрхангай аймгийн аялал-рекреацийн чадавхийн рекреацийн иж бүрэн үнэлгээ” хийсэн аргазүйн дагуу шатлал боловсруулж ашиглав.



Зураг №8.10. Аялал-рекреацийн нэгдсэн үнэлгээний зураг

Увс аймгийн засаг захиргааны нэгж сумаар авч үзвэл аялал рекреацийн нэн өндөр чадавхитай сум илэрсэнгүй. Харин аялал рекреацийн чадавхи өндөртэй нутгуудад Тариалан, Сагил, Давст, Түргэн сумд, дунд чадавхитай нутгуудад Ховд, Цагаан хайрхан, Баруун туруун, Бөхмөрөн, Малчин, Хяргас, Наранбулаг, Өндөрхангай сумд, сул чадавхитай нутгуудад Завхан, Өмнөговь, Тэс, Зүүнговь, Зүүнхангай, Өлгий сумдын нутаг дэвсгэр хамаарч байна. Энэ нь аялал рекреацийн бүсчлэл хийх үндэс болж байгаа юм. Нэг нэгэнтэйгээ зэрэгцэн оршиж буй нутаг дэвсгэрүүдийг үнэлгээний төстэй үзүүлэлтүүдээр нь нэг ерөнхий ареальд оруулж нэгтгэх замаар бүсчилсний үр дүнд тус аймагт аялал рекреацийн гурван район ялгарч байна. Үүнд:

1. Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг
2. Аялал рекреацийн чадавхи дунд бүс нутаг
3. Аялал рекреацийн чадавхи султай бүс нутаг гэсэн аялал рекреацийн чадавхийн түвшний ялгаатай нутгууд юм.


8.2.2. Аялал-рекреацийн бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөлт**8.2.2.1. Увс аймагт хөгжүүлэх боломжтой аялалын төрлүүд**

Хүснэгт №8.4. Аялал рекреацийн бүс нутгуудад хөгжүүлэх боломжтой аялалын төрлүүд

Аялал рекреацийн бүсүүд	Түүх соёлын дурсгалт газрууд	Байгалийн үзэсгэлэнт газрууд, ховор ба нэн ховор ургамал, ан амьтад	Цаашид хөгжүүлэх боломжтой ерөнхий ба тусгай сонирхолын аялалын төрлүүд
Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг (Тариалан, Сагил, Давст, Түргэн, Улаангом) сумдын нутаг	Халхайтын дэнжийн хүн чулуун хөшөө, Бор нурганы хүн чулуун хөшөө, Мөнгөт цахирын хадны зураг, Тэхтийн давааны хадны зураг, Харлаг бээсийн сүм, Чандманы дурсгал, Хар ямаат, Сартагтай хааны түүхт хад, Мянганы хөндийн дурсгалт газрууд	Увс нуурын ДЦГ, Цагаан шувуутын ДЦГ, Хархираа- Түргэний уул Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн нэн ховор, ховор ан амьтдаас зэгсний гахай, Хүдэр, буга, согоо, Азийн минж, хуруут хун, цасч тэглэй, хээрийн галуу, Үүрэг нуур	<ul style="list-style-type: none"> ➤ Нэн ховор амьтан түүний ул мөрөөр аялах аялал: Хархираа, Түргэний уул, Ямаат уул, Цагаан шувуут уулын нутгаар зэрлэг байгалийн “хатан хаан” ирвэсийн хаяг, бумбаа, мод самардсан зэрэг ул мөрөөр аялах төдийгүй аргаль, янгирыг ажиглан харах боломжтой. ➤ Усан спорт аялал Увс, Хяргас, Ачит, Үүрэг, Айраг, Дөрөө, Баян нуурууд, Ховд, Тэс, Хархираа, Түргэн, Шивэр, Нарийн, Хангилцаг зэрэг голуудаар завиар аялах боломжтой ➤ Уулын аялал: Хархираа, Түргэний уулс, Цагаан шувуут, Цагаан Дэглийн мөнх цаст өндөр оргилуудад авирах ➤ Шувуу ажиглах аялал: Увс, Үүрэг нуур зэрэгт усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах боломжтой. ➤ Цэцэг ажиглах аялал Хархираа, Түргэний уулс орчмын газар нутаг нь явган аяллын хувьд хамгийн тохиромжтой байгалийн иж бүрдэл бүрдсэн экзотик шинжтэй. ➤ Нүүдэлчдийн амьдралтай танилцах болон угсаатны аялал: Баяд, дөрвөд, халх, хотон ястан малчин айлд зочлон нүүдэлчин ахуйтай танилцах, соёл зан заншил, нутгийн зан үйлд суралцах, хоол цай амтлах, “Нүүдэлчдийн хотхон” байгуулах зэрэг сонирхолтой идэвхитэй аяллыг нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой. ➤ Түүх соёлын аялал Сагил, Давст сумын чиглэлд илүүтэй хөгжүүлэх боломжтой. ➤ Байгалийн аялал Дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн үзэсгэлэнт нутаг харьцангуй богино зайнд байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинжийг харах ➤ Амралт сувилгааны аялал ➤ Эрдэм шинжилгээ судалгааны аялал ➤ Бартаат замын буюу авто аялал
Аялал рекреацийн чадавхи дунд бүс нутаг (Ховд, Цагаан хайрхан, Баруун туруун, Бөхмөрөн, Малчин, Хяргас, Наранбулаг, Өндөрхангай сумд)	Хар Цагаан усны хадны зураг, Улаан толгойн дурсгал, Жаажаагийн хөтөлийн хүн чулуун хөшөө, Наранбулагийн хадны зураг	Гоожуурын хүрхэрээ, Ханхөхий-Хяргас нуур -А-Б, Хархираа-Түргэний, Алтан элс, Увс нуурын, Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн нэн ховор, ховор ургамал, ан амьтдаас Янгир, ирвэс, хойлог, зэгсний гахай, Азийн минж, хуруут хун, цасч	<ul style="list-style-type: none"> ➤ Ан агнуурын аялал: Ховдын Отор, Түргэний Шаварт, Атар, Сагил, Бөхмөрөний нутаг дамнасан “Гулзат”, Ханхөхийн салбар уулс орчмоос буга, тэх, угалз, бор гөрөөс, гахай зэрэг нэн ховор амьтныг тусгай зөвшөөрлөөр агнаж болно. Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө зэрэг нуураас загас барих боломжтой. ➤ Шувуу ажиглах аялал Хяргас нуур, Хяргас Айрагийн хоолой, Үүрэг нуур зэрэгт усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах

		тэглэй, хээрийн галуу вансэмбэрүү, цагаан уул цэцэг, төрөл бүрийн эмийн ургамал, мөнх цаст өндөр уулс	боломжтой. ➤ Усан спорт аялал ➤ Морь , тэмээн аялал ➤ Угсаатны аялал ➤ Түүх соёлын аялал ➤ Амралт сувилалын аялал жуулчлал
Аялал рекреацийн чадавхи султай бүс нутаг (Завхан, Өмнөговь, Тэс, Зүүнговь, Зүүнхангай, Өлгий сумд)	Шар булгийн хадны зураг, Зураагийн улаан хадны зосон зураг, Шар булгийн онцын хадны зураг	Ханхөхий-Хяргас нуур-А, хэцүү хад, Увс нуур, Тэсийн гол, Ханхөхий-Хяргас нуур-Б, Таван цонж	➤ Явган ба морин, тэмээн аялал: Баян нуур, Бөөрөг дэлийн элсний чиглэлд явган ба морь, тэмээн аяллыг тодорхой зам маршрутын дагуу нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой. ➤ Түүх соёлын аялал ➤ Угсаатны аялал

Санал болгож буй эдгээр аяллыг дагнасан хэлбэрээр хөгжүүлэхээс гадна хосолсон байдлаар хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм. Мөн сумын наадам, даншиг, овоо тахилга, бэсрэг наадам зэрэг орон нутгийн тэмдэглэлт үйл явдлуудтай холбосон аяллын хөтөлбөр, тухайн бүсийн онцлогт тулгуурласан төрөл бүрийн эвент арга хэмжээг зохион байгуулах нь илүү үр дүнтэй. Морь, тэмээ хөлслөхөөс гадна орон нутгийн онцлогийг харуулсан гар урлалын бүтээгдэхүүн бэлэг дурсгалын зүйлсийг үйлдвэрлэхэд нутгийн иргэдийг татан оролцуулж, тэдний орлогыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр иргэд, малчдын нөхөрлөлд сургалт зохион байгуулан, эсгий урлал, нэхмэл, хатгамал, сийлбэр хийх, үндэсний хувцас дээл, малгай, хантааз оёх зэрэг өрхийн болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих боломж байна.



Зураг №8.11. Увс аймгийн аялал-рекреацийн үнэлгээнд тулгуурласан төлөвлөлтийн зураг

8.2.2.2. Увс аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газар нутгууд, аялалын төрлүүд

Хүснэгт №8.5. Увс аймгийн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой газар нутгууд

№	Сумын нэр	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй газрууд	Шинээр төлөвлөж буй газрууд
1.	Завхан	Хэцүү хад жуулчны бааз /1 га/	Гурван нуурын сэлгээ /1га/
2.	Өмнөговь		Яргайт /1га/ Ногоон цэгээний рашаан /1га/
3.	Ховд		Шаазгай нуур /1га/ Гоожуур орчинд /1га/ Олон нуур орчинд/1га/
4.	Тариалан		Увс нуурын хөвөөнд /1га/ Тээлийн бургас орчинд / 1га/ Цагаан хөтөл орчинд/ 1га/
5.	Цагаан хайрхан		Хилэнгийн ам /1га/
6.	Баруун туруун		Сумын төвийн хиймэл нуурын орчим амралтын газар /1га/
7.	Бөхмөрөн		Ямаат гол /1га/ Шар харгайн рашаан 1/ га/
8.	Сагил		Үүрэг нуур, Хуучин тээврийн буудал / 1га/ Үүрэг нуур, Хөх эрэг орчинд /1га/ Боршоогийн гүүр орчинд /1га/
9.	Давст		Торхилогын гол, Давсны уурхайн орчим /1га/ Хатуугийн уул, Мөнгөт цахир орчинд /1га/ Хандгайтын Мэргэн шанаа /1га/
10.	Тэс		Увс нуурын зүүн талд хуучин амралтын бүст /1га/
11.	Зүүнговь		Баян нуурын хоолой /1га/
12.	Малчин	Хар тэрмис рашаан сувилал /1га/	Хар тэрмис /4 га/ Хяргас нуур, Малчин сум, Акаевын хошуу орчинд /1га/ сумын төвд цанын бааз, талбай/1га/
13.	Хяргас		Довны худаг/1га/ Хяргас нуур, Хяргас сум, Хөх дэрсний шугам орчинд/1га/
14.	Түргэн	Онцын тасархай жуулчны бааз,/1га/ Хархираа уулын цүнхэг /1га/	Цүнхэг амралтын газрын доод талд / 2га/ Дэлгэрмөрөнд уулын аяллын бааз /1га/ Долоодойн Буцалдагийн рашаан /1 га/ Бургастайн рашаан/ 1га/
15.	Өндөрхангай		Арслан толгой /1 га/ Алтан бургас, Буштагийн орчинд/ 1га/
16.	Зүүн хангай	Гивант рашаан сувилал /1га/	Согоо нуур /1га/
17.	Наранбулаг		Хяргас нуур, Наранбулагийн Тээг орчинд /1га/
18.	Өлгий		Өлгий сондуулын голын ам /1га/ Сондуултын рашаан /1га/
19.	Улаангом	Увс нуур жуулчны бааз, Ачит нуур ХХК, Баялаг од Увс шилтгээн ХХК, Их наяд Бумномин ХХК, Увс плаза, ССТ-Од ХХК, Шинэ-Ойрд ХХК /5га/	Увс нуурын ТХГ-ын орчны бүсэд, Улаангом сумын нутагт /2га/ Хархираа уулын бэлд цанын бааз, талбай /1га/

Боломжит аяллын төрөл, замнал

Байгалийн аялал жуулчлал бол Увс аймгийн аялал жуулчлалын чухал тэргүүлэх чиглэл юм. Дэлхийн байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинж төрхийг агуулсан **“Увс нуурын их ай сав”** хэмээх өргөн уудам нутаг бүхий байгалийн нөөцөөр баялаг, онгон зэрлэг байгаль, цэнгэг уст голууд, Монголын хамгийн том нуур, зэрлэг амьтадтай **“Төв Азийн эко системийн эталон”** нутаг төдийгүй олон ястан бүхий нүүдэлчин ардын ахуй амьдрал, зан заншил нь аялал жуулчлал хөгжих үндэс суурь юм.

Өнөөгийн байдлаар аймгийн нутагт дараахь чиглэлийн аяллуудыг санал болгон зохион байгуулж байна. Үүнд:

а) Богино хугацаат буюу өдрийн аялал

Аяллын замнал нь: Улаангом-Увс нуур –Улаангом

Аяллын замнал нь: Улаангом- Хархираа, Цүнхэгийн амралт- Улаангом

б) Дархан цаазат болон орон нутгийн хамгаалалттай газрын чиглэлд:

Монгол улсын хамгийн том талбайтай Увс нуур, анхны үүслээ хадгалж үлдсэн дэлхийн хамгийн хойд цэгт орших Алтан элс, Тэс, Торхилогийн голын адгийн үзэсгэлэнт орчин, Цагаан шувуут, Цагаан дэглий зэрэг мөнх цаст өндөр уулсын гайхам тогтоцыг ажиглан харж, Хархираа, Онцын тасархай жуулчны баазад амрах, Увс нуурын усанд сэлэх, усны шувуудын цуглааныг үзэх зэргээр 5 – 7 хоногт 1000 орчим км-т аялна. Энд Хархираа, Түргэн, Ямаат, Цагаан шувуут, Атар уулсаар фото аялал зохиож, ирвэсний хаяг, аргаль янгир үзүүлэх сонирхолтой адал явдлын маршрут ч байж болно.

в) Хяргас – Айрагийн хоолойн чиглэлд:

Хяргас нуурын дэргэдэх Хар тэрмисийн рашаан сувиллын газар, олон өнгөт элсэн манхануудыг харах, Айрагийн хоолойд нүүдлийн аяны гэрт амарч, нүүдэлчин ардын ахуй соёлтой танилцах, загас барих, нуурын усанд сэлэх, сэлүүрт завиар аялах, шувуудын цуглаан, хотон шувууг харах зэргээр 3 – 5 хоногт 500 гаруй км-т аялна. Энд Хяргас нуурын зүүн урд талд орших далайн эргийг санагдуулам байгалийн үзэсгэлэнт “Хэцүү хад”-ыг үзэх маршрут байж болно.

г) Говь – Хангайн хослол маршрут

Зүүнговь, Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Малчин, Хяргас сумын нутгаар аялаж, Баян нуур, Өгөөмөр, Алтан бургас, Буштаг, Булганхангай, Баянхайрханы байгалийн онцгой тогтоцтой үзэсгэлэнт газруудыг үзэж, Урт булаг, Хүнх, Гивантын рашаан, эртний сүм дуган, овоо тахилгыг сонирхон харах зэргээр 7 – 10 хоногт 2000 – 2500 км-т аялна.

д) Уулын спорт- аяллын бүс:

Хархираа, Түргэний уулс, Цагаан шувуут, Цагаан дэглийн мөнх цаст өндөр оргилууд уулчин хүний сэтгэлийг өөрийн эрхгүй татна. 3-5 хоногт 200 – 400 км аялна. Ховдын Гоожуурын хүрхрээ, Дамжиг, Олон нуур, Түргэний Живэрт, Төгсбуяантын хүрээ хийдийн туурь, Бөхмөрөний Ямаат зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг үзэж болно.

е) Ангийн отгууд бүхий бүс:

Өмнөговь сумын Улиастын шил, Хөх орой, Ховдын Отор, Түргэний Цүнхэг, Шаварт, Сагилийн Цагаан гол, Харгайт, Сагил, Бөхмөрөний нутаг дахь “Гулзат” ОН-ийн

хамгаалалттай газар, Хан-Хөхийн салбар уулс орчноос буга, тэх, угалз, бор гөрөөс, гахай зэрэг, ховор нэн ховор амьтныг тусгай зөвшөөрлөөр агнаж болно. Мөн Увс, Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө, Баян нуурууд, Ховд, Тэс, Боршоо зэрэг голуудаас загас барьж, шувуу агнах маршрут сонгож болно.

ё) Усан аяллын бүс:

Ховд, Тэс, Хархираа, Түргэн зэрэг урсгал сайтай голууд, Увс, Хяргас, Айраг, Дөрөө, Үүрэг, Ачит зэрэг Монголд томоохонд тооцогддог нууруудаар аялах бололцоотой.

ж) Алдарт хүмүүсийн төрсөн нутгаар:

Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Увс нутгийн унаган хүү Ю. Цэдэнбал, Ө. Бадрах нарын төрсөн нутгаар аялж, Давст суманд буй түүний музей, Монголдоо ганцханд тооцогддог чулуун давсны орд, Цахирт хад, Увс нуур доторхи хар модон төгөл, тэрчлэн төр, нийгмийн зүтгэлтэн Ж. Батмөнх, Т. Рагчаа, зууны манлай бөх Х. Баянмөнх зэрэг Монголдоо төдийгүй дэлхийд данстай хүмүүсийн өсөж төрсөн газар нутаг, сурч байсан сургууль зэргийг тусгай маршрутаар үзэж сонирхож болно.

Аймгийн нутагт явагдаж буй аяллын чиглэлүүдээс үзэхэд унаган байгаль, нүүдэлчин малчдын амьдралын хэв маяг, түүнтэй уламжлагдан ирсэн түүх соёлын өвд тулгуурлан, байгальд түшиглэсэн идэвхитэй, тусгай сонирхолын адал явдалт аяллын төрлүүд түлхүү явагдаж байна.

8.2.2.3. Маркетингийн төлөвлөлт

Аялал жуулчлал нь бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож, борлуулах үйл ажиллагаа явуулж байдгаараа үйлдвэрлэлийн шинжтэй. Байгууллага бүрт аялал жуулчлалын улиралд ирэх жуулчдын тоо, бүтцийг тогтоох, зах зээлийн сегментийг сонгох, хэрэглэгчдийн эрэлтийг тодорхойлох, үйлчилгээний чанарыг урьдчилан тогтоох зэрэг шаардлага урган гардаг. Аймгийн хувьд одооноос байгаль орчноо хамгаалах замаар “Хүрээлэн буй орчинд ээлтэй” –гээр аялал жуулчлалыг хөгжүүлэх нь аялал жуулчлалын хөгжлийн алсыг харсан загвар стратеги болж байна.

Увс аймгийн өнөөгийн нөхцөл байдал, аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, нөөц боломжууд, хөгжүүлэхийг зорьж буй бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогуудтай уялдан зорилтот зах зээлийг дараахь байдлаар хэсэгчлэн тэдгээрийн онцлогт тулгуурлан маркетингийн ялгаварт стратегиудыг баримтлана.

Зорилтот зах зээлийн хэсэг - дотоодын жуулчид

Дотоодын аялагчид өөрийн орны үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газруудтай танилцах, амарч зугаалах зэрэг төрөл бүрийн аялалд оролцох хүсэл сонирхолтой байдаг. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд дотоод зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Сүүлийн жилүүдэд дотоодын аялагч амрагчдын тоо эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан, тэдгээрт зориулсан нэгдсэн арга хэмжээг зохион явуулах нь илүү үр дүнтэй. Увс, Хяргас нуур, Урт булагийн рашаан, Хархираа, Цүнхэгийн амралт зэрэг нь дотоодын аялагчдын гол түшиц газар юм. Увс нуур,

Хяргас нуур, Хархираагийн амралт нь аймгийн төдийгүй Ховд аймгийн аялагч амрагчид зуны улиралд олноор зорин ирдэг газар юм.

Увс нуур нь дэлхийн өвд бүртгэгдсэн, улсын тусгай хамгаалалтанд авсан дархан цаазтай монголын хамгийн том нуур. Увс нуурт усанд сэлэх тогтоосон цэгт өдрийн амрагчид ихээр очиж амардаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд багавтар өртөгдсөн ч хог хаягдал нэмэгдэх болсон байна. Хяргас нуур Хар Тэрмисийн амралт рашаанд зуны улиралд амрагчид олноор ирдэг төдийгүй хувиараа гэр бүлээрээ ирж амрагчдын тоо нэмэгдсээр байна.

Иймд Баруун бүс болон Улаанбаатар, хөдөө орон нутаг дахь дотоодын аялагчдад зориулан мэдээлэл түгээх, сурталчилах, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах нь дотоодын аялагчдын тогтвортой үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байна. Цаашдаа Хар Тэрмисийн рашаан сувиллын газрын ажиллах хоногийн тоог нэмэгдүүлж, материаллаг нөхцөл, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Увс нуурын усанд сэлэх, наранд шарах орчныг тохижуулах, нүүдлийн боловсон WC байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх, Улаангом -Увс нуур, Улаангом-Хархираа хооронд хатуу хучилттай зам барих асуудлыг аж ахуйн нэгж, амралт сувиллын газруудтай хамтран шийдвэрлэх шаардлагатай.

Зорилтот зах зээлийн хэсэг - гадаадын жуулчид

Бие даан үүргэвчтэй аялагчид тур операторуудын санал болгосон үйлчилгээнд хамрагдалгүй ямар нэг хатуу төлөвлөсөн аяллын хөтөлбөргүйгээр аялалд оролцдог учраас тэднээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

Харин албан ёсны гэрээтэй багц аялагчдыг татахын тулд жуулчны мэдээллийн төв болон эко гэрт Улаанбаатар хотоос ирэх очих нислэгийн хуваарь, аймаг орон нутаг дахь байрлуулах болон хоол ундааны үйлчилгээний газруудын байршил, үйлчилгээний онцлог, холбоо барих утас, хаяг, Тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, хоноглох, отоглох газрын байрлал, хаанаас морь, тэмээ, машин хөлслөн авч болох, нүүдэлчин айл малчдын нөхөрлөлийн байршил, үйлчилгээний төрөл үнийн санал, аялал жуулчлалын бүсүүдэд аялахад баримтлах зарчим зэрэг мэдээллийг түгээх шаардлагатай. Эко гэр, жуулчны бааз, малчдын нөхөрлөлүүдээр дамжуулан судалгаа санал авч цаашид ямар төрлийн мэдээлэл үйлчилгээ хэрэгтэйг тодорхойлон үйл ажиллагаандаа тусгах нь чухал. Аймгийн вэб хуудас, мэдээллийн төв, товхимол, тараах материал зэрэг мэдээллийн сувгийг ашиглах боломжтой. Аймгийн жуулчны мэдээллийн төвийг Улаанбаатар хот дахь аялал жуулчлалын мэдээллийн “Гийчин” төвийн үйл ажиллагаатай уялдуулах хэрэгтэй.

Тур оператороор үйлчлүүлж Монгол улсад ирж буй жуулчдын дийлэнх хувийг багц аяллын жуулчид эзэлдэг нь судалгаагаар тогтоогдсон. Тус аймагт аялсан олон улсын жуулчдын зах зээлийн хувьд Япон, Германчууд эзлэж байсан бол сүүлийн 2 жил Америк, Англи, Орос жуулчид ихэнх хувийг эзэлж байна. Ирж буй жуулчдын ихэнхи хувь буюу 70-80% нь байгалийн аялал жуулчлал экотуризмыг сонирхдог. Европоос ирж буй жуулчдын дийлэнх нь байгалийн сайханд амрах, аялах, явган аялах, тусгай сонирхолын аялал болох уулын аялагч, спорт аялагч, анчин жуулчин, шувуу сонирхогч зэрэг

аяллуудыг сонирхон ирж байхад Азийн жуулчид тэр дундаа Япончууд чулуун давсны орд Шүдэн уулыг үзэх, чацаргана тарих арга технологитой танилцах, цаашид хамтран ажиллах зорилготой ирж байсан нь судалгаагаар тогтоогдсон. Иймд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тур операторуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, нутгийн иргэдэд түшиглэсэн хэлбэрээр зохион байгуулах стратегийг баримтлах нь зүйтэй юм. Дэлхийн өв болсон байгалийн үзэсгэлэн бүхий, ховор нэн ховор амьтдын өлгий нутгаар идэвхитэй эко аяллыг нутгийн иргэдэд түшиглэн тур операторуудын хамтын дэмжлэгтэйгээр бий болгож, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх стратеги барьж ажиллах боломжтой. Цаашдаа улсын чанартай үзэсгэлэн яармаг, уулзалт ярилцлагад тогтмол оролцон аяллын тухай мэдээлэл өгч ажиллах арга нь үр дүнтэй юм.

Жуулчны үйлчилгээг сайжруулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлж чадавхижуулахад тур операторууд, аялал жуулчлалын төрийн бус байгууллага, гадаадын төсөл хөтөлбөрүүд, сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр орон нутаг дахь жуулчны үйлчилгээг хүргэгчдийг бэлтгэх, сургах, чадваржуулах улмаар үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай.

Увс аймгийн хувьд аялал жуулчлалын маркетингийн үйл ажиллагаа нь *дотоодын жуулчдад* хүрээлэн буй орчинд эерэг, зохион байгуулалттай амралт, идэвхитэй аяллыг таниулахад чиглэгдэх бол *Гадаадын жуулчдад* Увс аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийн талаарх мэдээлэл түгээх, аялал жуулчлалын бүсийн ялгавартай бодлого баримтлах, сурталчилахад чиглэгдэнэ.

Маркетингийн стратеги:

Аялал жуулчлалын зорих газрууд нь өөрчлөгдөн байгаа эрэлт хэрэгцээ, шаардлагуудыг соргогоор мэдэрч, маркетингийн үйл ажиллагаагаа шинэчилж байх хэрэгтэй байдаг. Аяллын явц, бүтээгдэхүүн, тээвэр, байршуулах зэрэг үйлчилгээний багцуудыг санал болгох зэрэг нь хэдийгээр салангид үйл ажиллагаа мэт боловч бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетингийн хувьд цогц асуудал болно.

Увс аймгийн аялал жуулчлалын бүсүүд өөр өөрийн гэсэн онцлогт тулгуурласан ялгавартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох нь зүйтэй.

Стратеги:

1. Бусад бүс нутгуудаас ялгарах имиджийг тодорхойлох
2. Аялал жуулчлалын өөрийн нэрийн бүтээгдэхүүн шинээр гаргах, үйлдвэрлэх
3. Бүсийн онцлогт нийцүүлэн, янз бүрийн эвентүүдийг зохион байгуулах
4. Мэдээллээр хангах, түгээх
5. Тээврийн хэрэгсэл, байршуулах газрын стандартыг мөрдөх
6. Аялал жуулчлалынын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтарсан маркетингийн идэвхижүүлэлт хийх
7. Нэг жуулчнаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх /үнийг нэмэх бус бүтээгдэхүүний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогыг өсгөх/
8. Хууль эрх зүйн орчныг сайжруулах

9. Байгаль хамгаалал: Үүнд:

- Байгаль орчны хувьд эмзэг, ховордсон зүйлийг тодорхойлж, газрын зурагт байрлуулах
- Аялал жуулчлалд зориулж байгаль орчныг хамгаалах хөтөлбөр гаргах
- Мэдээллийн самбар, хог хаягдлын менежментийг бий болгох
- Аялал жуулчлалынын үйл ажиллагаа явуулж буй компани, хувь хүн, сонирхогч талуудад мэдээлэл түгээх, байгаль орчныг хамгаалах талаар чадавхижуулах
- Байгаль орчинд ээлтэй бизнесийг сертификатжуулах, Жишээ нь: Ногоон hotel, ногоон гэрүүд, ногоон хот айл, цэцэгсийн мөр, мөөгний зам, Рашааны зам... г.м.
- Байгаль хамгаалах ерөнхий компаниг үйл ажиллагааг өргөжүүлэх, Жишээ нь: байгаль орчныг хамгаалах талаар календарь гаргах, байгаль орчныг хамгаалах жижиг төсөл боловсруулах

Судалгаа: Үүнд:

- Байгалийн нөөцийн суурь судалгаа
- Эдийн засгийн тоо баримт
- Зах зээлийн судалгаа хийж, дүгнэлт санал боловсруулах
- Мэдээллийн сан байгуулах
- Мэдээллээ түгээх

Чанартай үйлчилгээ үзүүлж, стандартыг мөрдөх замаар дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээг бий болгох стратеги:

- Жуулчны аюулгүй байдал, даатгал
- Ур чадварыг нэмэгдүүлэх
- Үйлчилгээний чанар
- Хувь хүний хандлага
- Цэвэр орчин
- Харилцаа холбоо авч чадах байдал /интернет, гар утас г.м/
- Жуулчин юу хүсэж байгааг мэдэх
- Чанартай бүтээгдэхүүн санал болгох

Тогтвортой байдал: Ирээдүйд тогтвортой хөгжүүлэх, хэрэглэхийн тулд нөөцөө хамгаалах, хадгалах, тогтвортой амьжиргааг дэмжих стратеги:

- Бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын дагаж мөрдөх зөвлөмж журам боловсруулах
- Ховор ан амьтдын өлгий нутгийн бүсэд дагаж мөрдөх аялал жуулчлалын эко стандартыг боловсруулах
- Жуулчдын хувьд ёс зүйтэй байх /хариуцлагатай/ нөхцлийг бүрдүүлэх
- Иргэдийн боловсрол /Аялал жуулчлал, байгаль экологи, соёлын өвийн үнэ цэнэ/
- Төрийн болон хувийн олон нийтийн байгууллага, ард иргэдийн үүрэг, олон нийтийн оролцоог хангах

Аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлогт нийцүүлэн бусдаас ялгагдах бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгохдоо дараах стратегийг баримтална.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаа:

- Зах зээлийн судалгаа хийх /гадаад, дотоод/
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Бүтээгдэхүүнийхээ талаар мэдээлэл түгээх сурталчилах:

1. Уриа, лого имидж бүрдүүлэх
2. Танилцуулга, брошур гаргах
3. Үзэсгэлэн яармагт оролцох

Сувинер бий болгох /орон нутгийн онцлог төрхийг илэрхийлсэн тухайлбал: модон бал, балны тавиурыг давсаар хийх, ирвэсийн зураг бүхий эсгий, ирвэсийн зурагтай цамц, богино өмд, малгай хийх, эсгий шаахай, гэр, ан амьтдын дүрсийг давсаар урлах... г.м /

Аймгийн жуулчны мэдээллийн төвийг байгуулах нь :

1. Аймгийн аялалын үйл ажиллагааг сурталчилах
2. Аймгийн иргэд болон гадаад, дотоодын аялагчдыг мэдээллээр хангах
3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах
4. Жуулчны статистик тоо баримттай болох
5. Байгаль хамгаалах талаар мэдлэг түгээх, сурталчилах
6. Бие даан аялагчдад үйлчилгээ, бүтээгдэхүүнийг санал болгох, танилцуулах, мэдээлэл түгээх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

Аймгийн аялал жуулчлалын веб хуудсыг Увс аймгийн болон Соёл, спорт аялал жуулчлалын яам, Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын аялал жуулчлалын салбарын гол веб сайтад холбох шаардлагатай юм.

Аймгийн аялал жуулчлалын имидж буюу “**лого**”-г бий болгох нь ихээхэн чухал. Имидж нь аймгийн аялал жуулчлалын өвөрмөц онцлогийг тодорхойлж бусдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээний давуу талыг харуулна.

Имиджийг бүрдүүлэхдээ:

- Уламжлалт дүр төрхийг сэргээх
- Соёлын өвийг хадгалах
- Шинэ дүр төрхийг олж нээх гэсэн 3 хүчин зүйлийг нягт уялдуулах шаардлагатай.

Увс аймгийн үндсэн имидж :

1. Дэлхийн өвд бүртгэгдсэн нутаг дэвсгэр
2. Дэлхийн хамгийн хойд захын элс
3. Дэлхийд ховордсон ирвэсийн өлгий нутаг
4. Монголын 9 гайхамшгийн нэг - Увс нуурын экзотик, давтагдашгүй төрх байдал
5. Түүх соёлын дурсгал
6. Бий биелгээ, ардын ёс заншил
7. Жамц давс, арвайн гурил
8. Чацаргана
9. Тэсгим хүйтнийг мэдрэх ... г.м нэгэнт бүрдсэн давтагдашгүй онцлог, имидж дээр тулгуурлан, шинэ өнгө аясыг мэдрүүлсэн маркетингийн идэвхижүүлэлтийг бий болгох бололцоотой.

Увс аймгийн хувьд дараах эвент арга хэмжээг зохион байгуулах боломжтой:

- Ардын язгуур урлагийн бэсрэг наадам
- Олон ястны хурим найрын ёслол
- Монгол гэр барих, буулгах, үйлдвэрлэх ажиллагаа
- Нүүдэлчдийн хотхон байгуулах
- Бий биелэгээний их наадам
- Овоо тахилгын бэсрэг наадам

- Уран бугуйлчдын бүс, улсын уралдаан
- Бух ноолдаан
- Увс нуурын ханш нээх баяр
- Чацаргана хураалтын баяр
- Цасны баяр
- Эсгий хийх, мал хяргах уралдаан
- Цагаан идээ боловсруулах, арвайн гурил хийх үзүүлэх сургууль
- Морин пологийн тэмцээн
- Сарлагийн пологийн тэмцээн
- Сарлагаар нүүдэл хийх
- Тэмээн нүүдэл
- Увс, Хяргас нуурын элсэн дээрхи спортын тэмцээн
- Увс нууранд усан спорт аялал хөгжүүлэх

8.2.2.4. Увс аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн цаашдын хандлага

Увс аймгийн 2020 он хүртэлх жуулчдын тоог урьд жилүүдийн өсөлтийн хувь хэмжээ болон хүлээн авах зорилгод тулгуурлан 2 хувилбараар тооцоолон гаргалаа. Үүнд:

Хувилбар А: 2005 оноос хойшхи жуулчдын тооны өсөлт аажим байгаа учраас 2013-2016 оны өсөлтийг аажимаар нэмэгдэнэ гэж үзэж тооцоолоход 2020 он гэхэд 10,007 мян орчим жуулчид хүрэлцэн ирэх прогноз гарч байна. 2013 онд жуулчны бааз-4, амралтын газар 3, рашаан сувилалын газар 2 нийт хүчин чадал нь 570 ор бүхий ажиллаж байсан бол 2020 онд уг хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай болно гэсэн тооцоо гарч байна.

Хүснэгт №8.6. Жуулчны тоо: Хувилбар А

Жуулчны тоо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Нийт жуулчны тоо А	5,050.5	5,353.6	5,781.9	6,360.1	7,123.3	7,978.1	8,935.4	10,007.7	56,590.4
Өсөлтийн таамаглал	4.0%	6.0%	8.0%	10.0%	12.0%	12.0%	12.0%	12.0%	72.0%

Хувилбар Б: 2016 онд 1 сая орон нутагт жуулчин хүлээн авах зорилгод хүрэхийн тулд 2013 оноос эхлэн аялал жуулчлалын салбарт шинэчлэл хийж, 2015, 2016 онуудад тус бүр 30%, 37% өсөлт бий болгож байж хүрэхээр байна. 2020 онд 16056 жуулчин хүлээн авах прогноз гарч байгаа бөгөөд жуулчны үйлчилгээний байгууллагын хүчин чадлыг 2013 оныхоос 3,2 дахин нэмэгдүүлэх шаардлагатай болно.

Хүснэгт №8.7. Жуулчны тоо: Хувилбар Б

Жуулчны тоо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт I
Нийт жуулчны тоо А	5,099.1	5,711.0	7,424.3	10,204.1	11,428.6	12,800.0	14,336.0	16,056.3	83,059.4
Өсөлтийн таамаглал	5.0%	12%	30%	37,4%	12%	12%	12%	12%	127,4%

8.2.2.4. Увс аймгийн аялал жуулчлалын хөгжүүлэх төлөвлөлт

Үндэслэл : Монгол орны баруун бүсэд унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай говь цөл хосолсон үзэсгэлэнт байгаль, олон ястны өвөрмөц ахуй, зан үйл, түүх соёлын эртний дурсгалууд, зэрэг дотоод гадаадын жуулчдыг татах ихээхэн нөөц боломж байна. Мөн 1997 онд Увс нуурын ай савын Дархан цаазтай газрыг дэлхийн шим

мандлын нөөц газар, Улаангом хотын дэргэдэх Чандмань уулын археологийн олдвор нь эртний түүх соёлын нандин өвд зүй ёсоор тооцогддог. Зэгс хулсан шагшуурга дунд завиар аялах, ховор жигүүртэн шувууд болон усны амьтдыг үзэх, загасчлах чиглэлээр Увс нуур, мөн Хар-ус нуурын өмнөд эргээр аялал жуулчлалын бааз байгуулах нөөц байна.

Увс аймгийн Цагаан шувуут, Хархираа, Түргэний уулс зэрэг өндөр уулсад уулын спорт, Тэс, Түргэн, Хархираа, Хангилцаг зэрэг түргэн урсгалт голуудаар усан спортын аяллын төрлийг хөгжүүлэх боломж байна. Увс аймагт байгалийн болон тусгай сонирхолын аялал жуулчлалыг үндсэн болон туслах маршрутаар хөгжүүлж, эдийн засагт мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг салбар болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Богино хугацааны төлөвлөлт / 2014он-2016 он /

Зорилго: Аймгийн аялал жуулчлалын салбарын бүтэц, зохион байгуулалт, маркетингийг сайжруулах, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудын материаллаг хангамж, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх,

- Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн нүүдэлчдийн зан үйлийг сонирхуулах, эмнэг сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулж, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах\
- Байгаль орчинд хоргүй, орчин үеийн эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс дотоодын амрагчдыг хүлээн авч байгаа Увс нуурын ай сав дахь Хархираагийн амралт, Хяргас нуурын хөвөөн дэхь Хар тэрмисийн рашаан сувилалын газарзэрэг амралт сувилалын газруудыг тохижуулж, хүчин чадлыг бүрэн ашиглах, нөхцөл бүрдүүлэх
- Түүх соёлын дурсгал болон байгалийн үзэсгэлэнт газруудыг бүртгэлжүүлж, аялал жуулчлал, үзмэрийн зориулалтын нөхцөл бүрдүүлэх
- Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулан дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх
- Аялал жуулчлалын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн стандартыг хангасан зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, эко гэр байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, боловсон хүчнийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах
- Жуулчны бааз, амралт сувиллын газрууд аймаг орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажилладаг нөхцөл бүрдүүлэх
- Аялал жуулчлалыг нөөцөд нь тулгуурлан бүс нутгаар хөгжүүлэхэд анхаарах Үүнд: Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг (Тариалан, Сагил, Давст, Түргэн, Улаангом) сумдын нутагт ерөнхий ба тусгай сонирхолын аяллыг түлхүү хөгжүүлэх

Дунд хугацааны төлөвлөлт/ 2017он -2021он /

Зорилго : Увс аймагт аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлнэ.

- Увс нуурын орчимд байгуулсан аялал жуулчлалын цогцолборыг загвар бааз болгон хөгжүүлэх
- Аймгийн болон баруун бүс нутгийн хэмжээнд зохион байгуулж буй аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг хувийн хэвшлийнхэнтэй хамтран зохион байгуулах
- Аялал жуулчлалын чиглэлээр гадаадын сонирхогч компани хөрөнгө оруулалтыг татан оруулах арга хэмжээг зохион байгуулах
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын сүлжээнд мэдээллийн сүлжээнд оруулж, зах зээлийн сурталчилгааг оновчтой хийх
- Гадаад, дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэн, яармагт оролцох, аймаг орон нутгаа сурталчлах ажлыг идэвхижүүлэх
- Аялал жуулчлалын бааз ангийн отог зоогийн газрын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг төрөлжсөн сургалтанд хамруулан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх
- Чанадманы уулын булш буюу Чандманы соёл хэмээн түүхэн бүлэг дурсгал, Цагаан шувуут, Цагаан дэглий, хархираа Түргэний уулсын чиглэлээр аяллын маршрут гарган тусгай сонирхолын аяллын төрлүүдийг түлхүү хөгжүүлэх
- Эртний Түрэг-Монголын хүн чулуунууд, онгон дагшин байгалиа ашиглан дархан цаазат газрын бүс, говь хангайн хосолмол маршрут, уулын аяллын бүс, ангийн отго бүхий бүсүүдээр төрөлжүүлэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх,
- Аялал жуулчлалыг нөөцөд нь тулгуурлан бүс нутгаар хөгжүүлэхэд анхаарах Үүнд: Аялал рекреацийн чадавхиар дунд бүс нутаг (Ховд, Цагаан хайрхан, Баруун туруун, Бөхмөрөн, Малчин, Хяргас, Наранбулаг, Өндөрхангай сумдын нутагт тусгай сонирхолын аяллын төрөл болох спорт ангийн аялал жуулчлал, усан, шувуу ажиглах аяллыг түлхүү хөгжүүлэх

Урт хугацааны төлөвлөлт/ 2022он -2030 он /

Зорилго : Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох.

- Дотоод гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчны бааз, дэн буудлын сүлжээ байгуулах
- Хөрш улс орнуудтай хил дамнасан олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Аялал жуулчлалд хөрөнгө оруулах дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих, жуулчдад хандсан сурталчилгааг өргөтгөх
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан аялал жуулчлалаас олох орлогоос орон нутгийн ард иргэдийн амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг авах
- Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, олон улсын нисэх онгоцны буудалтай болох
- Ногоон эдийн засаг, ногоон аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүж буй сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах

- Увс нуурын орчимд аялал жуулчлалын цогцолбор байгуулан аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

9.1. Уул уурхайн газрын ашиглалтын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ

Тус аймаг нь алт, зэс, ховор металл, гоёл чимэглэлийн чулуу, шатах малтмалын хувьд ирээдүйтэй тул цаашид хийх судалгааг дээрх ашигт малтмалуудад хандуулж явуулах шаардлагатай.

Увс аймагт 2014 оны 5 сарын байдлаар 24 аж ахуй нэгжийн ашиглалтын 40 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Үүнээс 3 холимог металлын, 14 нүүрсний, 16 алтны, ховор металлын 1, давсны 4, барилгын материалын 2 уурхай байна.

Хүснэгт №9.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын төрөл

Д/д	Ашигт малтмалын төрөл	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
1	Алт	16	8
2	Барилгын материал	2	2
3	Төмөр	3	3
4	Давс	4	4
5	Холимог металл	1	1
6	Нүүрс	14	9

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд 2013 онд улс, орон нутгийн төсөвт оруулсан орлогын хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №9.2. Уул уурхайн салбараас төсөвт оруулсан орлогын хэмжээ

Аж ахуйн нэгжийн нэр	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, сая төг	Нийт улсын төсөвт оруулсан орлого, сая төг
Хартарвагатай ХХК	37.5	275.4
Хотгор ХХК	59.1	472.9
Эрчим ХХК	8.4	57.42

Хүснэгт №9.3. Увс аймгийн хэмжээнд 2013 онд үйлдвэрлэсэн уул уурхайн бүтээгдэхүүн гаргалт

Аж ахуйн нэгжийн нэр	Хөрс хуулалт, мян.м3	Хүдэр олборлолт / бүтээгдэхүүн гаргалт, мян.тн
Хартарвагатай ХХК	35.0	83.9
Хотгор ХХК	441.3	93.54
Эрчим ХХК	30.0	24.0

Хүснэгт №9.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээ

Увс аймгийн хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээ		
Нийт хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо	ААН	Эзлэх талбайн хэмжээ (га)
48	34	294251,09

9.2. Уул уурхайн газрын ашиглалтын хэтийн төлөвлөгөө

9.2.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Увс аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг авч үзвэл тус аймгийн Тариалан сумын нутагт орших Хартарвагатай ХХК нь Увс аймгийн төвийн дулааны станц болон аймгийн төвийн болон сумдын нүүрсний ахуйн хэрэгцээг ханган ажиллаж байна. Харин Бөхмөрөн сумын нутагт орших Нүүрст хотгорын нүүрсний ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Хотгор ХК, Эрчим ХК нь Баян-Өлгий аймгийн төвийн болон сумдын нүүрсний хэрэгцээг хангахаас гадна тус ордод ойролцоо орших Увс аймгийн сумдын нүүрсний хэрэгцээг ханган ажиллаж байна. Бөхмөрөнгийн дулааны цахилгаан станц нь хүчин чадал багатай, тухайн газар нутгийн ахуйн хэрэглээний эрчим хүчээр хангахад чиглэгдэн ажилладаг, Хар тарвагатай /нөөц 25,7 сая тн/-н, Нүүрст хотгор /нөөц 143,3 сая тн/-ын зэрэг нөөц нь тогтоогдсон нүүрсний уурхайнуудыг түшиглэн дулааны цахилгаан станц барих боломжтой.

Наранбулаг сумын нутаг дахь Харганатын төмрийн хүдрийн уурхайгаас гарах бүтээгдэхүүнийг Хөшөөтийн уурхайн коксжих нүүрстэй боловсруулан эхний ээлжинд металлургийн үйлдвэрийн түүхий эд үйлдвэрлэх боломжтой. Шүдэн уулын давсны орд нь бүс нутгийн хэмжээнд ач холбогдолгүй орон нутгийн уурхай юм.

Цаашид эдгээр компаниуд нь одоогийн хэрэгцээг бүрэн хангахаас гадна нэмэлт хэрэгцээг хангах боломжтой. Ялангуяа Бөхмөрөн сумын нутагт орших Нүүрст хотгорын нүүрсний ордыг түшиглүүлэн цахилгаан станц барьж одоогийн Оросын Холбооны улсаас импортоор авч байгаа цахилгааны хэрэгцээг хангах түүнчлэн илүүдэл цахилгааныг Оросын Холбооны улсад экспортлох боломжтой. Мөн уг ордоос ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Хотгор” ХК, “Хотгор шанага” ХХК, “Эм Си Жи Ти” ХХК, “Эрчим” ХХК нь Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотоор дамжуулан 450 км автозамаар тээвэрлэн Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутагт орших Даянгийн боомтоор Хятад улсад экспортлох боломжтой. Энэ тохиолдолд дээрх 450 км автозамыг хатуу хучилттай болгох шаардлагатай. Нүүрст хотгорын нүүрсний ордын “Хотгор” ХК-д ноогдох нөөц 11.8 сая тонн, “Хотгор шанага” ХХК-ийн нөөц 472.7 сая тонн, “Эм Си Жи Ти” ХХК-д ноогдох нөөц 404.2 сая тонн, “Эрчим” ХХК-д ноогдох нөөц 10.4 сая тонн байна.

Хүснэгт №9.5. Увс аймаг дахь нүүрс олборлогч аж ахуйн нэгжийн судалгаа

Д/д	Нүүрсний уурхай, ордын нэр	Аж ахуйн нэгж, компанийн нэр	Байршил	Уурхайн ундны усан хангамж	Цахилгаан хангамж	Нүүрс буталж ангилах, баяжуулах, угаах үйлдвэр	Дэд бүтэц
1	Нүүрст хотгор	"Хотгор" ХХК	Увс, Бөхмөрөн -60 км	Уурхайгаас 8 км, Ямаатын голоос хангадаг.	Дизель: ДГ-30кВт, ДГ-100кВт, Бөхмөрөн сумаас 2011 онд 10кВ-ын ЦДАШ-д холбогдсон.	356000.0 тн хуримтлагдсан нүүрсийг ангилан ялгах шигшүүрийн тоног төхөөрөмжийг БНХАУ-аас захиалсан. Суурилуулж ашиглана.	Бөхмөрөн сумын төвтэй шороон замаар холбогдсон, Эрчим хүчний системд холбогдсон.

2	Нүүрст хотгор	"Хотгор" ХХК	Увс, Бөхмөрөн -60 км	Ямаат болон Байрамын гол	Дизель: ДГ- 30кВт, ДГ- 100кВт	356000.0 тн хуримтлагдсан нүүрсийг ангилан ялгах шигшүүрийн тоног төхөөрөмжийг БНХАУ-аас захиалсан. Суурилуулж ашиглана.	Бөхмөрөн сумын төвтэй шороон замаар холбогдсон, Эрчим хүчний системд холбогдсон.
3	Нүүрст хотгор-Хотгор	"Хотгор шанага" ХХК	Увс, Бөхмөрөн -60 км	Гүний худаг, Ямаат гол	Цагаан нуур- Хотгорын 10кВ-ийн ЦДАШ-аас 5 км шугам татаж холбосон. Дизель станц 2 ширхэг, ДС- 100, ДС-1500		Аймаг, сумын төвтэй шороон замаар холбогдсон. Эрчим хүчний системд холбогдсон.
4	Нүүрст хотгор, I давхарга	"Эрчим" ХК	Увс, Бөхмөрөн		Дизель		
5	Хар тарвагатай	"Хартарвагатай" ХК	Увс, Тариалан, Улаангом оос баруун урагш 90км-т	Бургастайн гол, горхи	Дизель станц 2 ш-ДЭС-60, АД-100	Нүүрсийг 30мм-ээс их, бага фракцаар ангилан ялгах төхөөрөмж ашиглаж эхэлсэн.	Монгол улсын босоо тэнхлэгийн Ярант, Ховд, Улаангом, Хандгайтын автозам дайран өнгөрдөг. Увс аймаг нь ОХУ-аас эрчим хүчээр хангагддаг.
6	Хөөтийн тал	"Хүдэн" ХХК	Увс, Давстаас баруун тийш 42 км, Сагилаас зүүн хойш 37 км	Боржоон гол баруун зүгт 20км зайтай, Хар мод гол зүүн зүгт 13 км зайд байна.	ТЭЗҮ-д тусгагдсанаар, дизель үүсгүүр, ЭХ- ний шугамд холбогдох боломжтой		Ордоос 6 км-т Улаангом- Хандгайтын хатуу хучилттай засмал зам, 2.5км-т Өндөр хүчдэлийн ЦДАШ-тай.

Хүснэгт №9.6-д ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд заасан хүчин чадлыг оруулсан боловч цаашид нүүрс экспортлох, цахилгаан станцад нүүрс нийлүүлэх тохиолдолд хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой.

Увс аймгийн нутаг дэвсгэрт нөөц нь тогтоогдсон ашиглахад бэлэн болсон орд бол Наранбулаг сумын нутагт орших Харганат, Цагаанхайрхан сумын нутагт орших Төмөрчулуутын төмрийн хүдрийн орд юм. Эдгээр ордуудыг ашиглахад зам тээврийн дэд бүтцийг бүрдүүлэх шаардлагатай. Мөн аль болох нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зам тээврийн зардлыг хэмнэх, бүтээгдэхүүний үнэ ханшийг нэмэгдүүлэх боломжтой.

9.2.2. Шинээр ашиглалтад орох боломжтой уурхай

Тус аймгийн нутаг дэвсгэрт алтны 16, ховор металлын 1, төмрийн хүдрийн 3, давсны 4, барилгын материалын 2 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Алтны тусгай

зөвшөөрлийн хувьд нөөц нь хомсдож байгаа тул цаашид тус аймагт даацтай үйл ажиллагаа явуулах боломжгүй. Харин үүсмэл ордыг ашиглах, нөөц нэмэгдүүлсэн тохиолдолд бага хэмжээний олборлолтын үйл ажиллагаа явуулах боломжтой. Алтны олборлолтын үйл ажиллагаа явуулахад бүтээгдэхүүний зам тээврийн дэд бүтэц шаардагдахгүй тул үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учрахгүй. Наранбулаг сумын нутагт орших Харганат, Цагаанхайрхан сумын нутагт орших Төмөрчулуутын төмрийн хүдрийн ордыг ашиглалтад оруулахад бэлэн болсон боловч бүтээгдэхүүний зам, тээврийн дэд бүтэц бүрдээгүйгээс ашиглалтад оруулахад хүндрэлтэй. Барилгын материалын түүхий эд болох шаврын уурхайг ашиглалтад оруулж тоосго үйлдвэрлэх боломжтой тул ойрын 5 жилд ашиглалтад оруулах боломжтой. Нүүрсний Явар, Хүдэн зэрэг жижиг ордууд байгаа боловч бас л дэд бүтэц бүрдээгүйгээс ашиглалтад оруулах боломжтой. Хэрэв эдгээр ордуудыг ашиглавал нүүрсийг гүн боловсруулвал илүү үр ашигтай байж болох талтай.

9.2.3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

Увс аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг авч үзвэл 2014 онд 2, 2015 онд 10, 2016 онд 4, 2017 онд 17 тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаар байна. Энэ оны 7-р сарын 1-нд батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг дахин 3 жилээр сунгагдах боломжтой. Хайгуулын тусгай зөвшөөрлийг 2010 оны 6-р сараас хойш олгоогүй тул хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжих боломж 4 жил бүрдэхгүй байхаар байна. Дээрх тусгай зөвшөөрлүүдээс 3 тусгай зөвшөөрөл эзэмшигч ашиглалтын өмнөх гэрээ байгуулсан тул шууд ашиглалтын тусгай зөвшөөрөл авна. Мөн хайгуулын ажлын үр дүнгээс хамаарч 4-5 хайгуулын тусгай зөвшөөрөл ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломжтой байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9.6. Хайгуулийн тусгай зөвшөөрлүүдийн ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломж

Үзүүлэлт	2015-2016	2017-2018	2019-2020	2020-2024
Хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болох боломжтой тусгай зөвшөөрлийн тоо	3	2	3	-

9.2.4. Ашигт малтмалын хайгуул, судалгааны ажлын цаашидын төлөвлөлт

Увс аймгийн нутаг дэвсгэрт нэгэнт зам, тээврийн дэд бүтэц бүрдээгүй тул төмрийн хүдэр, нүүрс, холимог металл зэрэг ашигт малтмалын нөөц тогтоох чиглэлээр хайгуул хийхэд ойрын 10-20 жилдээ ашиггүй. Алт, мөнгө зэрэг үнэт болон ховор металлын үндсэн ордын хайгуулын чиглэлээр хайгуул хийхэд үр ашигтай байж болох талтай. Хайгуулын ажлыг илэрц ихтэй тус аймгийн Тариалан, Өмнөговь, Өлгий, Ховд, Түргэн сумдын нутгийг хамруулан хийх нь үр ашигтай байж болох талтай.

Их нууруудын хотгорын районд газрын тос болон газрын тосны уламжлалт бус эх үүсвэр болох занарын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөц тогтоох ажлыг бүтээгдэхүүн хуваах зарчмаар хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд ажиллах боломжтой.

9.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, судалгааны ажлын цаашдын төлөвлөлт

2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу тухайн аймагт оршиж буй орд илэрцийн хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг дарга олгож, хэрэгжилтэнд нь хяналт тавьж байхаар хуульчлагдсан юм. Зам болон барилгын салбар эрчимжтэй хөгжиж буй энэ үед Увс аймгийн хэмжээнд аж ахуйн эргэлтэнд оруулах боломжтой Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг хүснэгтээр орууллаа.

Барилгын чулуу					
1	Урд бор толгой	49°56'55" 93°18'00"	Бороч уулаас БУ 1.2км-т	Хар саарал өнгөтэй андези-базальт- порфирит	Асар их нөөцтэй бөгөөд ашиглахад зам харилцаа сайн.
2	Улаан дөрөлж	49°43'30" 93°32'25"	Дэмбэрэл Уулаас хойш 2.0км-т	Улаан өнгөтэй, дунд ширхэгтэй боржип	Асар их нөөцтэй бөгөөд ашиглахад зам харилцаа сайн.
3	Шатадын ам	49°44'00" 92°49'30"	Түргэний шовгор уулаас ЗУ 10км-т	Улаан ягаан өнгөтэй, том ширхэгтэй, порфирлог бүтэцтэй боржин	Асар их нөөцтэй бөгөөд ашиглахад зам харилцаа сайн.
4	Халихын булаг	49°45'40" 92°49'00"	Хүрмийн овоогоос ЗХ 10 км-т	Хар өнгөтэй андези- базальт порфирит	Асар их нөөцтэй бөгөөд ашиглахад зам харилцаа сайн.
5	Улаан толгой	49°41'30" 93°37'3"	Хашаат худагаас баруун тийш 8.5км-т	Хар өнгөтэй дунд ширхэгтэй габбро	Асар их нөөцтэй бөгөөд ашиглахад зам харилцаа сайн.
Шохой					
6	Байцаа голын илрэл	49°29'40" 95°19'10"	Зүүн хангай сумаас БХ 22 км-т	2 км урт, 120 м зузаантай шохойн чулууны зузаалаг	Орон нутгийн чанартай ашиглах
Тоосгоны шавар					
7	2-р илрэл	49°34' 18" 90°42'22"	Ховд сумаас БХ 35 км-т	0.5x1,6 км талбайд шаврын хэвтээш тогтоогдсон	Орон нутгийн чанартай

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хөтөлбөрийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хэрэгжүүлэх хугацаа
1	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” УИХ 2008 оны 01 сарын 31, 12-р тогтоол	
2	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	
3	Төрөөс хvнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого 2009 оны 7-р сарын 15	
4	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 39 дүгээр тогтоол	
5	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр УИХ-н тогтоол 2010 оны 06 сарын 25 өдөр	
6	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол	
7	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал УИХ-н 2001 оны 57 дугаар тогтоол	
8	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 45 дугаар тогтоол	
9	Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр /засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 120-р тогтоол/ Шинэчлэлийн засгийн газар, Яамдын үйл ажиллагааны төлөвлөгөө; Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2012-2016 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	2012-2016
10	Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр, /аймгийн ИТХ-н тогтоолоор батлагдсан/	2021 он хүртэл хэрэгжих
11	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1997 оны 255 дугаар тогтоол	1997-2030
12	Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр Засгийн газрын 2005.09.28-ний өдрийн 202 дугаар тогтоол	2006-2015
13	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр Засгийн газрын 2003 оны 207 дугаар тогтоол	2003-2015
14	“Сүү” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2006 оны 239 дүгээр тогтоол	2006-2020
15	Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоол	2001-2020
16	“Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр” Засгийн газрын 2008.07.08 дугаар 288	2008-2016
17	“Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2009.02.04-ний 32 дугаар тогтоол	2009-2016
18	“Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” Засгийн газрын 2009.09.30-ны 299 дүгээр тогтоол	2009-2016
19	“Ариун цэврийн байгууламжийг сайжруулах” хөтөлбөр /Нийтийн бохирын шугам, цооног, бохир усны төрөл бүрийн цэвэрлэх байгууламж/ Засгийн газрын 2006.10.11-ний 246 дугаар тогтоол	2006-2015
20	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр Засгийн газрын 2003.06.24-ний 160 дугаар тогтоол	2003-2015
21	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 103 дугаар тогтоол	1998-2020
22	“Малын чанар сайжруулах” хөтөлбөр. Засгийн газрын 2006.04.26-ны 93 дугаар тогтоол	2006-2015
23	“Малын тэжээл” хөтөлбөр Засгийн газрын 2007.11.07-ны 283 дугаар тогтоол	2008-2015
24	“Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” үндэсний хөтөлбөр УИХ-ын 1997 оны 106 дугаар тогт	2000-2021
25	Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоол	1998-2021
26	Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1996 оны 163 дугаар тогтоол	1996-2016
27	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр УИХ-ын 1998 оны 29 дугаар тогтоол	1998-2015
28	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2003.06.04-ний 141 дүгээр тогтоол	2003-2012
29	Ойн тухай үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоол.	2001-2015
30	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр Засгийн газрын	1999-2015

	1999.02.10-ны 25 дугаар тогтоол	
31	“Чанарын болон байгаль орчны удирдлага /менежмент/-ийг дэмжих үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2002.07.08-ны 146 дугаар тогтоол	2002-2016
32	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2000 оны 120 дугаар тогтоол	2000-2015
33	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2008 оны 267 дугаар тогтоол	2008-2015
34	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2005.03.09-ний 44 дүгээр тогтоол	2005-2025
35	“Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах” хөтөлбөр Засгийн газрын 2006. 12.20-ний 309 дүгээр тогтоол	2010-2015
36	“Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” Засгийн газрын 2008.02.27-ны 71 дүгээр тогтоол	2008-2015
37	“Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр” Засгийн газрын 2008.03.05-ны 84 дүгээр тогтоол	2008-2015
38	“Чацаргана” хөтөлбөр 2010.03.10-ний 60 дугаар тогтоол	2010-2016
39	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2008.02.27-ны 78 дугаар тогтоол	2008-2012
40	Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	2012 он
41	Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө	2011-2021
42	2003 онд батлагдсан УГЗБЕ төлөвлөгөө	2003-2023
43	Баруун бүсийн ГЗБЕ төлөвлөгөө	2010-2020
44	Тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө	2012
45	Монгол улсын статистикийн эмхэтгэл	2013